

# **АГУУЛГА**

“Олон улсын авлигын эсрэг өдөр дэлхий нийтэд хандан хэлсэн үг” Нэгдсэн Үндэстний Байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Бан Кимун Message of the Secretary-General, Ban Ki-moon .....	2
<b>ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ, АРГА ЗҮЙН БҮТЭЭЛ</b> .....	4
Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт: Сэтгүүлчийн ёс зүйн код ба хэвлэлийн консул, Ц.Онон Self regulation of media: Journalist's code of ethics and media consul, Ts.Onon.....	4
“Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого, түүний үр ашгийн байдал”, Ч. Улаан “Mongolian Investment Policy and its effectiveness”, Ch. Ulaan.....	11
“Авлигын эсрэг хуулийн глобальчлал хөгжиж буй орнуудад тус дэм болж байна үү?”, Кевин Е. Дэйвис “Does the Globalization of Anti-corruption Law Help Developing Countries?”, Kevin E. Davis .....	16
“Авлигын эсрэг олон улсын хамтын ажиллагаа, удирдлагыг бэхжүүлэх бага хурал”, Жиовани Галло “Symposium on Strengthening Global Leadership and Cooperation against Corruption”, Giovanni Gallo .....	57
“Ялын бодлогыг шинэчлэх шаардлага, эрүүгийн эрх зүйн реформ”, Д. Баярсайхан “The requirement of Penalty Policy reform, criminal law reform”, D.Bayarsaikhan .....	65
“Авлига ба аюулгүй(тай) байдал”, Транспарэнси интернэшнлийн Ажлын баримт бичиг #04/2008 “Corruption and security”, Transparency International Working paper #04/2008.....	73
<b>СУДАЛГАА</b> .....	85
“Авлигын судалгаа Бодлогод чиглэсэн тандалт” Женс Ч.Андвиг ба Од Хэлге Фжелстад, Ингэ Амундсэн, Тоне Сиссенер, Тина Сорейде “Research on Corruption A policy oriented survey”, Jens Chr. Andvig and Odd-Helge Fjeldstad, Inge Amundsen, Tone Sissener, Tina Soreide .....	85
“Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь”, Ц.Даваадулам “Glossary of concepts and terms in governance”, Ts. Davaadulam .....	97



## ОЛОН УЛСЫН АВЛИГЫН ЭСРЭГ ӨДВР ДЭЛХИЙ НИЙТЭД ХАНДАН ХЭЛСЭН ҮГ

Бан Кимун

Нэгдсэн Үндэстний Байгууллагын  
ерөнхий нарийн бичгийн дарга

### Message of the Secretary-General<sup>1</sup>

Corruption is a threat to development, democracy and stability. It distorts markets, curbs economic growth and discourages foreign investment. It erodes public services and trust in officials. And it contributes to environmental damage and endangers public health by enabling the illegal dumping of hazardous waste and the production and distribution of counterfeit medicines.

The United Nations Convention against Corruption has helped the public sector to make progress in deterring these crimes. Last year, the Convention's States parties, which now number 148, established a peer review mechanism to identify gaps in national anti-corruption laws and practices -- a major breakthrough that can help governments halt bribe-taking and the embezzlement of public funds.

The private sector's contribution is also essential. Corruption acts as a hidden overhead charge that drives up prices and erodes quality without any benefit to producers or consumers. Preventing corruption makes good business sense. Increasingly, investors are factoring not only environmental, social and governance considerations into their decision-making, but sound ethical performance as well.

<sup>1</sup> <http://www.un.org/en/events/anticorruptionday/sgmessages.shtml>

Авлига нь хөгжил, ардчилал ба тогтвортой байдалд заналхийлдэг. Зах зээлийг гажуудуулж, эдийн засгийн өсөлт болон гадаадын хөрөнгө оруулалтад саад болдог. Аюултай хорт үлдэгдлийг хууль бусаар хаях, хуурамч эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахаас болж хүрээлэн буй орчныг бохирдуулж, иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулдаг.

Нэгдсэн Үндэстний Авилгалын эсрэг Конвенци эдгээр гэмт хэргийг тогтоон барихад амжилт олоход төрийн салбарт туслалцаа үзүүлсэн юм. Одоогоор 148 болоод байгаа Конвенцид нэгдсэн оролцогч талууд өнгөрсөн жил авлигатай тэмцэхэд үндэсний хууль тогтоомжийн болон практикт оршиж буй сул талуудыг илрүүлэх харилцан үнэлгээний механизмыг бий болгосон юм. Энэ нь засгийн газруудад хээл хахууль болон олон нийтийн хөрөнгийг шамшигдуулах явдлыг таслан зогсооход туслах юм.

Хувийн салбарын хувь нэмэр ч маш чухал үүрэгтэй. Авлига бол үйлвэрлэгч эсвэл хэрэглэгч нарт ямарч ашиггүйгээр үнийг өстөж чанарыг муутгадаг нуугдмал илүү зардал юм. Авлигаас урьдчилан сэргийлэх нь бизнест таатай байх юм. Хөрөнгө оруулагч нар шийдвэр гаргахдаа зөвхөн хүрээлэн буй орчны, нийгмийн, засаглалын хүчин зүйлийг бус түүнчлэн эдгээр ёс зүйн хэм хэмжээг бодолцдог болсон нь өсөж байна.

Дэлхий дахини бизнесийн удирдагч нарыг би авлигыг буруушаан авлигыг хориглохыг уриалж байна. НҮБ-ын

I call on business leaders worldwide to denounce corruption and to back their words with strict prohibitions against it. They should adopt anti-corruption policies in line with the United Nations Convention and put in place the necessary checks to strengthen integrity and transparency. I also urge corporations to work more closely with the United Nations on this issue. In particular, they should consider joining the UN Global Compact, the world's largest corporate sustainability initiative, which provides participants with tools to fight all forms of corruption, including extortion and bribery.

What we urge upon the public and private sectors, we at the United Nations must practice ourselves. An ethical organizational culture is one of the best antidotes to corruption. The United Nations Ethics Office promotes accountability, integrity and transparency. A thorough policy protects staff against retaliation if they report misconduct or participate in audits and investigations that may expose unethical behaviour.

The United Nations is also working to combat corruption in the conduct of its activities, including procurement, by ensuring individual accountability, collaborating with law enforcement officials, and investigating all possible instances of corruption that may arise. On 8-9 December at UN Headquarters in New York, the UN Office of Internal Oversight Services is bringing together organizations from around the world for a conference aimed at strengthening the role of internal investigations in combating corruption.

On this International Anti-Corruption Day, let us all do our part to foster ethical practices, safeguard trust and ensure no diversion of the precious resources needed for our shared work for development and peace.

Ban Ki-moon

Авиалгалын эсрэг конвенцийн үзэл баримтлалын дагуу тэд авлигын эсрэг бодлого боловсруулан шударга ёс, ил тод байх явдлыг бэхжүүлэхэд шаардлагатай шалгах механизмыг хэрэгжүүлэх ёстай. Би түүнчлэн энэ асуудлаар корпорациудыг НҮБ-тай нягт хамтран ажиллахыг хичээнгүйлэн уриалж байна. Ялангуяа, дэлхийн хамгийн том тогтвортой хамтын санаачлага болох НҮБ-ын Дэлхийн гэрээнд нэгдэх асуудлыг авч үзэх ёстай юм. Энэхүү санаачлага нь оролцогч наарт нэхэж авах, хээл хахууль зэрэг алигын бүх хэлбэртэй тэмцэх хэрэгслийг олгодог юм.

Төрийн болон хувийн салбарт урилан дуудаж байгаа асуудлыг бид өөрсдөө НҮБ хэрэгжүүлсэх ёстай юм. Ёс зүйн зохион байгуулалтын соёл нь авлигын эсрэг сайн жорын нэг юм. НҮБ-ын удирдлагын ёс зүйн нь хариуцлага, үнэнч шударга байдал, ил тод байдлыг дээшлүүлдэг. Албан хаагчид өөрсдөө аудитын шалгалт, мөрдөн шалгах зэрэг ажиллагаанд оролцоход албан тушаал ашиглах нөхцлийн талаар өөрсдөө мэдэгдсэн тохиолдолд албан хаагчдаа хамгаалах нарийн бодлоготой юм.

НҮБ мөн засгийн газрын худалдан авалтын явц дахь авлигын асуудалтай хувийн хариуцлагыг дээшлүүлэх журмаар тэмцэж байна. Түүнчлэн хууль хяналтын байгууллагын албан хаагчидтай хамтран авлига үүсэж болох бүх тохиодлыг шалган ажиллаж байна. Нью-Йорк дахь төв байранд 12 дугаар сарын 8-9-ны өдөр НҮБ-ын Дотоод хяналтын газар дэлхийн олон орны байгууллагуудтай хамтран авлигатай тэмцэхэд дотоод хяналт шалгалтын үүргийг бэхжүүлэх чиглэлээр бага хурал хийв.

Энэхүү олон улсын авлигатай тэмцэх өдөр итгэлийг хангах ёс зүйн хэм хэмжээ бий болгоход өөрсдийн хувь нэмрийг орууля, түүнчлэн хөгжил ба энх тайвны төлөөх бидний хамтын ажиллагаа хөгжил дэвшилд шаардлагатай байгаа маш их үнэ цэнэтэй нөөцийг урсахгүй байгаад итгэлтэй байя.

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ, АРГА ЗҮЙН БҮТЭЭЛ



## ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ: СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙН КОД БА ХЭВЛЭЛИЙН КОНСУЛ

Сэтгүүлч Ч.Онон

2010 оны 11 дүгээр сар 19

“Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин” хэлэлцүүлэг

Өнөөдрийн илтгэлүүдэд эрх зүйн позитивист чиг хандлага буюу хууль зүйн арга хэрэглэж төрөөс хэвлэлийн эрхийн тогтолцоог байгуулах ёстай гэж судлаачдын хувьд үзэж байх шиг байна. Үүнийгээ амьд эрх зүйд үндэслэх, өөрөөр хэлбэл нийгмийн материаллаг ашиг сонирхолтой бүлэглэл, нийгэмлэгээс тогтоосон нийгмийн амьдралыг өөртөө шингээсэн дүрэм журмыг тусгах, хэвлэлийн эрхийг хийсвэр сэтгэхүйгээс бус бодит зүйлээс хайвал үр дунтэй болов уу гэсэн үүднээс дараах санааг нэмэрлэе.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалт гэдэг нь хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсад, редакциудын хамтдаа сайн дураараа баталсан ёс зүйн зарчмыг олон нийтэд нээлттэй мөрдүүлэх мэргэжлийн нийгэмлэг юм. Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх байгууллага нь Хэвлэлийн ёс зүйн зөвлөл юм. Хэвлэлийн зөвлөл нь хэвлэл төдийгүй телевиз радиод ч хамаатай. Хэвлэлийн Консул ч гэж нэрлэдэг энэ сэтгүүлчдийн

мэргэжлийн байгууллага дэлхийн 54 улсад ажилладаг.<sup>1</sup> Хэвлэлийн Консул нь Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдүүлэх, нөгөөтэйгүүр сэтгүүлчдийг хамгаалах, сэтгүүлчийн нэрээр хаягласан гомдлыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх журмаар шийддэг байгууллага билээ.

**Бүгд эрх зүй ярьж байхад яагаад ёс зүй ярьсан бэ?**

Одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөр нийгмийн амьдралд бүх зүйлийг шийдэхгүй гэдэг нь нэгэнт тодорхой болж байна. Эрх зүй хэвлэлийн зөв буруу хандлагуудыг эрэмбэлж хуульчлахыг оролдож байгаа ч ёс суртахуунтай холбоотой нарийн ширийн зүйлсийт тэр бүр бүрэн дүүрэн тусгаж чадахгүй байна. Хууль тогтоомжийн үүрэг нь ёс суртахууны хэм хэмжээг амьдралд

<sup>1</sup> Хэвлэлийн Консулын тухай мэдээллийг [www.media-accountability.org](http://www.media-accountability.org), [www.wanews council.org](http://www.wanews council.org) вэбсайтуудаас үзнэ үү.

албадан хэрэгжүүлэхэд оршдог. Эрх зүйн асуудлыг ёс зүйн оролцоогүй шийдвэрлэх боломж тун бага. Учир нь ёс зүй дээр эрх зүй суурилдаг билээ. Хууль тогтоомжийг дагаж мөрдөх үндэс нь ёс суртахууны шаардлагыг дагаж хангаж биелүүлэх явдал. Ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөх нь эрх зүйн суурь зарчим билээ. Эрх зүйн тавьж хэрэгжүүлж чаддаггүй шаардлагыг ёс зүй тавьж хэрэгжүүлж чаддаг бөгөөд учир нь ёс зүйн үйлчлэх цар хүрээ эрх зүйнхээс өргөн юм.

Шинжлэх ухаан, хууль эрх зүйн аль алиin нь хэлж өгдөггүй зүйл болох хүн ёс суртахууны хувьд ямар байх ёстийг хүнд ухааруулж ойлгуулдаг ухаан нь ёс зүй билээ. Өвөрмөц онцлогтой мэргэжил болох сэтгүүлчийн хувьд ёс зүй нь бусад мэргэжлийн ёс зүйн адил мэргэжлийн ёс суртахууны шаардлагыг тодорхойлж, улмаар мэргэжлийн хүрээнд хэрэгжүүлэх, зарчмыг нь сахиуулж мөрдүүлэх зорилготой. Сэтгүүлчдэд мэргэжлийн ёс суртахууны хэм хэмжээг төлөвшүүлэх, мэргэжилтэн хүний хувьд зан суртахуунд хяналт тавьж зохицуулах, мэргэжлийн ёс зүйн дурмийг сахиуулж мөрдүүлэх үүрэгтэй.

Хуулийг албадан биелүүлж, хуулийн заалтууд хүнийг буруутгах шийтгэхэд чиглэсэн бол ёс суртахууны шаардлагыг сэтгүүлч бүр сайн дураараа, өөрийн хүсэл зоригороо сахин мөрдөж, хэрэгжүүлж хэвшиүүлэх юм. Нийгэм эдийн засагт институци гэсэн ойлголт сүүлийн жилүүдэд маш хүчтэй болж байна. Ёс суртахуун нь албан бус институцийн суурь, яс мод болдог юм байна. Ийм нэг институци нь хэвлэлийн өөрийн зохицуулалт юм.

“Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрөө удирдах ёсны норматив үндэс нь хуульд “найдах” бус харин өөрсдийн тогтоосон олон нийт, заншлын хийгээд ёс зүйн хэм хэмжээ байх учиртай. Хууль

бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн “гадаад” харилцаанд хамаарахаас бус “дотоод” харилцаанд хутгалдан орох ёсгүй. Харин түүнийг өөрсдийн тогтоосон заншил, ёс зүйн гэх “олон нийтийн” хэм хэмжээгээр зохицуулах нь бие даасан байдлаа хангах гол механизм болно” гэж хуульч Б.Чимид гуай нэгэнтээ саналаа хэлж билээ.

Хэвлэлийн өөрийн зохицуулалт бол том бодлого, их орон зайд чанартай сэтгүүл зүйд байх ёстай нэг тогтолцоо бөгөөд манай нийгэмд хундтэй байрандаа байх ёстай ойлголт-сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн зарчим, түүнийг мөрдүүлэх байгууллага, хэвлэлийг хараат бус хариуцлагатай байлагах систем билээ.

### **Өнөөдрийн бодит цнэлгээ: Пиррийн ялалт**

Ингэж ялснаас ялаагүй нь дээр шахуу хэмээх утгатай мэргэн үг манай хэвлэлийн өнөөгийн нехцэлд тохиорохоор байна.<sup>2</sup> Манайд эрхийн төлеө тэмцэгч сэтгүүлчид заримдаа Эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэгтнүүд болчихоод байна. Сонин, телевизийн эсрэг иргэний хэргийн тоо буурахгүй харин ч нэмэгдэх хандлагатай байна. 2007 онд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбогдох иргэний 33 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 70 хувьд нь сэтгүүлч шууд ялагдаж, өндөр албан тушаалтнуудын хэрэг 100 хувь албан тушаалтны талд шийдэгдэж байна.<sup>3</sup> Эрүүгийн хуулийн 111-р зүйлээр дөрөвхөн жилийн дотор 18 хүн ял эдэлсэн судалгаа гарсан. Ганцхан жилийн дотор эрүүгийн хуулийн заалтаас үүдэн 6

2 МЭӨ 280 онд Македоны хаан Пиррийн арми Ромын легионтой хоёр хоног байлдаж ялсан ч маш их хохирол үзсэн тул “Ахиад ингэж нэг ялах юм бол би ганц ч цэрэгтүй хоцорно” гэж Пирр хаан халаглажээ.

3 [www.globeinter.org.mn](http://www.globeinter.org.mn)

сэтгүүлч шүүхийн тогтоол уншуулаад байна.

“Сэтгүүлч бусдын эрх ашгийг хохироожээ. Төлбөрийг нь өөрийнхөө эрх чөлөөгөөр хийж байна. Ардчилсан зарчимд нийцэж байна уу? Нийцэж байна. Цэг”.

Сэтгүүлчид дүүргийн цагдаагийн хэлтэс, дүүргийн шүүхийн үүдэнд оочерлож, сэтгүүлчийн мэргэжлийн үнэ цэнэ, хэвлэл мэдээллийн нэр хүндийг олон нийтээс асуухад ичмээр дор байгаа нь МХХ-ийн судалгаанаас илэрхий байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг төрийн заналхийллээс хамгаалах шалгарсан арга нь хэвлэлийн өөрийн зохицуулалт юм. Хэвлэлийн өөрийн зохицуулалт нь үүний зэрэгцээ ёс зүйгүй сэтгүүлчдээс иргэдийг хамгаалж, сэтгүүл зүйн нэр хүндийг аварч, ингэснээр ёс зүйгүй сэтгүүлчдийн үйлдлээр далимдуулан хэвлэлийн хүзүүндэх гогцоог чангалах гэсэн төрийн оролдлогоос урьдчилан сэргийлсэн тогтолцоо билээ. Бид яаж хийж бүтээнсээр манай нийгэм төлөвшдөг. Бид нийгмийн институциудыг хэлбэршүүлж болно.

Сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим, кодыг бид баталсан. Тухайлбал, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Телевизуудийн холбоо, Монголын Чөлөөт Сонинуудын Холбоо, МОНЦАМЭ болон “Ийгл” ТВ-ийн Мэдээллийн алба, “Өнөөдөр” сонин зэрэг эвлэл, холбоо, байгууллагууд өөр өөрийн ёс зүйн дүрмүүдийг баталсан. Харин хэрэгжилтэнд нь хяналт тавьдаг, хариуцлага тооцдог механизм өнөө хэр бүрдээгүй байгаа. Дүрэм журмаа сайн мөрдөж буйг сайшаадаг, алдаа дутагдал гаргасанд хэрхэн хариуцлага тооцож тухай тогтолцоо байхгүй. 2008 оны 4 дүгээр сарын 24-нд МСНЭ-ээс Ёс зүйн

хороо байгуулах талаар хэвлэлийн бага хурал хийсний маргаашаасаа л өдөр тутмын хэвлэлүүдээр баахан хардсан улстөржсөн нийтлэлүүд дагуулсан билээ.

Хэвлэлийн өөрийн зохицуулалт олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжилд хэрэгтэй тухай таван шалтгаан:

1. Редакцийн эрх чөлөөг хангана
2. Төрийн зүгээс саад хийхийг хязгаарлана.
3. Хэвлэл мэдээллийн чанарыг өргөнө
4. Хэвлэл мэдээлэл хариуцлагатай байгааг харуулж нотолно.
5. Уншигч үзэгчдэд хэвлэл мэдээлэлд хүрэх гарам болно.

Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр эрдэм санхүүгийн бяр суужээ. Гэвч хэвлэн нийтлэх эрх чөлөөндөө бие даасан хараат бус эзэн нь байхын тулд хэвлэлийн салбар өдөр бүр тэмцэж байна.

### **Сонгуулийн Хэвлэлийн консулууд**

2004 оны УИХ-ын сонгууль, 2008 оны УИХ, орон нутгийн сонгууль, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Хэвлэлийн түр зөвлөл ажилласан.

Үүний нэг тод жишээ нь 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр сэтгүүлчдийн ёс зүйтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх Хэвлэлийн цэцийг МСНЭ-ийн дэргэд байгуулан ажилласан явдал болов. МСНЭ, “Глоб Интернэшил“ ТББ, Нээлттэй нийгэм Форумын хамтарсан “Чөлөөтэй бөгөөд шударга байх нь“ төслийн хүрээнд энэ цэц ажиллажээ. Хэвлэлийн цэцийн дүрмийг Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Сонинуудын холбоо, Монголын Чөлөөт Сонинуудын Холбооны хамтарсан

бага хурлаар хэлэлцэн баталжээ. Уг “Сонгуулийн үеэр сэтгүүлчдийн баримтлах зарчим”-д “Сонгуулийн тухай мэдээлэхдээ сэтгүүлчид Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Пактын 19-р зүйлийг иш үндэс болгон иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хүндэтгэн үзэж, олон нийтийн эрх ашигт үйлчилж байх эрхэм үүргээ дээдлэхийн хамт “Нотолгоотой баримтад тулгуурласан, тэнцвэртэй мэдээлэл түгээх” зарчмыг баримтлан ажиллана” гэжээ.

### **Шүцхийн альтернатив: Хараат бус байдлыг хамгаалах хувилбар**

Хэвлэл Засгийн газрыг хянах “хоточ нохойн” үүргээ Засгийн газрын зүгээс хамгийн бага хяналттай байж л гүйцэтгэж чадна. Энэ хараат бус байдлыг хамгаалахад өөрийн зохицуулалт зорьж байгаа юм. Сэтгүүлчийн мэргэжлийн алдааг ашиг сонирхлын зөрчилтэй эрх мэдэлтэн биш мэргэжил нэгт нөхөд нь шүүснээр өөрийн зохицуулалт сэтгүүлчийн хараат бус байх эрхийг хамгаалдаг. Цагт хавчигдах, мэдээг баталгаажуулах, мэдээлэлд нэвтрэх эрх дутах, санхүүгийн хангалтгүй эх үүсвэр, уг хэллэгийн ялгаа, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах, технологийн хоцрогдол гээд редакцийн гал тогооны зовлонг зөвхөн мэргэжлийн сэтгүүлчид л ойлгоно.

Тиймээс “чоно цатгалан хонь бүрэн байх хувилбар” буюу шүүхийн альтернатив хувилбар нь хэвлэлийн өөрийн зохицуулалт гэж санал болгож байна. Сэтгүүлч аль нэг дүүргийн цагдаа шүүхийн хаалга сахиж шүүлгэх биш, мэргэжил нэгт нөхдөөсөө бүрдсэн Хэвлэлийн зөвлөлөөр шүүлгэж, хамтын шийдвэрийг сонсох нь шүүхээс ял авснаас дээр билээ. Манай шүүх үнэн мөнийг олдоггүй, зөвхөн гэм буруутай эсэхийг тогтоодгийн адил Хэвлэлийн

зөвлөл нь тухайн нийтлэл бичсэн сурвалжлагчийг сэтгүүлчийн ёс зүйн зарчим зөрчсөн эсэхийг л тогтооно. Товчондоо үүгээрээ сэтгүүлчийг шүүхэд очихоос вакцинжуулж байна.

Хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэргэжлийн ёс зүйн зарчмаа нийтэд зарлаж, дагаж мөрдсөнөөрөө өөртөө хариуцлага үүрч, ингэснээрээ редакцийн бие даасан байдлаа бүрэн хангана гэсэн уг. Үншигч үзэгчид өөрийн үйл ажиллагаанд хариуцлагатай ханддаг сонинд телевизэд илүү итгэдэг билээ. Хэвлэлийн өөрийн зохицуулалтаар дэмжүүлсэн чанартай сэтгүүл зүй нь эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус үйл ажиллагааны нэмэлт баталгаа болох юм.

Эрх чөлөө, хариуцлага нэг зоосны хоёр тал юм

Нялзуунаас шулуун нь дээр. Эрх мэдэл хулээх хариуцлагатайгаа дүйцэх ёстой. Хэвлэлийн эрх чөлөөг өдлэхтэй зэрэгцэж нийгмийн өмнө хүлээх хариуцлага хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонинд оногддог бөгөөд сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ёстойг сэтгүүлчид ойлгодог. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцлага алдвал олон түмний дэмжлэгийг алдаж, улмаар дөрөв дэх засаглал гэж хичнээн чанга хашираад ч үр дүн нь хоосон талд цуурай мэт үлдэнэ. Хэвлэл хүмүүст таалагдаж байж захиалга, сурталчилгааны ашиг их олно. Чухам энэ ашгийн төлөө хэвлэл үнэн зөв, бодитой, тэнцвэртэй, олон эх сурвалжаар баталгаажуулсан, сонирхолтой мэдээллийг түгээнэ. Үүнийг дагаад ёс зүйн асуудал дагалдана. Ёс зүйтэй байж л олон түмний итгэлийг байнга хүлээнэ. “Чөлөөт хэвлэл зөвхөн олон түмнээс, өөрөөр хэлбэл зах зээлээсээ хамааралтай”<sup>4</sup> гэж Б.Баабар хэлжээ.

4 Б.Баабар “Хэвлэлд ээлтэй хүн” 2004.05.03

Сонин хэвлэлийн алдааг тэвчин уучилдаг байсны үр дунд өрнийн чөлөөт хэвлэл өнөөгийн сонгодог утгаар олон төлөвшиж, ардчилал гэдэгтэй аналог болон зөвшөөрөгдсөн юм. Гэхдээ учлал гэдгийг хуулийн хариуцлагаас дархлан чөлөлөх гэдэг шууд утгаар нь бус, харин сэтгүүлчийн алдааг төсвийн мөнгө туусан луйварчны үйлдлээс ялгаатай авч үзсээр ирсэн практик гэж ойлгохыг хүсч байна.

Үгхэлэх эрх чөлөө гэдэг болуузэлбодлоо хамгаалах, бусадтай үл зөвшөөрөлцөх, үл сонсох, эс санхүүжүүлэх, сөрөг хүчин байх, эсвэл нийтийн дэмжлэг авахгүй, нэрд гарахгүй байх гэх мэтийн бүх л үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх эрх чөлөөтэй байна гэсэн үг билээ. Чөлөөтэй үг хэлэх эрхийн улс төрийн үүрэг бол бусдыг дуулгавартай дагадаггүй хүмүүс, хавчигдсан цөөнхийг хүчирхийлэл дарамтаас хамгаалахад оршихоос бус тэднийг дэмжин тэтгэж, илүү нөхцөл олгох, бүтээгдэгүй гавьяаных нь төлөө шан хуртээж, алдаршуулахад оршихгүй.

Сонины газар өөрийнхөө улстөрийн бодлоготой нийцэхгүй материалыг нийтлэхээс татгалзах, уг хүнийг ажилд авахаас татгалзах эрхтэй. Бизнесмэн өөрийг нь шүүмжилдэг, доромжилдог, шавраар буддаг сонинд зар сурталчилгаагаа нийтлүүлэхээс татгалзах эрхтэй. ТВ-ийг ивээн тэтгэгч өөрийнхөө санхүүжүүлдэг нэвтрүүлэгт гарсан бүдүүлэг алдааг шүүмжлэх эрхтэй. Дээрх бүхэн цензур бишээ. Хувь хүний үйл ажиллагаа бол цензор биш. Цензур бол төрөөс хэвлэлийг хянах явдал. Ямар ч хувь хүн бусад хүний амыг барьж, нийтлэлийг нь хориглож чадахгүй. Түүнийг зөвхөн Засгийн газар л чадна.

Өөрсдийн төлөө, өргөн түмний төлөө, хүний төлөө взэл бодлоо өргөн дэлгэр илэрхийлэн дэмжлэг авах замаар төр, засгийн газар, түүний байгууллага,

албан тушаалтуудын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчтэй хэрэглүүр нь хэвлэл мэдээлэл-дөрөв дэх эрх мэдэл. Харин манайхан “засаглал” хэмээн андуурч, төр, түүний байгууллагын нэг хэсэг мэт буюу аанай л бусдыг засагладаг, захирдаг, дэглэдэг хүч хэрэгсэл мэт ойлгуулан тэгснээр ард олноос хөндийрэхэд хургаж болзошгүй байна. Юуны чинь засаглах вэ? Харин засаг төрийг олны мэдээллийн хувцээр л хянаж ариусгах онцгой эрх мэдэл билээ.<sup>5</sup>

Хэвлэлийн ёс зүйн холбогдолтой маргааныг урьдчилан хянан шийдвэрлэдэг хөндлөнгийн механизм болох Хэвлэлийн зөвлөл ийнхүү олон сонирхлын зөрчил дунд дуншиж байна. Хэвлэлийн гутгэлгийн хэргийг шийдвэрлэж байх цоо шинэ чиг хандлагыг тогтоож байна.

### Хэвлэлийн Консул цүннийг яаж хийх вэ?

Хэдийгээр иргэн хүн нэр төрөө сэргээлгэхээр шүүхийн байгууллагад хандах эрх нь нээлттэй боловч ийнхүү шүүхэд нэхэмжлэл гаргахаасаа өмнө Хэвлэлийн Зөвлөлд хандаж, тухайн хувь сэтгүүлч сэтгүүлчийн ёс зүйгээ зөрчсөн эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулан авдаг практик дэлхийн олон оронд бий. Бараг дийлэнх тохиолдолд хэвлэл болон иргэний хооронд үүссэн гутгэлгийн холбогдолтой маргаан нь Хэвлэлийн Зөвлөлийн шийдвэрээр эцэс болж, сонин хэвлэл нь залруулга хэвлэн, училал гүйдаг. Гутаагдсан нэр төр шүүхийн шийдвэрийн дагуу сонины газраас мөнгөн төлбөр гаргуулснаар л сэргэдэг гэж ойлгох нь өрөөсгөл тул энэ асуудал заавал шүүхийн байгууллагаар

5 “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө” Б.Чимид - Монгол Улсын гавьяат хуульч, доктор (Ph.D), профессор. <http://www.globeinter.org.mn/index.php?cmd=Content&id=300&menuid=60>

шийдэгдэг байх албагүй гэсэн санаа үүний цаана байдаг. Хэвлэлийн Зөвлөл аливаа уншигчийн зүгээс гаргасан гомдол, маргааныг хянан үзээд, сэтгүүлч ёс зүйгээ зөрчсөн гэсэн дүгнэлт гаргавал тухайн сонины газар нь анхны ташаа мэдээлэл тараасантай яг адил арга байдлаар залруулга, уччал хэвлэх үүрэгтэй болдог ба тодорхой хэмжээний мөнгөн торгууль төлдөг. Энэ торгууль нь Хэвлэлийн Зөвлөлийн санхүүжилтийн нэг хэсэг болдог. Хэвлэлийн Зөвлөл амжилттай ажиллах нэг гол хүчин зүйл бол хэвлэлийн салбарт ажиллах буй сэтгүүлч, эрхлэгч, хэвлэн нийтлэгчид сэтгүүлчийн ёс зүйн баримт бичгийг даган мөрдөж байхаа батлан, гарын угсгээ зурсан байх явдал юм.<sup>6</sup> Мэргэжлийн эрх мэдлийг мэргэжлийн шударга ёстой нийцүүлж ажиллах, нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа бүрэн дүүрэн ухамсарлана.

Харин хэвлэлийн эсрэг дэгдсэн маргааныг Хэвлэлийн Зөвлөл анхлан шийдвэрлээд түнгээрээ зохицуулж дуусвал сайн хэрэг боловч хэрэв түүний шийдвэрийг нэхэмжлэгч буюу гомдогч эс зөвшөөрвөл шүүхэд хандах эрх нь хэвээр влдэнэ. Энэ бол иргэдийн Үндсэн хуулийн эрх юм.<sup>7</sup> Үүнээс үүдээд шүүхэд Хэвлэлийн зөвлөлийн шийдвэрийг хэрэглэх үү, угүй юу гэсэн асуулт гарч ирнэ.

### **Оновчтой зорилго: Чанартай сэтгүүл зүй**

Товчхондоо сонин бол ялааны алуур биш. Нэг улс төрчийн нөгөөгөө цохих алуур бүр биш. Шударга ёс, ардчиллыг хамгаалдаг институци. Сэтгүүлчдийг шүүх цагдаад хүргэлгүй дархлажуулах, мэргэжлийн мэдлэг чадвар, дадал зүйд хамаарах дүрэм журам, сэтгүүл зүйн стандартыг дагаж

<sup>6</sup> Шар хэвлэлтэй хийх тэмцлийн үйлдлийн дараалал. Д.Гантуг. 2002

<sup>7</sup> Монгол Улсын Үндсэн хууль, 16-14

мердөх, тогтсон хэм хэмжээг практикт хэрэгжүүлэх, мэргэжлийн үнэ цэнэ, хэвлэл мэдээллийн нэр хүндийг өргөх нь Хэвлэлийн зөвлөлийн зорилго билээ. Эрх чөлөө гэдэг бол зөвхөн хариуцлага хүлээх чадвартай хүмүүсийн эрүүл саруул зорилго.

Үүний төлөө сонин, телевизүүдийн эвсэл холбоо, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд эрх ашгаа харж нэгдэж, уг хэлээ ололцож, санхүү босгож, ашиг сонирхлоо, сэтгүүлчдээ хамгаалж чадна гэдэгт итгэж байна. Хэвлэлийн зөвлөлийн амжилт олох зайлшгүй нөхцөл нь Хэвлэлийн зөвлөл нэр хүндтэй байх явдал билээ.

Хэвлэл өөрийгөө зохицуулна гэдэг нь өөрөө илжиг байх, эсхүл илжигтэй байх хоёрын ялгаа юм.

Хэнд та буруугаа тохно, түүнд эрх мэдлээ алдана

Бид улстөрчид, эрх баригчдыг хэтэрхийх буруутгаж, тэрхэмжээгээрээ тэднээс хараат болж байна. Хэвлэлийн зохицуулалтыг эрх зүйгээр зохицуулах гэх нь улстөрчдөд толгойгоо өгсөн хэрэг болж байна. Бид алдаагаа давтахгүй, ололтоосоо ухрахгүй байх ёстой. Би өөрөө амьдралаа төлөвлөнө, эсвэл өөр хүмүүс таны амьдралыг төлөвлөнө. Тиймээс эрх зүйн зохицуулалтаас зайлсхийж, мэргэжлийн ёс зүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрөө өөрийгөө зохицуулахаар оролдоод үзэх нь чухал юм.

2007 онд Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн зөвлөлийн харьцуулсан судалгааг<sup>8</sup> Дани,

<sup>8</sup> Милтон Фрийдман “Хувь заяагаа сонгох нь”, УВ 2001

<sup>9</sup> “Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгаа: Дани, Их Британи, Недерланд, Швед, Босни-Герцеговинагийн Хэвлэлийн Консулын жишиг” Ц.Онон, Нээлттэй Нийгэм Форум, 2007

Их Британи, Недерланд, Швед, Босни-Герциговинагийн Хэвлэлийн Консулын жишээгээр судлаад дараах дүгнэлтэнд хүрсэн:

- Үр дүнтэй ажиллах Хэвлэлийн зөвлөл хэвлэл мэдээллийн эсрэг үүсэх эрүүгийн болон иргэний хэргийг цөөлнө. Шүүхийн өмнөх шатанд сэтгүүлч ба нэхэмжлэгчийг эвлэрүүлэх журмаар хэргийг шийдсэнээр шүүхээр шийтгэгдэх сэтгүүлчдийн тоог цөөлнө.
- Хэвлэлийн зөвлөлийн бүтэц нь хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, эрхлэгч нарын корпорацичлагдсан хольц байна. Хэвлэлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, эрхлэгч нар болон олон нийтийн төлөөллийг ижил тоотой оруулж, шийдвэр гаргах бүрэлдэхүүний тэнцвэрийг хангах нь зүйтэй. Хэвлэлийн зөвлөлийг шүүгчээр даргалуулах нь зүйтэй. Хэвлэлийн зөвлөлийн гишүүн орон тооны бус, харин нарийн бичгийн дарга орон тооны байх нь зүйтэй.
- Хэвлэл мэдээллийн салбар Хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг бүрэн санхүүжүүлж байна.
- Зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг батлах бүтэц тусдаа байх нь санхүүгийн сахилга бат алдагдахаас сэргийлж байна
- Зөвлөлийн үйл ажиллагааны стандартыг нь үнэлэх, ёс зүйн дүрэм шинэчлэх бүтэц нь Консулаас тусдаа байна.
- Хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагаа тунгалаг, жил бүрийн тайлан нь олон нийтэд ил тод байна.
- Хэвлэлийн зөвлөлийн мөрдөх сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг нийтээр хүлээн зөвшөөрсөн байх
- Хэвлэлийн зөвлөлийн талаар хуулинд шууд заалт орох шаардлагагүй.

- Зөвлөлийн шийтгэл нь шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, залруулга ба уучлал нийтлэхээс хэтрэх ёсгүй. Залруулгын хэмжээ, нүүрний байрлалыг зөвлөл тогтоох нь зүйтэй
- Хэвлэл мэдээллийн хаягласан гомдлыг Консул үнэ төлбөргүй барагдуулах нь зүйтэй.
- Зөвлөлийн санхүүжилтэнд гадаадын олон улсын байгууллагаас дэмжлэг авч болно
- Хэвлэлийн зөвлөл мөрдөн шалгах эрхгүй

Мөрөөдөл яриад дээгүүр хөвөөд байж болохгүй, дор дор нь хаагаад явах хэрэгтэй. Юун түрүүнд бид Хэвлэлийн Консулаа байгуулах хэрэгтэй байна.

Мөнгө бүрэн ноёлсон, эрх зүйн орчин таатай бус өнөөгийн нөхцөлд мэргэжлийн сэтгүүл зүй амьд байгааг харуулж, мэдээ хөөцөлдөн ямагт яарч явдаг өдөр тутмын тойгоосоо нэг удаа холдоод хараат бус ажиглагчдын үгийг сонсож санаа аваасай гэж бид мэргэжил нэгтэй нөхөддөө хандаж байна .

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүгдийг цуглуулж хамруулах, редакци болон эрхлэгчидтэй, эзэдтэй зөвшилцөлд хүрэх, Засгийн газар болон нийгмийн зүгээс дэмжлэг авах, дагаж мөрдөх ёс зүйн дүрэм боловсруулах, зардал ба боломжтой санхүүжилтийг төсөвлөх, бүрэлдэхүүн, ямар хэвлэл мэдээллийн байгууллага орох зэрэг байгууллатын бүтцийг хэлэлцүүлэх, бүрдүүлэх, Хэвлэлийн зөвлөлийн эрхийг тодорхойлох, өргөдөл хүлээж авах, шийдвэрлэх үйл ажиллагааг тогтох, сэтгүүлчдэд болон хэвлэлд ёс зүйн дүрмийг мэдээлж хүргэх, адил төстэй бусад байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох зэрэг олон олон ажил та биднийг хүлээж байна.

\* \* \*



## МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР АШГИЙН БАЙДАЛ

Чүлтэмиийн Улаан

ҮИХ-ын гишүүн, Төвсийн байнгын хорооны  
гишүүн, доктор, профессор

Манай улс дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралыг гэтлэн даваад эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангах зорилтыг хэрэгжүүлэх үедээ шилжиж байна. Энэ үед эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ үр ашгийг дээшлүүлэх, ялангуяа хөрөнгө мөнгөний өгөөж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд илүүтэй анхаарал хандуулах шаардлага тавигдаж байна.

Макроэдийн засгийн онолоор авч үзвэл эдийн засгийн өсөлтийн үндсэн нөхцөл нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм. Онолын хувьд хөрөнгө оруулалтын хэмжээ болон эдийн засгийн өсөлтийн хооронд тогтвортой холбоо байдаг. Энэ бол бодит амьдрал дээр нэгэнт батлагдсан зүйл юм.

Үйлдвэрлэл хөгжүүлэхэд илүү их хөрөнгө зарцуулсан улс орнууд (Япон, Сингапур, Омнө Солонгос г.м)-ын эдийн засгийн өсөлтийн түвшин өндөр байна. Харин нь хөрөнгө оруулалтад ДНБ-ийхээ багахан хувийг зарцуулсан улс орнуудын өсөлтийн үзүүлэлт бага (Уганда, Бангладеш) г. м байна. Гэхдээ энэ дүтнэлт нь нилээд урт хугацааг, ядаж 20-30 жилийн хугацааг хамарсан судалгаагаар батлагдах юм.

Манай улсын хувьд авч үзвэл шилжилтийн гэж нэрлэгдсэн 20-аад жилийн дотор ихээхэн савлагаатай унаж, боссон замыг туулж ирсэн

байдаг. Энэ хугацааг судалж үзэхэд хөрөнгө оруулалтын хэмжээ үнэмлэхүй түвшнээр байнга өсөж ирсэн нь шууд болон дам нөлөөгөөр эдийн засгийн өсөлтөд зэрэг нөлөө үзүүлж байсан байна.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад хэрэгцээтэй хөрөнгийг бурдүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад орон, олон улсын байгууллагаас авах хөгжлийн албан ёсны тусламж (ОДА) болон дотоодын хөрөнгө оруулалтын нөөцийг бүрэн хэмжээгээр ашиглах бодлого явуулж байсан байна.

- Манай улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн 6-н жилд жил тутам 100-аад тэрбум төгрөгөөр нэмэгдсээр энэ онд 800-аад тэрбумаас давж байна.

Манай улс гадаадын 40-өөд улстай хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр хэлэлцээр байгуулсан байна.

Үүнээс гадна манай улс гадаадын хөрөнгө оруулалтын хууль баталж, түүнд З удаа нэмэлт өөрчлөлт оруулж эрх зүйн орчин, хуулийн баталгаажуулалтыг сайжруулсан байна. Энэ бүхэн гадаадын шууд хөрөнгө оруулалт байнга нэмэгдэх таатай орчин болжээ.

Цаашид ч гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ тогтвортой өсөх

хандлага тодорхой байна. Оюу толгойн орд газрыг ашиглах гэрээ хэлэлцээр хийгдэж, Таван толгойн орд газрыг ашиглах асуудал яригдаж байна. Эдгээр асуудлууд шийдэгдэхийн хирээр гадаадын хөрөнгө оруулалт огцом нэмэгдэх болно. Өнөөдрийн байдлаар авч үзэхэд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтаас давсан байгаа нь манай эдийн застийн өсөлтөд чухал нөлөө үзүүлсэн нь тодорхой юм..

Гадаадын хөрөнгө оруулагчид өндөр үр ашигтай төсөл, стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг ашиглах арга хэмжээнд хөрөнгөө оруулж байгаа учраас оруулсан хөрөнгийн өгөөж өндөр байгаад эргэлзэх зүйл байхгүй.

- Эдийн застийн хямралтай, хөрөнгө санхүүгийн нөөцийн хомсдолтой байсан үед гадаад улсуудаас авах хөгжлийн албан ёсны тусламж чухал үүрэг гүйцэтгэж байлаа. Сүүлийн 10 жилийн туршид жил тутам 100-180 тэрбум төгрөгийн зээл, тусламж ашигласан байна. Хөгжлийн албан ёсны тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь анхандаа нийгмийн салбарын бүхий л хүрээг хамарч байсан бөгөөд шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийн дунд амьдрал залгуулах, гал унтраах зорилгод илүүтэй ашиглагдаж байснаа аажмаар эдийн застийн дэд бүтэц, нийгмийн салбарын томоохон төсөл арга хэмжээнд түлхүү зарцуулагдах болсон байна. Сүүлийн жилүүдэд гадаад зах зээлд таатай нөхцөл байдал үүсэж дотоодын эдийн засаг байнга тэлж байгаатай холбоотойгоор гадаад өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд сайжирч байна. Өр ба ДНБ-ний харьцаа, өр ба экспорт, өр ба ЗГ-ын орлого, өрийн үйлчилгээ экспорт, өрийн үйлчилгээ ба ЗГ-ын орлогын харьцаа сэрэмжлүүлэх

түвшнээс 2-6 дахин доогуур байна. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 1,255.9 тэрбум төгрөг болсон хэдий ч нилээд урт хугацаанд төлөгдөх учраас дарамт, хүндрэл үүсгэхгүй байх боломжтой юм.

Зээлийн өрийн үлдэгдлийн 82.6 хувь нь төрийн өмчийн байгууллагуудад, 17.4 хувь нь хувийн өмчийн байгууллагуудад ногдох байна. Авч ашигласан зээлийн ашиглалт үр өгөөжийг дээшлүүлэх асуудалд онцгой анхаарах шаардлага тавигдаж байна.

Сүүлийн жилийн дунгээр авч үзвэл манай улсын нийт хөрөнгө оруулалтын 42 хувийг гадаад эх үүсвэрээр, 58 хувийг дотоод эх үүсвэрээс санхүүжигдсэн байна.

Дотоод эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын бүтцийг судалж үзэхэд банкны зээлээр 13,5 хувийг, компанийн хөрөнгөөр 15 хувийг бүрдүүлсэн байна. Бизнесийн хүрээ, хувийн хэвшлийнхний хийсэн хөрөнгө оруулалтын талаар дэлгэрэнгүй судалгаа хийх мэдээллийн бааз байхгүй, үр ашгийн тооцоо гаргах боломж туйлын хязгаарлагдмал байна.

Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээ, барих барилга байгууламж нь тухайн компанийн хувьд үр өгөөжтэй байсан төдийгүй улс орны нийтлэг эрх ашигт нийцсэн, хүн амд үйлчилсэн гэдэг агуулгаар талархан хүлээж авах учиртай. Хувийн хөрөнгө оруулалт нь хөдөлмерийн нөөцийг ашиглах, ажлын байр бий болгох, байгалийн баялаг бүхий шинэ бүс нутгийг ашиглах, шинэ салбарыг бий болгох зорилгоор дийлэнх тохиолдолд ашиглагдаж байснаас үзэхэд бүтээн байгуулалтын шинжийг илүүтэй агуулж байсан гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

- Сүүлийн жилүүдэд үндэсний аж үйлдвэр, хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжиж, цар хүрээ нь тэлж байгаатай уялдан дотоодын хөрөнгө оруулалт бодитойгоор нэмэгдсээр байна.

Дотоодын хөрөнгө оруулалтад улсын төсвийн хөрөнгө оруулалт томоохон үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үндэсний орлогын бүрэлдэхүүн хэсэг болох хуримтлалын фондын зонхилох хэстийг бүрдүүлсээр байгаа гэдэг утгаараа чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн таван жилд улсын төсвөөс 2020,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь түүний өмнөх таван жилийн хөрөнгө оруулалт 180-д тэрбум төгрөг байсантай харьцуулбал 10 гаруй дахин их байна.

Улсын төсвөөс хийх хөрөнгө оруулалтын хэмжээ ингэж ихээхэн хурдацтай нэмэгдэж байгаа нь оруулсан хөрөнгийн өгөөжийг дээшлүүлэх асуудалд анхаарал хандуулах шаардлагыг бий болгож байна.

Үйлдвэрлэлийн салбарын хөгжилд илүү их хөрөнгө оруулалтыг зориулсан улс орны эдийн засгийн өсөлт өндөр байдаг тухай дээр өгүүлсэн билээ. Энэ агуулгаар нь манай улсын төсвийн хөрөнгө оруулалтын материаллаг үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус салбарт оруулсан гэж авч үзэж дүгнэлт хийх нь зүйтэй юм.

Сүүлийн жилүүдийн дунджаар хөрөнгө оруулалтын 60-аад хувь нь материаллаг үйлдвэрлэлийн салбарт, 40-өөд хувь нь үйлдвэрлэлийн бус салбарт ашиглагдсан байна. Ерөнхий хандлага нь оновчтой гэж үзэж болох ч үйлдвэрлэлийн бус салбарт оруулсан хөрөнгийн хувийн жин жил дараалан өсөх хандлагатай байна. Үйлдвэрлэлийн салбарын дүнгээр авч

узвэл үйлдвэржүүлэлтэд зарцуулсан хөрөнгө оруулалт салбар дотроо 22 хувь, нийт хөрөнгө оруулалтдаа 15 хувь хүрэхгүй, сүүлийн жилүүдэд хувийн жин байнга буурах хандлагатай байгааг оновчтой, хангалттай түвшин гэж үзэх үндэстгүй байна.

Материаллаг үйлдвэрлэлийн салбарууд дотроос дэд бүтцийн, тухайлбал зам барилга, тээвэр холбооны салбарын хувийн жин харьцангуй өндөр байсан нь манай орны онцлог юм. Материаллаг үйлдвэрлэлийн салбарт оруулсан хөрөнгийн хувийн жин өндөр байгаа нь эх орны үндэсний баялгийн гол хэсэг болох идэвхтэй үндсэн фондыг нэмэгдүүлж байгаа гэдэг утгаараа ач холбогдолтой байдаг.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх боломжийг судлахын тулд түүний технологийн бүтцийг авч үзэх нь зүйтэй байдаг. Судалгаанд хамрагдсан хугацаанд хөрөнгө оруулалтын дунд барилга угсралтын ажлын хувийн жин 80 гаруй хувь, тоног төхөөрөмжийн хувийн жин 10 хүрэхгүй хувь, их засвар 5-6 хувийн жинтэй байна.

Манай хөрөнгө оруулалтын технологийн бүтцэд үндсэн хөрөнгийн идэвхтэй хэсэгт хамаардаг, илүү бүтээлч шинж чанартай тоног төхөөрөмжийн хувийн жин харьцангуй дор түвшинд байгаа нь тийм ч сайн үзүүлэлт биш юм байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт үндсэндээ шинээр барилга байгууламж барихад ашиглагдаад байгаа үндсэн хөрөнгө хамгаалж тордох, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож бүтээмжийг нэмэгдүүлэх асуудалд бага анхаарч иржээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нөхөн үйлдвэрлэлийн бүтцийг авч узвэл шинээр барихад 70 хувь, өргөтгөл шинэчлэлт хийхэд 20 хувь, их засвар хийхэд 10-д хувь нь ашиглагдаж

байгаагаас үзсэн ч дээрх дүгнэлт нотлогдож байна.

Хөрөнгө оруулалтын нөхөн үйлдвэрлэлийн бүтцээс үзэхэд хөгжлийн тэлж өргөжин хөгжих-экстенсив хэлбэр зонхилоод чанаржиж, өгөөжөө нэмэгдүүлж хөгжих, өөрөөр хэлбэл шинжлэх ухаан, техникийн дэвшилийн онолтыг нэвтрүүлж үр ашиг, чанарыг дээшлүүлэх хөгжлийн интенсив хэлбэрийн хувийн жин бага байна. Ялангуяа сүүлийн 1-2 жилд, ирэх онд дээрх хандлага давамгайлж байгааг анхаарах ёстой. Ирэх онд улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээний 70 хувь нь шинээр барих, 15 хувь нь өргөтгэл шинэчлэлт хийх, мөн 15 орчим хувь нь их засвар хийхэд төлөвлөгөөд байна.

Шинээр барих ангилалд хамрагдаж байгаа төсөл, арга хэмжээний нилээд хувь нь албан контор, унаа машин гэх зэрэг хүнд суртлын гэгдэх албан хаагчдын ажиллах ая тухыг хангахад чиглэгдсэн алсдаа улсын төсвийн ачааллыг нэмэгдүүлэх зүйлүүд байна. Зүй нь төслийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь иргэддээ ажлын байр бий болгох, хөдөлмөрийн нөөцийг ашиглах замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад илүүтэй чиглэгдэж байвал оновчтой болох юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өсөхийн хирээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо нэмэгдэж байна. Энэ ч зүй ёсны хэрэг гэж үзэж болох талтай. Ирэх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1100-аад төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсний 70-аад хувь нь үйлдвэрлэлийн бус хүрээнд чиглэгдэж байна.

Дээрх төсөл, арга хэмжээний бараг тал хувь нь 100 сая хүрэхгүй хөрөнгө оруулалттай байна. Төсөвлөсөн хөрөнгө оруулалт нь дунджаар нийт төсөвт

өртгийхөө 5 хувь ч хүрэхгүй байгаагаас болон нийт төсөл, арга хэмжээний 40-өөд хувь нь энэ оноос шинээр эхлэхээр төлөвлөснөөс үзвэл маш олон жижиг төсөл, арга хэмжээнд, хөрөнгө нөөцийг хэтэрхий тарамдуулан хуваарилах нь гэсэн дүгнэлт гарч байна. Ийм нөхцөлд хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийн тухай ярих нь утга учир муутай харагдаж байна.

Дээрх байдлууд нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт ихээхэн гажуудсаныг харуулж буй хэрэг юм. Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг УИХ дээр ихээхэн задгай хэлэлцдэг, гишүүдийн саналаар объектын тоог ихээр нэмэгдүүлдэг, гишүүдийн гэсэн нэртэйгээр тойрог бүрт ихээхэн хэмжээний хөрөнгийг үнийн дүнгээр нь хуваарилдаг, бэлтгэл хангадаагүй, зураг төсөвгүй, хайгуул ч хийгдээгүй объектыг төсөвт тусгадаг; хөрөнгө оруулалтын арга хэмжээг төсөл, арга хэмжээ нэг бүрээр батлах хуулийн заалтыг зөрчиж үнийн дүнгээр, багцлан төсөвлөж батладаг болсон, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналт суларсан зэрэг нь дээрх байдалд хургэсэн гэж үзэж байна.

Улсын төсвийг бүхэлд нь, түүний дотор хөрөнгө оруулалтыг хэт төвлөрүүлсэн байдлыг өөрчилж төсвийн ерөнхийлөн захирагч болон орон нутгийн эрх мэдлийг, хариуцлагын нь хамт нэмэгдүүлсэн шинэ тогтолцоо, шинэ арга механизмд шилжихгүйгээр дээрх гажуудлыг арилгаж чадахгүй юм.

Хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг дээшлүүлэх асуудлыг зөвхөн түүний бүтэц, бүрэлдэхүүнийг боловсронгуй болгох хүрээгээр авч үзэхэд ашиглаагүй нөөц боломж багагүй байгаа нь тодорхой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүний өгөөжийг өстгөх

замаар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх асар их нөөц бололцоо байна. Онолын хувьд эдийн засгийн оновчтой тэнцвэрийн үед нийгэм дэх хадгаламжийн хэмжээ хөрөнгө оруулалтын хэмжээтэй тэнцүү байдаг гэдгийг харгалзан үзвэл хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж ч байна.

Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор илүү их хөрөнгийг чиглүүлэхийн тулд өнөөгийн хэрэглээнд, ялангуяа Засгийн Газрын хэрэглээнд ашиглаж буй нөөцийг хязгаарлах боломжийг ч судлан авч, үзэх шаардлагатай. Онолын хувьд хуримтлал, хэрэглээний зохистой харьцааг барьж капиталын өсөлтийг оновчтойгоор бий болгох нь эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэгдүүлэх нэг чухал шижим юм. Энэ чиглэлд судалгааг нарийвчлан хийж төр, засгийн бодлогод тусган хэрэгжүүлэх нь зүйтэй байна.



# АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ГЛОБАЛЬЧЛАЛ ХӨГЖИЖ БҮЙ ОРНУУДАД ТУС ДЭМ БОЛЖ БАЙНА УУ?

Кевин Е. Дэйвис

Бизнесийн эрх зүйн профессор  
Нью-Йоркийн их сургуулийн Хууль зүйн сургууль

## Does the Globalization of Anti-corruption Law Help Developing Countries?

Kevin E. Davis<sup>1\*</sup>

Beller Family Professor of Business Law  
New York University School of Law  
ked2@nyu.edu

September 2010

*Forthcoming in International Law, Economic Globalization and Development,*

Julio Faundez and Celine Tan, eds.  
(Edward Elgar, 2010).

### Abstract

What role do foreign institutions play in combating political corruption in developing countries? This chapter begins by describing the recently developed transnational anti-corruption regime, which encompasses legal instruments ranging from the dedicated multilateral agreements sponsored by the OECD and the United Nations, to the anti-corruption policies of international financial institutions, to components of the international anti-money laundering regime, international norms governing government procurement, and private law norms

<sup>1</sup> \* I am grateful for comments on an earlier version from Indira Carr, Robert Howse, James Jacobs Guillermo Jorge, and Benedict Kingsbury, as well as Julio Faundez and Celine Tan (the editors). I am also grateful for the support of the Filomen D'Agostino and Max E. Greenberg Research Fund at NYU School of Law.

## Авлигын эсрэг хуулийн глобальчлал хөгжиж буй орнуудад тус дэм болж байна уу?

Кевин Е. Дэйвис<sup>1\*</sup>

Бизнесийн эрх зүйн профессор  
Нью-Йоркийн их сургуулийн  
Хууль зүйн сургууль  
ked2@nyu.edu

2010 оны 9 дүгээр сар  
Олон улсын эрх зүй, эдийн засгийн  
глобальчлал ба хөгжлийн ойрын  
ирээдүйн хандлага,

Редактор: Жулио Фаундез, Селине Тан  
(Эдвард Элгар, 2010).

### Хураангуй

Хөгжиж буй орнуудад улс төрийн авлигатай тэмцэхэд гадаадын байгууллагууд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Энэ бүлгийн эхэнд Эдийн засгийн хөгжил хамтын ажиллагааны байгууллага (ЭЗХХАБ) болон Нэгдсэн үндэстний байгууллагын дэмжлэгтэйгээр гаргасан олон талт хэлэлцээрүүдээс эхлээд олон улсын санхүүгийн байгууллагын авлигатай тэмцэх бодлого, олон улсын мөнгө угаахтай

<sup>1</sup> \* Омнөх хувилбарт санал, зөвлөмж өгсөн Индира Карр, Роберт Ховс, Жеймс Жакоб Гулермо Жорге, Бенедикт Кингсбури, түүнчлэн Жулио Фаундез ба Селине Тан (редакторууд) наартаа талархлаа илэрхийлж байна. Мөн Нью-Йоркийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Филомен Де Августино болон Макс Грийнбергийн Судалгааны санд дэмжлэг үзүүлсэн явдалд талархлаа илэрхийлж байна.

concerning enforcement of corruptly procured contracts. It also surveys the evidence concerning a variety of claims about the potential advantages and disadvantages of having foreign institutions play a role in preventing, sanctioning, or providing redress for corruption on the part of local public officials. One of the main conclusions is that more attention ought to be paid to whether foreign institutions displace and undermine, or alternatively complement and enhance, local anti-corruption institutions. The analysis not only sheds light on the transnational anti-corruption regime, but also has implications for other efforts to rely on foreign legal institutions to address the problems of developing countries.

## INTRODUCTION

What role do foreign institutions play in combating political corruption in developing countries? This chapter attempts to shed light on this question by examining the impact on developing countries of the elaborate transnational anti-corruption regime that has emerged in recent years. The centerpieces of that regime are dedicated treaties such as the Organization for Economic Cooperation and Development's Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions ('OECD Convention') and the United Nations Convention against Corruption ('UN Convention'). However, the regime also encompasses a range of other legal instruments, including the anti-corruption policies of international financial institutions, components of the international anti-money laundering regime, international norms governing government procurement, and private law norms concerning enforcement of corruptly procured contracts.

The idea that foreign legal institutions can step in and be of assistance when

холбоотой дэглэм, застийн газрын худалдан авах ажиллагааг зохицуулах олон улсын хэм хэмжээ, авлигатай холбоотойгоор хийгдсэн худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилттэй холбоотой эрх зүйн тогтолцоо хүртэлх эрх зүйн хэрэгслүүдээс бурдэх, саяхан боловсруулан гаргаад буй улс хоорондын авлигын эсрэг дэглэмийн талаар авч үзэх болно. Энд мөн тухайн улс орны төрийн албан хаагчдын авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэх, ял шийтгэл ногдуулах, хохирлыг арилгахад гадаадын байгууллагуудын үүрэг оролцооны боломжит давуу болон сүл талын талаарх төрөл бүрийн нотолгоо материалыудыг судлан үзсэн болно. Гол дүгнэлтүүдийн нэг нь гадаадын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, эсвэл нөгөө талаар тухайн улс орны авлигын эсрэг байгууллагыг өргөжүүлэх, хамтран ажиллах аль аль тал дээр илүү анхаарлаа хандуулж ажиллах явдал юм. Энэ анализ шинжилгээ нь олон улсын авлигын эсрэг дэглэмийн талаар онцлон авч үзээд зогсохгүй мөн хөгжиж буй орнуудын асуудалд чиглэсэн гадаадын хуулийн байгууллагуудад хамаарах бусад хүчин чармайлтуудын хамаарлыг авч үзсэн.

## 1. Танилцуулга

Хөгжиж буй орнуудад улс төрийн авлигатай тэмцэхэд гадаадын байгууллагууд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Энэ бүлэгт сүүлийн жилүүдэд бий болсон улс хоорондын авлигын эсрэг дэглэмд нэгдэн орох нь хөгжиж буй орнуудад ямар нөлөө үзүүлж байгааг судлан үзэж уг асуултад хариулт өгөхийг зорьсон юм. Энэхүү дэглэмийн гол цөм нь Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Олон улсын бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан хаагчийг хахуульдахтай тэмцэх конвенц ('ЭЗХХАБ-ын конвенц') болон Нэгдсэн үндэстний байгууллагын

their domestic counterparts are found wanting, which some might call a form of legal globalization (others might call it ‘institutional piggy-backing’), is a familiar one in modern legal thought. For instance, the international investment regime is typically justified by reference to the idea that investor-state arbitration can usefully compensate for the shortcomings of national courts in capital-importing countries. International commercial arbitration is often justified on similar grounds. Along the same lines, Dammann and Hansmann (2008) have proposed that countries with strong courts should allow those courts to assert jurisdiction over disputes to which they have no tangible connection in order to enable litigants in developing countries (and elsewhere) to break the monopolies enjoyed by dysfunctional local courts. Coffee (1999) makes the case for allowing issuers from countries with weak securities regulators to rely on foreign securities laws. Finally, proponents of extra-territorial application of labour and environmental laws argue that this is the best means of securing protection for the inhabitants of countries with inadequate labour and environmental regimes.

The idea of calling on foreign legal institutions to buttress domestic institutions is particularly appealing when what is at stake is the very integrity of the state. Political corruption, which I will define broadly – if somewhat vaguely – as the misuse of public power for private gain, compromises the integrity of the state and is widely viewed as a significant obstacle to development (see generally, Rose-Ackerman, 1999). At the same time, the advent of globalization has made political corruption a transnational phenomenon. We live in a world of structural adjustment programs, multinational corporations, international supply chains, international wire transfers and daily inter-

Авлига нь зөвхөн дотоодын асуудал байхаа большыг Конвенци маань өөрөө нотолж байгаа юм. Энэхүү гэмт хэрэг нь хил хязгаарыг харгалзахгүй юм. Иймд олон улсын хамтын ажиллагааг этгээдийг хүлээлгэн өгөх, олон талын эрх зүйн гэрээ хэлэлцээр, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, хамтран мөрдөн шалгах ажил явуулах зэрэг чиглэлээр хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм. Хил хязгаар, аюулгүй байдал зэрэг нь мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулахас зайлсхийж, шударга ёсыг олж буруутай талуудад хариуцлага хүлээлгэх ёстай. Конвенцийг соёрхон батлахдаа авлигатай тэмцэх чиглэлээр улс орнууд өөр бусад оронтой хамтран ажиллахаа зөвшөөрдөг. Үүнд урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг яллах зэрэг ордог.

## Хөрөнгө эргүүлэн олж авах

Олон улсын хамтын ажиллагаа нь ялангуяа хулгайллагдсан хөрөнгийг олж тогтоон, эргүүлэн олж авахад маш чухал юм. Иймд энэ нь тодорхой үр дунд хурч болох салбар тул тусгайлан анхааран дэмжих хэрэгтэй юм. Хэрэв хөрөнгө эргүүлэн олж авах хэрэгслүүдийг

preventive guidelines, tracking systems and assessment tools. Success also depends on the removal of banking secrecy as an obstacle, and a greater willingness by political leaders, institutions, including anti-corruption authorities of receiving States, to cooperate for the return of stolen resources.

Asset recovery has been a breakthrough of the Convention that has offered new hope and created new expectations. To meet such expectations, the Stolen Assets Recovery Initiative, commonly known as the StAR Initiative, was launched by the World Bank Group and UNODC in September 2007. Its goal is to facilitate systematic and timely return of assets that derive from corruption – thereby denying safe havens to corrupt public officials or private entities alike. Later this morning will hear from the Director of the StAR Initiative, Mr. Adrian Fozzard, on the pillars and accomplishments of this enterprise. Suffice it to say that StAR is the cooperative effort of two organizations, the United Nations and World Bank, to make a substantial contribution to the implementation of the specific provisions of the Conventions dealing with asset recovery.

### **Third Conference of the States Parties to the UN Convention against Corruption**

Excellencies, Ladies and Gentlemen, The third session Conference of the States Parties to the UN Convention against Corruption was held in Doha in November last year. While this is certainly no news to any of you, allow me to highlight the key significant developments that have transpired from that Conference.

### **Review of implementation**

Last year in Doha, the international anti-corruption community reached an historical decision by adopting the Mech-

ашиглах юм бол хулгайлагдсан тэрбум тэрбумыг эргүүлэн олж авах боломжтой юм. Энэ нь урьдчилан сэргийлэх зохицуулалт, ул мөрийг нь дагаж олох систем, үнэлэх хэрэгслүүд юм. Банкны нууцлалын системийг саад тогтор хэмээн авч хаях, улс төрийн удирдлага, байгууллагуудын хүсэл эрмэлзэл, ялангуяа, хөрөнгө очсон улсын авлигатай тэмцэх байгууллагын хөрөнгө эргүүлэн өгөх тал дээр хамтарч ажиллах хүсэл эрмэлзэл зэргээс амжилт хамаарах юм.

Конвенцийн хөрөнгө эргүүлэх олж авах асуудал нь шинэ найдвар, шинэ хүлээлт өгсөн урагш хөтөлсөн том алхам юм. Энэхүү хүлээлтийг хангахад 2007 оны 9 сард Дэлхийн банк, НҮБ-ын Хар тамхи мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх газар Хулгайлагдсан хөрөнгийг эргүүлэх олж авах санаачлага (ихэнхдээ (StAR- stolen asset recovery) Стар санаачлага хэмээн нэрлэгддэг) –ыг боловсруулсан юм. Үүний зорилго нь авлигын улмаас олсон хөрөнгийг системтэй, цаг хугацаанд нь олж авахад дэмжлэг үзүүлэх – иймд авлигад автсан төрийн албан тушаалтнууд болон хувийн байгууллагуудад тайван байх боломжийг олгохгүй юм. Бид өнөөдөр энэхүү санаачлагын үндэс суурь, хурсэн үр дүн зэргийн талаар тус санаачлагын дарга Адриан Фозардын илтгэлийг сонсох болно. Стар санаачлага нь хөрөнгө эргүүлэх олж авах талаархи Конвенцийн тусгай заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ болон Дэлхийн банк гэсэн хоёр байгууллагын хамтын ажиллагааны бодит үр дүн гэдгийг хэлэх нь зүйтэй юм.

### **НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн оролцогч улсуудын гуравдугаар бага хурал**

Хатагтай, ноёдоо, өнгөрсөн жилийн 11 сард НҮБ-ын Авилгалын эсрэг Конвенцийн оролцогч улсуудын гуравдугаар бага хурал Доход болсон. Энэ бол та бүхэнд нэг их сонин зүйл биш нь тодорхой,

anism for Reviewing Implementation of the Convention, which is unprecedented in the UN system. This came after the recognised necessity, paramount importance and urgency that were expressed by all States parties to the Convention to establish an effective mechanism to review its implementation. We are not so naive to believe that this architecture, known as the “UNCAC Review Mechanism”, will end corruption, but it will no doubt enable us to measure and support efforts to fight it. From now on, States will be judged by the actions that they take against corruption, and not the promises they make.

Under the Mechanism, States have undertaken to review each other progress in fighting corruption through a peer-to-peer process. In other words, each State will review and be reviewed in consecutive cycles of five years each. The Mechanism will not generate ranks, neither will it compare countries with one other. It will rather support domestic anti-corruption efforts, will help countries to take stock of their own progress, identify their own weaknesses, their own needs, and gain preferential access to international cooperation and assistance.

### **Private sector**

*Excellencies, Ladies and Gentleman,*

This Symposium is being held to foster greater leadership and cooperation in the fight against corruption. In attendance are numerous high-level national and international civil servants who are devoting their lives to this cause. I mentioned at the outset that governments and their leaders have a crucial role to play. However, for anti-corruption action to be holistic and effective, we should not neglect what is often referred to as “the other side of the equation”: the private sector. Also the corporate community has consider-

тэгэхдээ энэхүү бага хурлаас гарсан ач холбогдолтой үндсэн зорилтуудаас дурьдахыг надад зөвшөөрнө үү.

### **Хэрэгжилтийг үнэлэх**

Өнгөрсөн жил Дохад олон улсын авлигын эсрэг хамтын нөхөрлөл НҮБ-ын Аivilgalын эсрэг Конвенцийн хэрэгжилтийг үнэлэх механизмыг батлан НҮБ-ын системд байгаагүй түүхэн шийдвэрт хүрсэн юм. Конвенцийн бүх оролцогч улс орнууд хэрэгжилтийг үнэлэх үр дүнтэй механизм байгуулах нэн чухал, яаралтай шаардлага байгааг илэрхийлсэн юм. Бид “НҮБ-ын АЭК-ийн үнэлгээний механизм” гэсэн байгууламж нь авлигыг зогсоож чадна гэдэгт итгэх гэнэн хүмүүс биш хэдий ч авлигатай тэмцэх хүчин чармайлтыг хэмжих, дэмжих боломжийг бидэнд олгож байгаа нь маргаангүй юм. Өнөөдрөөс эхлэн талуудыг өгч буй амлалтуудаар бус харин авлигын эсрэг хийж буй үйл ажиллагаагаар нь үнэлэх юм.

Энэхүү Механизм гэдэгт талууд авлигатай тэмцэх чиглэлээр өөр өөрсдийн амжилтыг яг ижил тэнцүү нөхцлөөр хийх юм. Өөрөөр хэлбэл, улс болгон таван жилийн давтамжтай дэс дараатай циклийн дагуу үнэлж, үнэлүүлэх юм. Механизм нь эрэмблэхгүйгээс гадна улс орныг хооронд нь харьцуулахгүй юм. Энэ нь дотоодын авлигын эсрэг хүчин чармайлтыг дэмжих, улс орнуудад өөрийн амжилтыг үнэлэхэд туслах, өөрсдийн хэрэгцээ, шаардлага, сүл талуудыг олж тогтоох, олон улсын хамтын ажиллагаа, дэмжлэгийн ашиг тусыг эдлэх зэрэг боломж олгох юм.

### **Хувийн салбар**

*Хатагтай, ноёдоо*

Энэхүү бага хурал нь авлигатай тэмцэхэд хамтын ажиллагаа, тэргүүлэх үүргийг дэмжихэд зориулсан. Олон тооны өндөр түвшний үндэсний болон

able leadership to exercise and contributions to make. The UN Convention against Corruption mandates governments to establish corporate liability to corruption, but also measures to promote cooperation between business and public authorities that investigate and prosecute corruption. Of course, governments need to reassure their private counterparts that cooperation will be rewarded. We at the UN Office on Drugs and Crime are working on that front too. Guided by the Convention, that warrants measures to encourage the spontaneous provision of information useful to investigative and evidentiary purposes, we are working with some pilot governments to introduce legal incentives to corporate cooperation with public authorities – mitigation of punishments and other solutions can be the “carrot” to juxtapose to the “stick” of severe sanctions, astronomic fees or long debarments from public tendering.

### **International Anti-Corruption Academy**

As recently as last month, the world has witnessed another tangible manifestation of leadership, cooperation and public-private commitment. After a long preparatory work, the first International Anti-Corruption Academy opened its doors in Austria. Inaugurated by your illustrious compatriot, the Secretary-General of the United Nations, Mr. Ban Ki-moon, the Academy is a milestone in the global efforts to combat corruption. As the world’s first institution of higher learning focused on fighting corruption within the framework of the Convention, the Academy will disseminate specialized anti-corruption knowledge around the world, and forge specialized anti-corruption skills. The establishment of the Academy is the result of productive collaboration between the Government of Austria, UNODC, the European Anti Fraud Office and other partners – and can count on the generous

олон улсын төрийн албан хаагчид өөрсдийн амьдралыг тус үйлсэд зориулдаг. Хамгийн анхаас нь застийн газрууд, тэдгээрийн удирдлагууд шийдвэрлэх үүрэгтэй гэдгийг би онцолж байсан. Тэгэхдээ авлигын эсрэг үйл ажиллагааг үр ашигтай болгоход ихэнхдээ “тэгштгэлийн нөгөө тал” хэмээн нэрлэдэг хувийн салбарыг бид үл ойшоож болохгүй юм. НҮБ-ын Авиалын эсрэг Конвенци нь застийн газруудыг авлигын эсрэг корпоратив хариуцлагыг бий болгохыг үүрэг болгодог. Түүнчлэн авлигыг мөрдөн шалгаж, яллах буй төрийн байгууллагууд болон хувийн салбарын хамтын ажиллагааг дэмжих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Мэдээжийн хэрэг застийн газрууд хамтын ажиллагаа шагнагдана гэж өөрсдийн хувийн салбарын хамтрагчдаа итгэж үнэмшүүлэх ёстой. Бид НҮБ-ын Хар тамхи гэмт хэрэгтэй тэмцэх газар үүн дээр мөн ажиллах байна. Мэдээллийг өгөх асуудлыг дэмжинэ гэсэн Конвенцийн утга санааг удирдлага болгон мөрдөн шалгах, нотлох баримтыг цуглуулахад хэрэгтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр бид зарим нэг застийн газруудтай хамтран ажиллаж байна. Энэ ажлын хурээнд төрийн байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн хөшүүрэг бий болгох, үүнд ялын хэмжээг багастах болон бусад өөр арга хэмжээнүүд “урамшуулал”-ыг “арга хэмжээ”-тэй хатуу чанга, маш их хэмжээний төлбөр тавих, төрийн худалдан авалтанд оролцох эрийг нь урт хугацаагаар хасах зэргийг зэрэгцүүлэх юм.

### **Олон улсын авлигын эсрэг академи**

Саяхан сар гарны өмнө, дэлхий өртөнц бүхэлдээ манлайлал, удирдлагын олон нийтийн ба хувийн үүрэг даалгавар, итгэл үнэмшэлийн, хамтын үйл ажиллагааны үр дүн гэх мэт үр шим болсон бодит баталгааг бодитоор

contributions of leading governments and business alike.

## The Group of 20

Our host country, the Republic of Korea, will soon play host to the most important gathering of world's leaders. Under the Korean Presidency, the next Summit of the Group of 20 will take place in this very city just in a few weeks from now. At the previous Summit, held in Toronto in June this year, the leaders of the Group of 20 broke news grounds by calling upon themselves and the rest of the world to ratify and implement the UN Convention against Corruption as a means to redouble international efforts to combat corruption and lead by example. Under the chairmanship of France and Indonesia, the Anti-Corruption Working Group created by the Group of 20 met in Jakarta as recently as last week, and has already generated results to be commended. The G20 Anti-Corruption Action Plan has been crafted and is expected to be adopted by the world's leaders as they met here next month. In the three-page Action Plan, the UN Convention against Corruption is mentioned or referred to nine times. The Action Plan contains time-bound commitments for G20 leaders to honor – including the commitment to ratify the Convention as soon as possible by those four G20 States that are yet to do so – it places strong emphasis on the need to engage business leaders, and contains a regular progress reporting obligation. This is tangible evidence that the Group of 20 has elevated the fight against corruption to the top of its agenda.

## Conclusions

*Excellencies, Ladies and Gentlemen,*

The blueprint of a holistic integrity infrastructure is the United Nations Convention against Corruption – which has

мэдэрсэн билээ. Урт хугацааны бэлтгэл ажил хангагдсаны үр дунд Австри Улсад анхны Олон улсын Авлигын эсрэг Академи үүд хаалгаа нээлээ. Нээлтийн үйл ажиллагааг нээхээр нутагтаа алдаршиж хэзээний олны танил болсон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Бан Кимун хэлэхдээ уг академийн нээлт нь бүх дэлхий нийтийн авлигатай тэмцэх үйл ажлын хамгийн чухал үе гэжээ. Авиалгалтай тэмцэх конвенцид тулгуурлан өндөр түвшний мэдлэг олгох дэлхий дээрхи анхны байгууллагын хувьд Академи нь авлигатай тэмцэх талаар тусгай мэдлэгийг, авлигын эсрэг байх мэдэгдэхүүнийг дэлхий даяар мэдрүүлэхийг эрмэлзэх болно. Тус академи нь Австри Улсын Засийн газар, НҮБ-ын Хар тамхи гэмт хэрэгтэй тэмцэх газар, Европын залилангийн эсрэг газар мэн бусад улс орны засийн газар адил үйл ажиллагаа эрхлэдэг албан байгууллагуудын туслалцаа, хамтын ажиллагааны үр дүн юм.

## Хорийн бүлэг

Дэлхийн хамгийн чухал шилдэг удирдлагуудын уулзалт цуглаан удахгуй БНСУ-д болно. БНСУ-ын улсын удирдлагуудын хэлсэнчлэн дараагийн Хорийнн чуулга уулзалт тус улсад хэдхэн 7 хоногийн дараа болно. Түрүүчийн уулзалт нь өнгөрдөг зуны 7 дугаар сард Торонто хотод болсон. Цуглааны гол шалтгаан нь тэд өөрсдөө болон бүх дэлхий нийтийг НҮБ-ын Авиалгальн эсрэг конвенцийг дэмжиж, баталгаажуулан өндөр жишгэгтэй үйл ажиллагаа явуулах талаар нэгдсэн санаанд хүржээ. Франц, Индонези Улсын хариуцлагын дагуу Их Хорийн бүлгийн байгуулсан авлигын эсрэг тэмцэх баг бүрэлдэхүүн нь өнгөрдөг 7 хоногт Жакартад цуглаж сонирхол татахуйц маш үр дүнтэй ажил хийжээ. Их Хорийн бүлэгийн Авлигын эсрэг тэмцэх төлөвлөгөө нь бэлэн болсон ба дараа сард болох чуулган дээр

been ratified by over three quarters of the world in less than a decade and as such, can ensure consistency and coherence of anti-corruption efforts at the international level. The ultimate success of the UN anti-corruption Convention will be measured by the ability of government leaders to leave up to their legal obligations and implement its far-reaching measures; by the ability of the business leaders to establish coherent and unequivocal self-regulation models; by the ability of both public and private leaders to engage in a constructive dialogue and leverage public private partnerships; and by the ability of international organization like the United Nations to inform and support these dynamics, when requested to do so. Within this framework, leadership and cooperation are indispensable to breathe life into the Convention, help us define our roles and join forces to marshal an effective response to corruption.

*I wish you a successful Symposium and productive deliberations.*

*Thank you.*

их Хорийн бүлэгийн уулзалтан дээр гишүүд танилцаж хүлээн зөвшөөрөх үлджээ. З хуудас бүхий Тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд НҮБ-ын Авиалгалын эсрэг Конвенци нь 9 удаа дурдагдсан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд их Хорийн удирдлагуудын үүрэг даалгаварууд орсон ба үүнд бизнес эрхэлж буй албан байгууллагуудыг хамруулах талаар онцолж дурдсан. Түүнчлэн амжилт урагшлалтынхаа талаар байнгын тайлан мэдээлэл гаргаж байх албан үүрэг, их 20-д багтаж байгаа улс орны удирдагч нар конвенцийг аль болох түргэн батлах хэрэгтэй гэх мэт зүйлсийг багтаажжээ. Энэ нь их Хорийн бүлэг авлигатай тэмцэх үйл ажиллагааг бүрэн хэмжээнд чухалчилж хандан авч үзэж буйн бодит нотолгоо юм.

## **Δүгнэлт**

*Эрхэм Ноёд, Хатагтай нараа,*

Үнэн шударга байдлаар төсөл болон хэрэгжиж байгаагийн илрэл НҮБ-ын Авиалгтай тэмцэх Конвенци 10 гаруй жилийн туршид дэлхийн дөрөвний гурав нь хамтран оролцож байгаа юм. Тус конвенци ёс зүйд нийцхүүц, хоорондоо холбоотой нэгдмэл байж авлигын эсрэг олон улсын хэмжээнд тэмцэж чадна гэсэн баталгаа юм. НҮБ-ын авилгын эсрэг конвенцийн үндсэн амжилт нь улс орны төрийн түшээд өөрсдийн хуулийн дагуу үргээ ухамсарлан биелүүлж, бизнес эрхлэгч нар уялдаа холбоотой, бүрэн дүүрэн, хоёрдмол бус үйл ажиллагаагаа эрхлэн, бүх л хувийн болон улс орны удирдлагууд бүтээлч хандаж, улс орны ба хувь хүний үүднээс ч зорисондоо хүрэхэд нь тууштай байж, НҮБ-ын гэх мэт олон улсын байгууллагууд нь эдгээр динамик хөдөлгөх хүч хөгжлийг хэрэгтэй үед нь дэмжин туслалцаа үзүүлэх зэрэгт гарч ирэх юм. Энэ үйл ажиллагааны хүрээнд манлайлал, хамтран зүтгэх зэрэг нь Конвенцийн үйл ажиллагааг идэвхжүүлэгч гол хүч ба Авлигын эсрэг бид өөр өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлан тэмцэх гол хөшүүрэг юм.

*Би та бүхэнд амжилт хүсье  
Баярлалаа*



## ЯЛЫН БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА, ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН РЕФОРМ

Должингиин Баярсайхан

МУИС-ийн ХЗС-ийн Эрүүгийн эрх зүйн тэнхмийн  
багш, профессор, доктор /Ph.D/

### Нэг. Онолын үндэслэл, нийтлэг жишиг

Ялын ойлголт нь эдүгээ онолын төдийгүй жишигийн шалгуураар авч үзэх боломжтой, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёо болж төлөвшжээ. Ял<sup>21</sup> нь эрүүгийн эрх зүйн салшгүй институт төдийгүй нийгмийн хамгаалалтын бодлого, тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Ялыг төрийн бодлогын хүрээнд хэт явцууруулж ойлгох нь эдүгээ ач холбогдоо алдсан бөгөөд харин нийгмийн шудрага ёс, шүүх эрх мэдлийн зарчим, чиг хандлагын хүрээнд авч үзэх нь нийтлэг хөгжлийн баримтлал болж байна. Эрүүгийн анхны төрөлжсөн хууль (1810 он, Франц) гарснаас хойших шинэ үеийн түүхээс үзэхэд ялын бодлогыг тодорхойлж ирсэн голлох дөрвөн онолын урсгал нэг нь негөөгөө үгүйсгэх замаар хөгжиж иржээ.

**I үе шат.** Абсолют онол буюу ялыг тэнцвэржүүлэх хандлага нь /Кант, Гегель/ XIX зууны II хагасаас 1950-аад он хүртэл хүчтэй нөлөөтэй хэвээр байсан байна. Гол агуулга нь “Хохирлыг

21 Ял - латины “peina”, “punitas” - “залхаалт, цээрлэлт, золиос, нөхөөс” гэсэн язгуур утгаас эх үндэстэй бөгөөд англи, франц, герман, испани, итали, орос, хэлний үг зүйн утгын нийтлэг зориулалт нь “гэмт үйлдэхүйн хариу шийтгэл, нөхөн төлөөс”, хууль зүйн агуулгаар нь авч үзвэл эрүүгийн хууль тогтоомж зөрчин гэмт халдлага хийсэн этгээдэд эрх зүйн процесийн дагуу шүүхээс оногдуулах нийгмийн нөлөөллийн албадлага, хязгаарлалтын систем ажээ. /Д.Б/

хохирлоор”, “Гэмтнийг гэсгээлээр” гэсэн үндэслэгээ, зарчимд тулгуурлан, гэмт хэрэг хийсэн этгээдийг төрөөс /“хашраах”/ яллан цээрлүүлэх, гэмт хэрэгт нь тохирсон ялыг оноох шаардлагыг хангахад чиглэгдэж байв.

**II үе шат.** Харьцангуйн онол буюу ялыг нийгэмшүүлэх хандлага /Ж.Руссо, М.Вебер/ XX зууны II хагасаас эхлэн абсолют онолыг шүүмжлэх хандлага баруун Европт хүчтэй дэлгэрч, ялын зорилго нь ялтыг нийгмээс тусгаарлаж, залхаан цээрлүүлэхэд гол нь биш, харин эргээд нийгмийн амьдралд хөлөө олоход нь туслах, засч төлөвшүүлэх замаар нийгэмшүүлэхэд чиглэгдэх ёстой гэсэн үзэл баримтлал юм. Энэ концепц 1960 оноос эхэлсэн ялын бодлогын шинэчлэлд тусгалаа олж, дэлхийн олон орны эрүүгийн хуулиудад илэрч, хэрэгжсэн байна.

**III үе шат.** Таслан зогсоох онол буюу ялын “үл тэвчих” хандлага. 1960 оноос эхэлсэн ялын нийгэмшлийн хандлага зарим талаар шүүмжлэлд өртөх болсны дээр ялангуяа АНУ-д ялыг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ ямар ч ур дүнгүй болсныг харгалзан, “гэмт этгээдийг нийгмээс тусгаарлан аюулгүй болгох”; дахин гэмт хэрэг үйлдэхгүй болтол нь “хашраах”; хатуу чанд ял оноох бодлого баримтлах чиглэл гарч ирэв. Энэ хандлага ялангуяа АНУ-д түгээмэл дэлгэрч Зүүн Европ,

Ойрхи Дорнод, социалист орнуудад ч түгэн тархаж нөлөөлсөн байдаг.

**IV үе шат.** Либерал онол буюу ялын дэнслэн хязгаарлах хандлага. 1990-ээд оны эхэн үеэс эрүүгийн эрх зүйн салбарт гуманизацийн болон криминализацийн үйл явц нэгэн зэрэг өрнөж, глобальчлал болон эрх зүйн интеграциллын нөлөө улс, орнуудад түрэн орж ирсэнтэй холбогдон гарч ирсэн<sup>22</sup> бөгөөд уг онолын үндэслэл нь Германы эрүүгийн эрх зүйч-эрдэмтэн Франц Листийн дэвшиүүлж байсан гурвалсан шаталбарын онолын үзэл санааг хөгжүүлэх замаар бүрэлдэн тогтжээ. Энэ онолоор бол болгоомжгүй, санамсаргүй тохиолдлоор буюу ялимгүй хэрэг үйлдсэн этгээдэд сануулга өгөх, замаар ялаас хэтрүүлэх, дунд зэргийн хэрэг үйлдсэн буюу их биш, бага хэмжээний хохирол учруулсан этгээдэд хүнд биш ял оноох, засарч төлөвших боломж олгох, хүнд ноцтой хэрэг үйлдсэн этгээдийн хувьд засрах боломжтойг нь засч авах, засрах боломжгүйг нь бусдад дахин хор хөнөөл учруулах боломжийг хаах гэсэн ялын ялгавартай хандах нехцлийг олгодог байна.<sup>23</sup> Түүнчлэн ял нь нэг талаас шийтгэл, нөгөө талаас итгэл хүлээлгэх, засрал төлөвшил олгох нийгмийн арга хэмжээ гэж үзэж, ялын зорилго нь нийгэмшүүлэх иргэншүүлэх тал нь давамгайлсан цээрлэл, шийтгэлийн хосолмол систем болох ёстой ажээ.

1990-ээд оноос хойш дэлхийн олон улс, орон эрүүгийн эрх зүйн салбарт реформ хийж чадсан бөгөөд Олон улсын гэрээ, хэлэлцээр цөөнгүй гарсныг үндэслэн Эрүүгийн хууль тогтоомждоо өөрчлөлт, шинэтгэл хийсээр иржээ. Английн 2003 оны эрүүгийн шүүн таслах ажиллагааны тухай (**Criminal justice act, 2003. p44**)

22 Norrie , A A Critical Introduction to Criminal law . London . 1993 p.84-85

23 Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба шилжилтийн үе. Олон улсын симпозиумын баримт , материалын эмхэтгэл УБ, 2006 183-р тал

хуулийн 142-р зүйлд “Ял нь оновчтой, эзнээ олсон, тодорхой, үндэслэлтэй, үр дүнтэй байх ёстой” гэж заажээ.

Дийлэнх улс орны эрүүгийн хууль тогтоомжинд ялын ойлголтыг тодорхойлсон норматив томьёолол байдаггүй. Харин постсоциалист орнуудаас Орос, Украян, Казакстан , Армен, Узбекстан, Тажикстан зэрэг оронд “Ял” гэсэн нэр томьёогоор /“Наказание”/ хэрэглэж тодорхойлсон бол Белорусь, Молдав, Монгол зэрэг улс “Эрүүгийн хариуцлагага” гэсэн ойлголтоор авч үзэж томьёолжээ. 1996 оны 2-р сарын 17-нд баталсан ТТУХНөхөрлөлийн (СНГ) орнуудын Эрүүгийн загвар хуулийн 3-р хэсгийн 9-р бүлгийн 45-р зүйлд “Ял” гэсэн ойлголтыг хэрэглэсэн ба шүүхийн тогтоолоор оногдуулах төрийн албадлагын арга хэмжээ” гэж тодорхойлсны дээр 45-р зүйлийн 2-д: “Ял нь шүүгдэгч болон бусад холбогдох этгээдийг шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, засч төлөвшүүлэх болон нийгмийн шудрага ёсыг сэргээн тогтоох зорилгоор хэрэглэгдэнэ” гэж заажээ.<sup>24</sup> Герман, Францын эрүүгийн эрх зүйн эх сурвалжуудад ялыг төрийн албадлагын арга хэмжээ гэхээсээ илүү эрх зүйт ёсны зайлшгүй шаардлага, төдийгүй шүүхээс оноож буй норматив санкци, шудрага ёсыг ханггуулах хэрэгсэл гэсэн утгаар авч үздэг ажээ. Баруун европ буюу эх газрын системийн орнуудад зэрэгцсэн хэд хэдэн эрүүгийн хууль, хуульчилсан акт эрүүгийн эрх зүйн үндсэн эх сурвалж болж үйлчилдгээс үүдэн олон категорт гэмт үйлдэхүйн түвшин, зэрэглэл бүхэнд тохирсон ялын бодлогын уян хатан систем үйлчилдэг.<sup>25</sup> Гэмт хэргийг

24 Модельный уголовный кодекс Содружества Независимых Государств. Рекомендательный законодательный акт. М.,1996 с 14

25 Жданов Ю.Н Лиговская Е.С Европейское уголовное право. Перспективы развития М.,2001 с91 Додонов В.Н Сравнительное уголовное право общая часть М., 2009 с 261-264

категорчлон маш нарийн дэлгэрэнгүй томьёолж, ялын санкцийг шууд хэрэглэх боломжтойгоор ойлгомжтой, тодорхой зааж өгдөг тул ялыг хэрэглэх үйл явцад давхардал, хүндрэл гарах нь харьцангуй бага ажээ.

Эдүгээ эрүүтийн эрх зүйн салбарт глобальчлал, интеграцциллын үйл явц нэвтэрч эхэлсэнтэй холбоотойгоор дэлхий дахинь хэмжээний эрүүгийн загвар хууль гаргах, олон улсын хэмжээнд дагаж мөрдөх ялын бодлогын үзэл баримтлал боловсруулах ажил 2003 оноос эхлэн эрчимтэй өrnөж байна. Үүний нэг үр дун бол НҮБ-ын болон харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалын олон улсын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр В.Коннор, С.Раушь нарын редакторлож олон орны шинжээч, судлаач, эрдэмтдийн оролцоотой 2007 онд гаргасан дэлхий дахинь эрүүгийн загвар хууль мөн. Энэ загвар хууль 17 бүлэг, 200 зүйл, 300 шахам тайлбарыг өөртөө багтаасан 526 хуудас бүхий томоохон хэмжээний чухал хэрэглэгдэхүүн болжээ.<sup>26</sup>

Ялын бодлогын хувьд энэ хуулинд аль нэг системийн онцлогийг тусгаагүй, харин дундын буюу жишигийн зарчим, хандлага түлхүү тусгагджээ. Ялын төрлийт үндсэн, сонгох, нэмэлт гэсэн гурван ангилааар авч үзсэн ба ялын үндсэн төрөлд (38-р зүйл) бүх насаар нь хорих, хугацаатай хорих, торгох ялыг, сонгох ялд шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах; нийгмийн үйлчилгээнд хамруулах; гэрийн хяналтад байлгах; нэмэлт ялд торгууль, нөхөн төлбөр, эрх хасах, хянан харгалзах; үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох; иргэний харьяллаас хасах гэх мэтийг оруулжээ. Эрүүгийн загвар хуулийн 38-р зүйлийн 3-д хугацаатай хорих ялын

дээд, доод хэмжээг заахдаа 1-5 жил, 2-10 жил, 3-15, 5-25, 10-30 жил гэсэн интервалт нормативыг жишиг болгон тогтоосон байна. Загвар хуульд цаазаар авах ялыг оруулаагүй байна. Түүнчлэн ялыг оноохдоо тухайн хэргийн хор аюул, хууль зэрчсөн байдлын түвшин, хэмжээ, яллагдаж буй этгээдийн засрах боломж болон нийгмийн шудрага ёс сэргээгдсэн эсэхийг харгалzan оновчтой шийдэж байх нөхцлүүдийг заажээ. Ял нь хууль тогтоомжид эрх зүйн үндэслэлийн хувьд тодорхой томьёологдсон байхаас гадна хуулиас гадуур хэнийг ч яллаж, шийтгэж болохгүй тухай өгүүлсэн нь бий.

Ялын төрлүүдийг хэрэглэж буй орнуудын цөөнгүй хэсэг нь хүмүүнлэгийн чиглэлийн хүрээнд өөрчлөлт хийгээд эхэлжээ.

Баруун европын дийлэнх улс, орон цаазаар авах ялыг халсан ба албадан ажил хийлгэх, эд хөрөнгийг бүхэлд нь хураах ялыг хязгаарлаж, нийгмийн үйлчилгээ, хотөлбөрт хамруулах, нөхөн төлбөр оноох ялыг орлуулан сольж ялын бодлогодоо өөрчлөлт оруулжээ. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэг ба түүнд оногдуулах эрүүгийн хариуцлагыг эрүүгийн тусгай хуулиар зохицуулж буй практик Герман, Франц, Бельги, Испани, Япон, Швейцар, Австри, Португали, Канад, Англи, Эстони, Египет, Латин Америкийн зэрэг 40 шахам оронд хэрэглэгдэж байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангид тусгай бүлэг болгон оруулсан 30 шахам орон байдал. Харин криминализацийн хандлагыг дагалдан шинээр илрэх болсон авлигын болон албан тушаалын гэмт хэргүүд, хүн худалдаалах болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг, терроризм зэрэг ноцтой хүнд гэмт хэргүүдийг эрүүгийн хуулинд тусгах, ялын бодлогыг нь чангатгах тал дээр санал нэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор

26 Model Codes for Post-conflict .Criminal Justice Model Criminal code. Vivienne O'Connor and Colette Raush editors, Peasbuilding and the Rule of law . W,P,L 2007

НҮБ-ээс 2003 онд баталсан Авилгалын эсрэг конвенц, Гэмт хэргийн улмаас олсон эд зүйлсийг хураах тухай 1990 оны Страсбургийн Конвенц, 2004 оны Эрүүгийн эрх зүйн Олон улсын 17-р конгрессийн тогтоол, 1989 онд НҮБ-аас баталсан 2-р факультатив протокол зэргийг ялын бодлогыг тодорхойлоход анхаарч тусгах ёстой юм.

Ялын төрлийг хэрэглэх зарчимд туйлын тодорхой санкцийг хуульчлах явдлаасаль болох зайлсхийх; альтернатив нөхцлийг тодорхой боломжит шийдлээр зохицуулж өгөх, жижиг, хүнд биш хэргүүдийн хувьд хянан харгалзах, торгууль, нөхөн төлбөрийн ялыг өргөн хэрэглэх ба баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох (5 хоногоос 3 сар), торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх долоо хоног болон сарын дундаж орлогоор тооцох; мөнгөн дүнгээр илэрхийлэх; төрчлэн хоригоос өөр төрлийн ялыг өргөжүүлэх ял солих процедурыг оновчтой хэрэглэх зэрэг практик, жишиг гадаадын орнуудад түгээмэл нэвтэрч хэрэглэгдэж байна.

### **Хоёр. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зарим хийдэл, эрх зүйн үр дагавар**

“Хуулийн хийдэл” гэдэг нь тухайн хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөх, эрх зүйн үндэслэл, хамаарал нь харилцан авцалдахгүй байх, хуулийн зорилго, зарчим нь хуулийн агуулга нөхцөлтэйгээ тохирохгүй байх, хуулиар шууд зохицуулагдах харилцаа тийнхүү бүрэн хуульчлагдаж чадаагүйгээс эрх зүйн үйлчлэл дутагдах, хуулиас гадуурх арга, замаар хуулийт хэрэглэх зэрэг сөрөг нөхцөл, байдал бий болсныг хэлнэ.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх болсноор даруй 8 жил өнгөрчээ. 2004, 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд ихэнхдээ аль нэг гэрээ конвенцэд нэгдэн орсон, эсвэл бусад хууль тогтоомжид нэмэлт

өөрчлөлт оруулах шаардлага тэрчлэн хуулийн зарим зүйл хэсгийг нэмэх, хүчингүй болгох, өөрчлөх зэрэг техникийн болон найруулгын шинжтэй өөрчлөлтүүд зонхилжээ. Агуулга, зарчмын шинжтэй дорвитой өөрчлөлт хийгдэгүй байна.

Эрүүгийн хуулийн хийдлийн илэрч буй шинжийг дараах чиглэлээр авч үзэж болно. Юуны өмнө Ерөнхий ангийн зарим зүйл, Тусгай ангийн зүйл, заалттай нийцэхгүй байх, хэм хэмжээнүүд хоорондоо шууд ба шууд бус байдлаар зөрчилдөх явдал нилээд байна. Эдгээрийг авч үзвэл:

а) Эрүүгийн хуулийн 2-р зүйлийн 2-д: “Эрүүгийн хууль тогтоомж энэ хуулиас бүрдэнэ.” 3-р зүйлийн 1-д “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг энэ хуулиар тодорхойлно” гэж заасан. Гэтэл Тусгай ангийн бланкет диспозици бүхий далан зургаан зүйл ангийн 45 нь шууд ишлэл татсан бланкет журмаар буюу дамжмал эх сурвалжаар шийдвэрлэгдэхээр заасан нь Эрүүгийн хуулиас гадуур хуульчилсан актаар зохицуулагдах боломжийг аяндаа бий болгоход хүрчээ.<sup>27</sup>

б) Эрүүгийн хуулийн 1-р зүйлд “... нийтийн болон хувийн өмчийг гэмт халдлагаас хамгаалах тухай заажээ.” Гэтэл эрүүгийн хуулийн 145, 146, 148, 150-р зүйлүүдэд заасан хулгай, залилан, булаалт, дээрэм, ашиглалын гэмт хэргийн хохирлын доод хэмжээг бага бус буюу 108000-540000 төгрөгөөр тогтоосноос болж монголын нийгэмд харьцангуй их гарч буй бағавтар хэмжээний хохирол бүхий (30000-108000) гэмт хэргүүдийг ял завшуулах, эрүүгийн хариуцлагаас хэлтрүүлэх нөхцлийг аяндаа бий болгоход хүрсэн.

Эрүүгийн хуулийн 263, 264-р зүйлд албан тушаалаа хэтрүүлэх болон

27 “Эрх зүй” сэтгүүл 2007 №1(15) 88-р тал

урвуулах гэмт хэргийн хохирлын доод хязгаарыг үлэмж /5сая 400 мянга – 13 сая 500/ гэж тогтоосноос болж нийтийн өмчид 5 сая хүртэл төгрөгийн хохирол учруулсан /бага бус/ гэмт хэргийн үйлдэл гэмт хэрэгт тооцгдохгүй, ял хүлээхгүй болсноос албан тушаалтнууд ял завших боломж бүрдجээ. Үүний хамт албан тушаалтан бусдын өмч хөрөнгө, эд зүйлсийг завшин үрэгдүүлж бага бус хохирол учруулсаар байгаа гэмт үйлдлүүд ял хүлээхгүй байдал үүссэн байна.

в) Эрүүгийн хуулийн 5-р зүйлийн 1-д:

“Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил байдал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэж заажээ. Гэтэл Эрүүгийн хуулийн 50-р зүйлийн 4, 51-р зүйлийн 3, 52-р зүйлийн 3 зэрэгт хүний нас, хүйс, нийгмийн онцлог байдлаар нь ялыг ялгавартай тогтоохоор тусгасан байdag.

г) Эрүүгийн хуулийн 45-р зүйлийн 2-т: “Эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгэр хүлээлгэнэ” гэжээ. Гэтэл эрүүгийн хуулийн 215-р зүйлийн 1; 216-р зүйлийн 1-д зааснаар тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн ...гэмт хэрэг үйлдсэн бол “...тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах ...” гэж заасан нь 45-р зүйлтэй зөрчилдсөн төдийгүй Эрүүгийн хуульд байхгүй хариуцлагын өөр төрлийг оруулж ирсэн нь хууль зөрчсөнөөс гадна ноцтой алдаа гэж үзэх ёстай.

д) Эрүүгийн хуулийн 6-р зүйлийн 2-т: “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаагийн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэжээ.

Тэгвэл эрүүгийн хуулийн 57-р зүйлийн 1-д: “...хэрэг тус бүрт оногдуулсан ялыг хамгийн хүнд ялтай дээд хэмжээний дотор бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн ... ялыг тогтооно” гэсэн байdag. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 18, 19 болон 56-р зүйлд зааснаас үзэхэд нийлмэл, давтан болон бүлэглэн үйлдсэн хэргийн хувьд ял халдаах, нэг бус удаа ял хүлээх зэрэг үр дагавар бий болох нөхцлийг үгүйсгэхгүй байна. Зүй нь ялыг зүйлчлэх зарчим нь үйлдэл бүрт ял оноогоод, оноосон аль нэг ялын хугацааны дээд хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцох ёстой ажээ.

е) Эрүүгийн хуулийн 8-р зүйлийн 2-т: “Гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ” гэсэн байdag. Эрүүгийн хуулийн 49-р зүйлийн 1-д: “...гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ноогдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүй албадан гаргуулах...” тухай заажээ. Амьдрал дээр орон сууц, мөнгөн хадгаламж, машин, тоног төхөөрөмж, газар болон өмчлөлийн объектын ихэнхи нь хамтран өмчлөх эд зүйлсэд багтсан байdag ба жишгийн зарчмаар хүний эд хөрөнгийг бүгдийг хураах явдлыг хатуу хориглодог ажээ. Энд гэр бүлийн гишүүд, үр хүүхдийн өмчлөх эрх хөндөгдөх, түүнд халдах асуудал гарч байгааг анхаарах ёстай.

ж) Эрүүгийн хуулийн 6-р зүйлд “Шударга ёсны зарчим”, 7-р зүйлд “Энэрэнгүй ёсны зарчмын” тухай заасан боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээг бүхэлд нь авч үзвэл 90 шахам хувь нь хорих ял оногдуулах нөхцөлтэйгээр хуульчлагдсанаас гадна болгоомжгүй үйлдэгдэх зарим гэмт хэрэг, хүнд гэмт хэргийн ангилалд багтсан (128, 171, 213, 217, 224, 289, 295-р зүйл) болон хугацаатай хорих ялын доод хязгаарыг өмнөх хуулиас илүү өндөрсгөж тогтоосон; ял тэнсэх нөхцлийг

боловжит бус байдлаар хязгаарласан; Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын доод хэмжээнээс доош татаж хөнгөрүүлэх нөхцлийг үгүйсгэсэн зэрэг нь Эрүүгийн хуулийн тулгуур зарчим болон хүнлэг ёсны шаардлагад нийцэхгүй болсон.

Энэ нь амьдрал дээр ч тодорхой батлагдаж, судлаачид төдийгүй жирийн иргэдийн шүүмжлэх сэдэв болсныг харгалзах ёстой болжээ.

3) Эрүүгийн хуулийн 50-р зүйлийн 3-т: “Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатай зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын 8 цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож болно” гэж заажээ. Гэтэл 100 цагийн албадан ажил хийлгэх ял авсан этгээд түүнийг эдлэхээс зайлсхийсэн нөхцөлд баривчлах ялаар солих болоход 12 хоног баривчлах ял болох ба энэ нь Эрүүгийн хуулийн 51-р зүйлийн 2-д заасан “Баривчлах ялыг нэг сараас зургаан сар хүртэлх хугацаагаар оногдуулна” гэсэн заалттай шууд зөрчилдөж байна.

е) Эрүүгийн хуулийн 47-р зүйлийн 3-д “Торгох ялаас ноцтой зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар сольж болно” гэсэн нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 3 жилээс дээш хорих ялтай санкцийг хэрэглэх боломжгүй болох буюу ял завшуулах нөхцлийг бий болгоход хүргэжээ.

ё) Эрүүгийн хуулийн 17-р зүйлд заасан гэмт хэргийн ангиллын шалгуур, нөхцлүүд нь тусгай ангийн цөөнгүй хэсгийн зүйл ангиудтай зөрчилдөх, зарим талаар авцалдахгүй байх, хүндэвтэр, хүнд гэмт хэргийн ангилал солигдох давхардал гарах, улмаар ялын бодлогын зарчимд үл нийцсэн хийдэл гарах нөхцлийг бий болгох зэргээр илэрч байна. Судлаач болон шүүгч нарын нэг бус удаа хэлж шүүмжилж байсныг

анхаарч үзвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим зүйл заалтад ялын доод хэмжээ нь хөнгөнд, дээд хэмжээ нь хүндэвтэр ангилалд багтсан, эсхүл эсрэгээр байгаа зэрэг нь гэмт хэргийн ангилалд ялыг бүрэн дүүрэн оновчтой тохируулж чадаагүй харуулж байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 149.1; 152.1; 154.2; 183.1; 196.2; 197.1; 218.1; 230.4; 232.1; 237.1; 237.2; 246.1; 258.1; 265.1; 267.1; 271.1 гэх мэт зүйл ангид дээр дурьдсан байдлыг харж болно.

Эрүүгийн хуулийн хийдэлд хамаарахгүй боловч эдүгээ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн буюу дэлхий нийтийн жишгийн хүрээнд авч үзвэл Монгол Улсын Эрүүгийн хуулиинд “албадан ажил хийлгэх ял болон цаазаар авах ялыг хэрэглэсэн хэвээр байгаа ба насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ял нь жишгийн түвшингээс илүү чанга хатуу байгаа зэргийг анхаарч үзэх нь зүйтэй юм.

#### **Гурав. Шүүхийн практик ба зарим нөхцөл байдал**

Сүүлийн 20 жилийн судалгаа практикаас үзэхэд шүүхээр оногдуулсан нийт ялын 70 шахам хувь нь хорих ял эзэлж байгаа ба түүнийхээ 50 гаруй хувийг тэнсэн харгалзаж үлдсэн 20 хувийг биечлэн эдлүүлдэг байна.<sup>28</sup>

2009 онд 7513 хүн шүүхээс ял шийтгүүлсний 5442 нь хорих ял, шийтгүүлсэнээс нь 3074 нь хорих ялыг биечлэн эзэлж 2013 хүн тэнсэн суллагдаж, 305 хүний тогтоол биецуулэхийг хойшлуулж, 350 хүн өршөөлөөр суллагджээ. Түүнчлэн 1771 хүн хорихоос өөр терлийн ял эдэлснээс 260 хүн торгох ялаар, 337 хүн албадан ажил хийлгэх ялаар, 1099 хүн баривчлах ялаар шийтгүүлжээ. Статистикийн турван жил тутмын дундаж жишгээс

28 УДШ-ийн тайлан болон судалгааны материал 2008-2010 /Д.Б./

харьцуулан түүвэрлэж узэхэд эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолын 52.2-54.7 хувь нь хэвээр үлдэж, 45.3-47.8 хувь нь хүчингүй болох буюу өөрчлөгдөж ирсэн нь ялын бодлогын шийдлийн үнэн зөв, тогтвортой байдал ихээхэн алдагдах болсныг харуулж байна.

Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгээс 2006 онд 11 аймаг, 7 дүүргийн 860 хүний хамруулсан социологийн судалгааны мэдээ, сэлтээс үзэхэд 41.7 хувь нь шүүх шийдвэр гаргахдаа шударга бус ханддаг гэсэн хариулт өгчээ.<sup>29</sup>

2008-2009 онд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт гэмт хэргийн 58.4 хувийг хүндэвтэр хэрэг эзэлж байгаагийн дээр нийт шийтгүүлсэн хүмүүсийн 26 хувь нь хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ажээ. Шүүхийн шатанд хэргийг мөрдөн байцаалтад буцаах явдал сүүлийн 5 жилийн байдлаар 58 хувийг эзэлж байгаа нь хүнийг нэг удаа шийтгэх буюу нэг удаа яллах зарчим алдагдаж ирсний нотолгоо бөгөөд ялыг гагцхүү шүүхийн процессийн журмаар, нотлогдсон хэрэгт гагцхүү шүүхээс хараат бусаар хянаж шийдэх ёстой гэсэн олон улсын эрх зүйн зарчим хангагдахгүй явж ирсний илрэл юм.<sup>30</sup>

“Хөгжингүй орнуудад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд аль болох нийгмээс тусгаарлалгүйгээр хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхийг зорьдогийн илэрхийлэл нь нийт ялын 80 гаруй хувийг торгох ба хорихоос өөр төрлийн ял эзэлдгээр илрэх бөгөөд харин манайд бол эсрэгээр нийт ялын 70 хувийг хорих ял эзэлж байна.”<sup>31</sup>

29 УДШ-ийн тайлан, судалгааны материал 2008-2010 /Д.Б/

30 Шудрага ёс сэтгүүл 2010 №1(2) 16-р тал

31 Харьцуулсан эрх зүйн онол , практикийн орчин үеийн асуудал . Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал УБ. 2007 82-р тал

Монгол Улсын Эрүүгийн хууль үйлчилснээс хойших УДШ-ээс 30 шахам тайлбар гарч бүрэн бус судалгаагаар 300 шахам нэр томьёог тайлбарлажээ. Эрүүгийн хуулинд тодорхой бус байдлаар буюу хоёрдмол утгатай хуульчлагдсан нэр томьёог хуулинд байхгүй агуулга, зарчмаар тайлбарлах нь эргээд хуулийн хийдэл газар авах нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд жишгийн зарчимд нийцүүлэн хэргийн нөхцлийг шийдвэрлэх (процессийн) байдлаар тайлбарлах практикийг нэвтрүүлэх нь манай нөхцөлд зөв сонголт байж болох юм.

Эцэст дүгнэлт болгож зарим саналыг дэвшүүлэхэд:

- 1) Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үзэл баримтлалыг боловсруулахдаа ялын бодлогод зоримог реформ хийх чиглэлийг тууштай баримтлах нь зүйтэй юм. Юуны өмнө Эрүүгийн хуулинд хорих ялын эзлэх хувийн жинг дэлхий нийтийн стандарт (40-45%) жишгээс дээшгүй байхаар томьёолох; хорихоос өөр төрлийн ялын санкцын үр нөлөөтэй хэлбэрүүдийг, уян хатан, хэрэглэх боломжтойгоор хуульчлах;
- 2) Эрүүгийн хуулинд байгаа эрх зүйн бүхий л хийдлүүдийг бүрэн засч арилгах;
- 3) Насанд хүрээгүй этгээдэд оногдуулах ялын дэглэмийг тусгай бүлэг болгон ялгавартайгаар хуульчлах;
- 4) Хуулийн этгээдэд эрүүгийн ял оноож буй гадаадын 35 орны туршлага, жишгийг сайтар судалсны үндсэн дээр аж ахуй болон экологи, эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон хуулийн этгээдэд өндөр торгууль оноож болох заалтыг эрүүгийн хуулинд нэмж томьёолох;

5) Эрүүгийн хуулийн шинэтгэлийг хийхдээ ганц нэг нэмэлт, өөрчлөлт оруулах төдийгээр уг үйл явцыг хязгаарлаж болохгүй бөгөөд Эрүүгийн хуулийн шинэтгэлийн хөтөлбөр, үзэл баримтлалыг төрийн бодлогын түвшинд боловсруулж, УИХ-аар батлуулах, улмаар Эх газрын эрх зүйн тогтолцооны жишгээр зэрэгцсэн эрүүгийн хуулийн тогтолцоог шинээр бий болгох, ингэхдээ үүнийг үе шаттайгаар хэрэгжүүлж, эхний ээлжинд Эрүүгийн төрөлжсөн ерөнхий хуулийг Европын жишигийн загвараар боловсруулж гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

6) Одоо мөрдөж буй УДШ-ийн тайлбаруудыг нарийн нягт судалж, нэр томъёоны аливаа тайлбарыг Эрүүгийн хуулийн дагалдах хууль болгон оруулж байх практик бий болгох нь хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох нь дамжигтгүй.

Эцэст нь тэмдэглэхэд ялын бодлого эznээ олсон, үр дүнтэй, тогтвортой, шударга, оновчтой бөгөөд нийгмийн ашиг сонирхолд бүрнээ нийцсэн байх нь Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинэтгэлд чухал хүчин зүйл болно.

ТИ-ИЙН АЖЛЫН БАРИМТ БИЧИГ №04/2008

## АВЛИГА БА АЮУЛГҮЙ(ТАЙ) БАЙДАЛ

### Агуулга

1. Аюулгүй байдлыг хамгаалах шаардлага өсч байгаа нь
2. Авлигаас үүсэх эрсдлийн сүлжээний илрэл
3. Авлигаас аюулгүй байдалд учруулах аюулыг ойлгох нь
4. Тулгарч буй бэрхшээлийг давах

Гадаадын түрэмгийллийн аюул нь улс орнуудын аюулгүй байдлыг хангахад анхаарч буй цорын ганц голлох асуудал биш болоод байна. Учирч болзошгүй аюулын жагсаалтад төрийн бус этгээд болон террорист бүлэглэлүүд орохын зэрэгцээ нийгэм, эдийн засгийн болон байгаль орчны шинжтэй аюулууд орж ирж байна. Эдгээр аюул дарамт нь дотоод ба гадаад гаралтайгаас үл хамааран хүчирхийлэл болон авлигыг газар авхуулж, үндэсний аюулгүй байдлыг сулруулах, дэлхийн системийг тогтвортгүй болгох эрсдэл бий богож байна.

Аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үүднээс дэлхийн улс орнууд нь дээрх аюулыг авлига хэрхэн үүсгэж, газар авхуулж өрнүүлдэгийг тогтоож, хариу арга хэмжээ авах ёстой. Зарим улс оронд авлига нь аюулгүй байдлалд заналхийлэх хүчин зүйлс болоод байна. Зэр зэвсгийн наймаа хийдэг этгээдүүд нь олсон ийнхүү хууль бус орлогыг хил дамжин ороход хахуульдахад ашиглаж, улмаар тэр улсуудын эсрэг хүчирхийллийн үйл ажиллагаа явуулж байна. Нөгөөтэйгүүр

авлига нь аюулгүй байдал сулрах шалтгаан болдог. Төрийн байгууллага нь засгийн эрхээ хадгалахын тулд авлига үйлдэж эхэлвэл тэр хэрээр аюулын эх сурвалж болж болно, учир нь тэр өөрөө улс төрийн, нийгмийн болон эдийн засгийн зөрчил тэмцэл ба үймээн самууныг хөөргөн дэгдээх хүчин зүйл болдог юм.

Авлигатай тэмцэх арга барил болон аюулгүй байдлыг хангах бодлого аль алиin нь дээрх харилцаа холбоог хэрхэхийг шийдэж, дотооддоо болон гадаадаас аюулгүй байдалд учирч буй эрсдлийн учир шалтгааныг илүү өргөн өнцөгөөс авч үзэх шаардлагатай байна.

### 21 дүгээр зуунд аюулгүй байдлыг шинээр тодорхойлох нь

“Аюулгүй байдал” гэдэг ойлголт нь гаднаас учрах аюул болон эрсдлээс нэг улс, бүлэг улсыг, тэдгээрийн иргэд, нутаг дэвсгэр болон эд хөрөнгийг хамгаалахыг хэлдэг байжээ. Эдгээр аюул болон эрсдэл нь цэргийн буюу цэргийн бус шинжтэй байх бөгөөд янз бүрийн этгээд буюу салбараас үүсэн гарч болно.

Энэхүү ойлголтод тулгуурлан үзвэл аюулгүй байдлыг хангах ажил нь урьдчилан сэргийлэх ба хамгаалах шинжтэй ажиллагаа болон бодлогоос бүрдэнэ. Энэ ажлыг тухайн улсын цагдаа, цэрэг болон иргэний зохих байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Харин аюулгүй байдлыг түүнд хамаарах өргөн орчин, нөхцөл байдалтай нь уялдуулан авч үзвэл

аюулгүй байдалд нэлөөлөх дотроо харилцан холбоотой олон нөхцөл байдлыг олж харах болно. Ойлголтын энэ өөрчлөлт нь зэвсэглэл бол аюулгүй байдлыг хангах ба түүнд аюул учруулах үндсэн шалтгаан, зөрчил тэмцэл бол зөвхөн улс хооронд үүсэх явдал гэсэн хуучинсаг ойлголтоос зайлсхийснийг илэрхийлж байгаа юм.

Энэ шинэ ойлголт нь нийгмийн, улс төрийн, эдийн застийн, технологийн болон байгаль орчны хүчин зүйл аюулгүй байдалд өргөн хүрээний ба хор хөнөөлтэй эрсдэл бусад хүчин зүйлийн адилаар учруулдагийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд улс орнууд тэдгээрээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ба хариу арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

#### Аюулгүй байдлыг хангах үйл явцын төвд хүн орших нь

Зөвхөн гадаадын түрэмгийллийн эсрэг төр улс хэрхэн өөрийгөө хамгаалж ирснийг судлахын хажуугаар “хүний аюулгүй байдлыг хангах” гэсэн альтернатив үзэл санаа гарч ирсэн байна. Энэ үзэл баримтлал нь иргэний дайн, аймаглан устгах, хүн амыг үй олноор хөөн нүүлгэх зэрэг өргөн хүрээний аюулаас хувь хүн болон хүн амын бүлгийг хэрхэн хамгаалах асуудлыг анхаарч үздэг юм.

Гаргасан хүчин чармайлт нь хувь хүн, хүн амын бүлэг, улс орны хэвийн амьдрал болон амьжирагаанд аюул учруулсан бэрхшээлтэй асуудлын шалтгааныг тогтоож, хариу арга хэмжээ авахад чиглэгднэ.

Бодлогын хүрээнд авах хариу арга хэмжээнд буюу шийдэлд эдийн застийн хөгжил, нийгмийн шудрага ёс, шүүхийн шинэчлэл, зэвсэг хураах болон хүний эрхийг хүндэтгэх явдал багтана.

#### 1. Аюулгүй байдлыг хамгаалах шаардлага өсч байгаа нь

Үндэсний аюулгүй байдлын тухай цэргийн уламжлалт ойлголт нь хоцрогдож, ард иргэд болон бүлэг хумүүст учирч буй өргөн хүрээний аюул эрсдлийг өөртөө хамаардаг болсон байна (дээр буй хүснэгтийг үзнэ үү). Авлигыг дагалдах бүтээгдэхүүн болох контрабандын наймаа, цагаачид ба дөрвөгсдийн хяналтгүй урсгал, төрөөс турхисан хүчирхийлэл, будлиантай сонгууль, нийтийг хамарсан халдварт өвчин, байгаль орчны сүйрэл зэрэг нь аюулгүй байдлыг хангахад анхаарвал зохих асуудлын жагсаалтыг өнөөдөр бүрдүүлж байна.

Аюулгүй байдалд учрах эрсдэл болон авлига хоорондоо холилдсон тохиолдолд цөөн тооны хүний эрх ашигт зориулан олон сая хүний аюулгүй байдлыг золиослох нөхцөл бий болж болно. Авлигын нэг үйлдэл нь аюулгүй байдлыг эрсдүүлэх ба тогтвортой байдлыг алдагдуулах хойно хойноосоо цуварсан үйл явдлыг эхлүүлж чадна. Шан харамж болон хээл хахууль өгсөнөөр террористууд улсын хилээр нэвтэрч, зорьсон газраа хүрч болох бөгөөд ийм хэргийг Кени улсаас ОХУ, Мароккогоос Тайланд хүртэлх нутаг дэвсгэрт олонтаа тогтоож баримтжуулж авсан билээ. Гэмт бүлэглэлийн сүлжээнүүд нь шан харамж өгч контрабандын бараа зөөж, худалдсан орлогоосоо төрийн эсрэг үйл ажиллагааг хэрхэн санхүүжүүлж болдогийг Армени, Азербайжан болон Гүрж дэх зэвсэгт бүлэглэдүүдийн ажиллагаанаас харж болно. Байгалийн баялагаас олсон үндэсний орлогыг улс төрчид хулгайлж цэргийнхэнд зориулж, зэр зэвсэг худалдан авахад зориулж, улмаар хоёр застийн газрын хүч нөлөөг тэнцвэржүүлэн хадгалж байгааг Судан болон Чад улсад харж болно. Эдгээр байдал нь, үйлдэж буй авлигын бүх

төрөл нь дурдсан улс орнуудын аюулгүй байдлыг хангах өргөн хүрээний үйл ажиллагаанд янз бүрийн байдлаар нөлөөлдгүй илтгэж байна.

## 2. Авлигаас үүсэх эрсдлийн сүлжээний илрэл

Асуудлыг “авлига болон аюулгүй байдал” гэсэн өргөн хүрээнд авч үзвэл авлига нь дэлхий, бус нутаг болон үндэсний хэмжээний аюулгүй байдалд учрах эрсдлийг болж, нөхцөлдүүлж байна. Хариуцлага тооцох механизм сүл байх, ил тод бус байх, авлигад өргөнөөр автагдах, аюулгүй байдал хангагдахгүй байх үзэгдлүүд нэг улсад нэгэн зэрэг гардаг нь тохиолдлын хэрэг биш гэдгийг олон судалгаа харуулж байна. Авлига нь олон төвшинд байгаа янз бүрийн этгээдийг нэг сүлжээнд оруулж, аюулгүй байдлыг хангах суурь баганууд болох улс төр, цэрэг, нийгмийн болон байгаль орчны аюулгүй байдлыг аажим аажмаар доройтуулж унагаадаг байна:

- Улс төрийн хүрээнд: Улс төрийн албан тушаалтан, нэр дэвшигчид, шүүгчид болон цагдаагийн байгууллагыг “худалдан авах”. Үүнд зориулах мөнгийг хар тамхины наймаачид, бизнесмен, улс төрийн элитийн хүчирхэг бүлэглэлээс авах бөгөөд аюулгүй байдлыг хангахтай холбоотой улс төрийн шийдвэрийг будлиantuлах, саатуулахад ашиглах болно.
- Цэргийнхний хүрээнд: Яамд буюу хувь гэрээлэгчид нь төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг хяналтгүйгээр, эргэж тайлагнахгүйгээр ба учир битүүлэг байдлаар худалдан авах.
- Нийгмийн хүрээнд: Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд нь хүн худалдаалах, зэвсгийн наймаа хийх зэрэгт өөрийн хүч нөлөө болон хээл хахуулийг

ашиглах (3 дахь хүснэгтэд байгаа нэмэлт тайлбарыг үзнэ үү).

- Эдийн засгийн хүрээнд: Байгалийн баялагаас олсон нийтийн хөрөнгөөс хулгайлсан мөнгийг цэрэгжсэн зэвсэгт бүлэг буюу босогчдыг санхүүжүүлэхэд зориулах.
- Байгаль орчны хүрээнд: Төр, засгийн байгууллага болон компаниудад хээл хахууль өгсөнөөр аюултай хаягдал болон материалыг ядуу дорой хүн амтай газар нутагт хаях, булшлах.

Эдгээр эрсдлийг арилган зайлцуулах үйл явцад төр засгийн байгууллага нь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх тустай этгээд байхын зэрэгцээ үүнд саад бэрхшээл учруулагч нэгэн зэрэг болж болно. БНХАУ, Чили, Герман болон Йордан улсуудын хувьд авлигатай тэмцэх засгийн газрын манлайлсан хүчин чармайлтын үр дунд төрийн аюулгүй байдалд учрах хэд хэдэн эрсдлийг арилгах алхам хийсэн байна. Бусад улсын тохиолдолд засгийн газрууд нь өөрийн улсын иргэдийн аюулгүй байдлыг золислож үндэсний, бус нутгийн болон дэлхийн хэмжээний аюул, түгшүүр тарьж өөхшүүлэхэд авлигыг системтэйгээр ашиглах ирсэн байна.

Транспэрэнси Интернэшилийн гаргасан 2008 оны Авлигын Төсөөллийн Индексийн хамгийн доод 5 хүртэлх хувийн бүлэгт Чад улс (1.6), Конгийн Ардчилсан БНУ (1.7), Мианмар (1.3) болон Судан улс (1.6) багтаж байна. Эдгээр улсын төр засаг нь өөрийн улсын иргэдийн эсрэг хүчирхийлэл хамгийн их хэрэглэдэг төр засгийн байгууллагын тоонд ордог байна.

Үүний зэрэгцээ харьцангуй тогтвортой ба сайн төр засагтай улсад авлига гаарч, аюул бүхий байдалд орж болно, тухайлбал хариуцлага тооцох механизм сүл, ил тод бус байдал ба

тууштай шудрага байх зарчмууд алдагдсан нөхцөлд ийм байдалд хүргэнэ. Саяхан АНУ болон Их Британид үл мэдрэгдэх гадаргуйн үйлдвэрлэх батлан хамгаалах аж үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан хэрэг зөрчлүүд нь авлига ямар хүрээнд явагдаж байгаагийн дэндүү тод жишээ юм. Ялангуяа Ирак улсад АНУ-ын хийж буй хэлцлүүд нь сүүлийн үед байнгын хатуу хяналтад орсон байгаа, учир нь АНУ болон Иракийн засгийн газруудын бодлогыг эргэлзээнд оруулсан хэд хэдэн цэргийн болон шатахуун түлшний тухай сэжиг бүхий гэрээ хэлцэл урьд нь илэрсэн юм. Иракийн Сэргээн Босголтын Сангийн Ерөнхий байцаагчийн хийсэн нэг судалгаагаар Эвслийн Тур Удирдах Байгууллага нь 88.1 сая ам.долларын үнэ бүхий гэрээнүүдийг зөрчилтэй байгуулж, наад зах нь 11 төсөлд илүү хөрөнгө зарцуулж, 36 сая ам.долларын зэвсэг болон сум хэрэгсэл дутагдсаныг тогтоожээ. АНУ болон Иракийн аль алиных нь төрийн албаны болон хувийн хэвшлийн этгээдүүд эдгээр зөрчилд холбоотой гэж буруутгагдсан байна. Транспэрэнси Интернэшилийн 2007 оны Дэлхийн Нийтийн Авлигын Хэмжүүр (Барометр) судалгаагаар эдгээр зөрчил болон бусад төрлийн авлигыг АНУ-ын засгийн газар устгах чадваргүй гэж АНУ-ын олон иргэд үздэг бөгөөд энэ үзүүлэлт нь уг улсыг ийм төрлийн зөрчилтэй муу тэмдэг орнуудын эгнээнд оруулж, жишээлбэл Аргентин, Албани болон ОХУ-ын нэг төвшинд аваачсан байна.

**Зохион байгуулалттай гэмт хэрэг:**  
Үндэстэн хоорондын хэмжээнд үүсэх эрсдэл

Европын Холбооны (EX) гишүүн орнуудад хийсэн олон нийтийн цуврал судалгаагаар зохион байгуулалттай гэмт хэрэг, үүнд авлигын гүйцэтгэх рольд иргэд ихээхэн санаа зовниж байгааг тогтоожээ.

Эдгээр улсад хийсэн 2007 оны Евробарометрын судалгаанаас үзвэл зохион байгуулалттай гэмт хэрэг болон терроризмын асуудлыг хөрш зэрэглээ орнуудтай хамтран шийдвэрлэх тэргүүн ээлжийн асуудал (асуулгад орсон хүмүүсийн 61 хувь) гэж заасан байна. EX-ны гишүүн орнуудын хувьд зохион байгуулалттай гэмт хэрэг болон терроризмтэй тэмцэх нь үндэсний бодлогын хамгийн их онцлон тэмдэглэсэн гуравдахь асуудал (23 хувь) болсон бөгөөд үүний өмнө гагчхүү нийгмийн шудрага ёсыг хангах (43 хувь) болон энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах (27 хувь) асуудлууд оржээ.

Эдгээр үзүүлэлтүүд нь өмнөх 2005 оны Евробарометрын үр дунг давтаж байна, тухайлбал EX-ны иргэдийн талаас дээш хувь (54 хувь) нь авлига бол тэдгээрийн улс оронд байгаа зохион байгуулалттай гэмт хэргийн хөдөлгөгч хүч гэж үзсээр байна.

Жишээ нь EX дахь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, ялангуяа Албани, Румын болон Туркээс ирсэн бүлэглэлүүд нь хүн худалдаалах сүлжээнд хоорондоо нэгдэж, улмаар улс хооронд гэмт хэргийн хохирогчдыг тээвэрлэхийн тулд хилийн хамгаалалтын албаныханд хээл хахууль олонтаа өгч, хувийн танил талын сүлжээгээ идэвхтэй ашигладаг байна.

“Хил гаалийн, цагдаагийн болон аюулгүй байдлыг хангах мэргэжилтнүүд авлигад автсан тохиолдолд ямарч орчин үеийн үнэтэй тоног төхөөрөмж нь манай иргэдийн эдэлвэл зохих аюулгүй байдлыг хангаж чадахгүй. Хэрэв авлигач төрийн албан хаагчид хувийн байдлыг нотлох хуурамч баримт бичиг гаргаж өгсөн бол террористууд дэлхийгээр чөлөөтэй зорчих бөгөөд бүх улс орны нийгэмд аюул учирна.”

- Рон Нобль (*Ron Noble*), Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга

**3. Авлигаас аюулгүй байдалд учруулах аюулыг ойлгох нь**

Улс орнуудын аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө, үүний дотор улсын хил хамгаалах болон батлан хамгаалах асуудалтай холбоотой уламжлалт бодлого нь авлигатай тэмцэх бодлоготой гайхал төрүүлмээр холбоогүй явж ирсэн байна. Өнөө уед улсын аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу боловсруулсан аливаа бодлого нь авлигын хүчин зүйл нөлөөлсөн тохиолдолд маш хангалтгүй гаж үр дун бий болгох талтай юм.

Түүнчлэн, авлига нь улс төрийн, цэргийн, нийгмийн, эдийн застийн болон байгаль орчны асуудлуудыг нэг дор нэгтгэснээр улс орон болон иргэдэд учрах аюулгүй байдлын эрдлийг нөхцөлүүлэхийн зэрэгцээ уг эрдлийг нэмэгдүүлж болно. Аль ч тохиолдолд аюулгүй байдал доройтох сурдрах нь авлига өсөхөд хүргэж эцэс төгсгөлгүй хэрэг зөрчлийн давтамж бий болгоно. Төр застийн байгууллагууд иргэдийн дунд үүсэх “аюул түгшүүр, айдас”-ын (бодит ба зохиомол) мэдрэмжийг ашиглаж, “үндэсний аюулгүй байдлыг хангах” лоозонг элдэв зөрчил дутагдлыг нуун дарагдуулах ба мэдээлэл олж авахад ашиглаж болно. Гэтэл эдгээр үйлдэл нь аюулгүй байдалд учрах аюул, эрсдэл нэмэгдэхэд нөлөөлнө. Ийм ойлгомжгүй, бүрхэг байдал нь аюулгүй байдлыг хангах уламжлалт аргын төсөв нэмэгдэхэд хүргэнэ. Сүүлийн 10 жилд дэлхийн цэргийн зардал 37 хувиар ессөн бөгөөд одоогийн бүх зардлын талаас дээш хувийг АНУ гаргаж байна.

“Бүх юмыг нууцлах нь төр застийн хүмүүс хууль бусаар баяжсанаа нуухад энэ аргыг ашиглаагүй байсан ч авлигын нэг хэлбэр юм. Төр застийн байгууллага нь улсынхаа төсвийг хэрхэн зарцуулснаа нийтэд мэдээлэхээс татгалзах тохиолдолд

тэд бус нутаг, улс орнуудын хөгжилд зориулсан эд хөрөнгийг хамгийн оновчтой байдлаар ашиглаж байгаа гэдэгт бид яаж итгэлтэй байж чадах билээ?”

- Оскар Ариас (*Oscar Arias*), Энх тайвны Нобелийн шатгалтан, Коста Рик улсын Ерөнхийлөгч

Авлига нь аюулгүй байдлыг дараах суваг болон этгээдээр дамжуулан доройтуулан сулзуулж болно:

- Хүчирхийлэл, түрэмгийллийг нэмэгдүүлэх хүчин зүйл. Хээл хахуулийг цөмийн зэвсэг олж авах явдлыг хөнгөвлөх ба улс орон (ихэнхдээ шилжилтэд байгаа буюу сул дорой улс) зэвсэглэхэд ашиглаж байна. Хуучин Зөвлөлт Холбоот Улсын зарим бүгд найрамдах улс (жишээ нь Беларус, Гүрж, Тажикистан) болон Пакистан зэрэг бусад улс эдгээр үхлийн аюултай эд материалыг гадаадад гаргадаг улсуудын жагсаалтыг тэргүүлж байна. Түүнчлэн хилийн ба нийтийн тээврийн аюулгүй байдлын шалган нэвтрүүлэх цэгт хээл хахууль өгч үндэсний хилээр террористууд чөлөөтэй нэвтэрч, террорист ажиллагаа явуулах боломжтой болж байна. Жишээлбэл, оросын мөрдөн байцаагчдын тогтоосноор Чечений үймэн дэгдээгчид 2004 онд нисэх онгоцонд террорист халдлага хийхийн тулд 180 ам.доллартай тэнцэхтэй үгүйтэй хээл хахууль өгч, зохих хувийн баримт бичигтүйгээр уг онгоцонд орж гэмт үйлдлээ хийх боломжтой болсныг тогтоосон байна.
- Гол гол салбаруудад зориулах застийн газрын төсөв хөрөнгийг бууруулах. Шийдвэр гаргах төвшинд авлига нөлөөлөх тохиолдолд аюулгүй байдлын өргөн хүрээний асуудал зохицуулахад зориулагдах хязгаарлагдмал байгаа төсөв хөрөнгө

багасч, зүй бусаар зарцуулагдаж, хувийн хэрэгцээнд ашиглагдана. Жишээ нь, судалгаанаас үзэхэд авлига нь улсын төсвийн зардлыг суурь нийгмийн үйлчилгээнд зориулахыг болиулж, харин батлан хамгаалахын санхүүжилтэд түлхүү чиглүүлдэг нь эдгээр зардал тус бүрт улсын орлогоос хуваарилдаг хөрөнгийн хувь хэмжээнээс харагдаж байна.

- Төр, зас гийн байгууллагад хариуцлага тооцох боломж хомсдох. Гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийт иргэдээс олгосон хэр хэмжээнээс хэтрүүлж, улмаар цэрэгтэй холбоотой төр, засгийн шийдвэр ба бусад салбарын үйл ажиллагааны талаар тайлан тавих асуудлаас зайлхад ашиглана. Ажлаа хязгаарлагдмал байдлаар тайлагнах нөхцөлд зэвсгийн наймаа болон цэргийн дэмжлэг туслалцааг тодорхой бус шалгуур үзүүлэлт ашиглан, битүүлэг байдлаар шийдвэр гаргадаг болно. Цэргийн гэрээлэгчид болон бус нутгийн хэмжээний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тэдгээрийн үйл ажиллагааг чиглүүлэх зохих хяналт, хамгаалалтгүй болж, улмаар хэрэгжихгүй болох талтай.
- Мэдээлэл олж авах боломжийг хязгаарлах. Аюулгүй байдал буурч байна гэсэн ойлголт гүнзгийрэх тутам “үндэсний аюулгүй байдал”-ын ойлголтыг төр засгийн байгууллагууд эсрэгээр ашиглаж, авлигын үйл ажиллагааг нийтэд мэдээлэхээс сэргийлэх буюу бусдын дургүйцлиг нугчин дараход ашиглаж болох юм. “Аюулгүй байдлыг хангах” хаалтыг ашигласнаар батлан хамгаалахын гэрээт захиалгыг олгох зэрэг асуудлаарх мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийж болно. Дайнгүй тайван үед ч гэсэн төрийн “аюулгүй байдлыг хангах” үйл ажиллагаа нийгмийн анхаарлын гадна байнга

байх ёстой гэж үзэж ирсэн. Жишээлвэл, Олон Улсын Валютын Сан болон Дэлхийн Банк аль алин нь боловсрол, эрүүл мэнд, шүүхийн үйл ажиллагаа болон олон тооны бусад салбарын зардлыг ил тод байлгахыг дэлхийн улс орнуудаас хүсэн хүлээдэг боловч нийтийн санхүүгийн дүрэм журмын хүрээнд батлан хамгаалахын зардлыг тайлагнахыг тэднээс шаарддаггүй.

- Хариуцлагаас зайлх явдлыг өөхшүүлэх. Ялангуяа дайны буюу үймээн самууны үед иргэний эрх болон зохих ёсны хэм хэмжээг “тероризм”-ээс сэргийлэх нэрийн дор, эсхүл “үндэсний аюулгүй байдлыг хангах” нэрийдлээр зөрчиж болдог, энэ нөхцөлд хувийн нь аюулгүй байдал хэдийнээ эрсдэлд орсон байdag учир иргэд нь авлигын хэргийг илчилж, мэдээлж чаддаггүй юм. 2006 онд ОХУ-д батлагдсан хуулийн дагуу экстремизм гэдэг ойлголтод одоо төрийн албан тушаалтныг шүүмжилсэн аливаа шүүмжлэлийг багтаасан байна. БНХАУ, Йордан, Непал, АНУ зэрэг улсад авч буй терроризмын эсрэг арга хэмжээний хүрээнд улс төрийн эсэргүүцлийн тодорхой үйлдлүүдийг шинээр авч үзэж хуулиар хянаж байх зүйл болгож ангилсан байна. Эрх зүйн хамгаалалт ийнхүү суларсан нөхцөлд санал бодлоо илэрхийлэх эрх чөлөө хамгийн ихээр хохирдог юм. Олж авсан мэдээллийнхээ эх сурвалжийг илгээн мэдэгдэх, эсхүл уг мэдээллийг огт нийтлэхгүй байхыг хэвлэл мэдээллийн байгууллагаас албадан шаардаж болно. Хэдийгээр дэлхийн 100 улс сэтгүүлчдийг болон тэдгээрийн мэдээллийн эх сурвалжийг хамгаалах хуультай байdag боловч эдгээр улсын жагсаалтад АНУ, Канад, Нидерланд болон Ирланд багтдаггүй нь хачирхалтай.

Авлига нь аюулгүй байдлыг сулруулж, доройтуулах шалтгаан болж өгдөг: энэ нь авлига тогтолцооны шинжтэй болж, төр засгийн байгууллага өөрөө уг бэрхшээлийн үүсгүүр болсон нөхцөлд ил тод харагдана. Ийм тохиолдолд авлига нь дараах зүйлд хүргэнэ:

- Аюулгүй байдалд учирсан аюулыг хурцатгах. Олон улсын худалдааны ургалын нэгээс доош хувийг бүрдүүлдэг хэдий ч дэлхийн хэмжээнд үйлдсэн авлига бүхий нийт хэлцлийн 50 хувь нь зэвсгийн экспорттой холбоотой байдаг юм. Авлига нь ямар нэг захиалсан зэвстийн бараа бүтээгдэхүүнийг хяналтгүйгээр нийлүүлэх ба зэвстийг хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг “цэцэглүүлэх” нөхцлийг бий болгодог. Жижиг зэвсгийн наймааг дангаар нь авч үзэхэд л хууль бус наймааны нийт орлогын хэмжээ жилд 10 тэрбум амдолларт хүрдэг гэсэн тооцоо байна. Экспортод тавих сул хяналт болон хууль бус наймаа нь тухайн улс өөрийн түнш болон бараа нийлүүлэгчид хууль ёсоор илгээсэн зэвсэг уг улсын аюулгүй байдалд хамгийн их аюул учруулж буй этгээдийн гарти очиход хүргэж болзошгүй юм, ийм явдал Колумб, Панам, Ирак, Сомали, Гаити болон Афганистанд учирсан байна. Зохицуулалтын “цоорхой”-г арилгах ба зэвсгийн наймааны зөрчилтэй бусад асуудлыг зохицуулахад чиглэгдсэн НҮБ-ын конвенци гаргах талаар томоохон алхам хийгдсэн боловч энэ санаачлага АНУ зэрэг зэр зэвстийн томоохон экспортлогчдын эсэргүүцэлтэй тулгарсан учир одоогоор урагш явахгүй байна.
- Зөрчил тэмцлийг тэтгэж, газар авхуулах. Төр засгийн төлөөлөгчид улсын өмч хөрөнгийг байнга системтэйгээр хулгайлаж ба шамшигдуулах нь иргэдийн дунд дургуйцэл болон зөрчил тэмцэл бий болгодог юм. Үүнийг Индонези, Нигери зэрэг байгалийн баялаг ихтэй улс дахь салан тусгаарлах хөдөлгөөн тод яруу харуулж байна. Өнгөрсөн хугацаанд авлигаар олсон ийм мөнгийг босогчдыг шууд дэмжих (Афганистан, Ирак), иргэдрүү харгислан дайрах (Судан) ба үймэн тэмцэл гадагш экспортлоход (Либери) ашигласан байна. Энэ ажиллагаанд төрийн бус этгээд мөн оролцож ирсэн бөгөөд тэдгээр нь хүчирхийллийг санхүүжүүлэхийн тулд мансууруулах бодис зарах, контрабанд хийх болон хүн наймаалах ажиллагаанаас олсон орлогоо ашиглаж байна. Жишээ нь Колумб улс дахь Транспэрэнси Интернэшилийн Үндэсний салбар нь мансууруулах бодисны худалдаа, зэвсэгт босогчид болон тухайн улсын төрийн дэглэм хоорондын хэлхээ холбоог шинжлэн судалсан байна.
- Төрийг “барыцаалах болон урвуулан ашиглахыг” хөхиүлэн дэмжих. Тоглоомын дүрмийг авлига тогтоож байгаа нөхцөлд улсын төсвийн зардлыг нэмэх нь тэр болгон аюулгүй байдлыг хангах илүү үр өгөөжтэй бодлого хэрэгжүүлж байна гэсэн үг биш юм. Цэргийн холбоотон улсдаа донор улсаас олгох тусlamжийн урстальг нэмэгдүүлье гэж бодоход хэрэв тухайн тусlamж хүлээн авагч улсын төр засгийн байгууллага авлигад идэгдсэн бол дээрх зардлын үр өгөөж болон үр дүнгийн тогтвортой байдал нь үтгүйсгэгдэх талтай. Жишээлвэл, хулгайч төр засгатай улс орнуудын цэргийн хөрөнгө санхүүжилтийг өсгөх нь гагцхүү нийтийн дэмжлэгтүй төр засгийг бэхжүүлэх ба аюултай байдлыг нэмэгдүүлэх ашиг сонирхолд үйлчилнэ.
- Бус нутаг, дэлхийн тогтвортой байдлыг сулруулна. Ливан, Пакистан, Судан, Конго зэрэг хоорондоо ялгаатай улсууд нь дотоодынх нь

авлига олон улсын аюулгүй байдал болон дэлхийн энх тайванд аюул учруулсан үндэстнүүдийн сүлжээний нэг хэсгийг бүрдүүлж байна. Эдгээр улс нь зөрчлийг урьдчилан сэргийлэх ба шийдвэрлэх, энх тайвныг хоёр талын хүчин чармайлтаар тогтоон төлөвшүүлэх ба батжуулах талаар өнгөрсөн болон ирээдүй цагт шийдвэрлэх тулгамдсан асуудлыг тодорхойлж байгаа юм. Ингэхдээ эдгээр улсын эдийн засаг, байгаль орчны болон нийгмийн аюулгүй байдал тийм ч ээдрээгүй бус байна гэдгийг санах хэрэгтэй.

- Энх тайван тогтоох үйл явцыг гутаан үгүйсгэх. Авлигын хэргүүд энх тайван тогтоох үйл явцыг гутаан үгүйсгэж байгаа тохиолдолд энэ нь тогтвортой байдлыг бий болгохоос илүү тогтвортой байдлыг үүсгэнэ. Үүнийг Гаити, Шри Ланка болон Зүүн Тиморын жишээнээс харж болно. Өмнөд Кавказын нутагт хийсэн судалгаанаас үзэхэд гэрээний нэг тал нөгөө талаа авлигад автагдсан гэж ойлгосон нөхцөлд энх тайван тогтоон төлөвшүүлэх ажиллагаанд хүндрэл учруулдагийг харууллаа. Авлига нь мөн цэрэг дайчдыг халж, анги нэгтгэлийг татан буулгах, зэвсэг хураах ба хүмүүсийг энхийн амьдралд шилжүүлэх үйл явцад бэрхшээл учруулдаг байна. Урьд өмнө цэргийн жанжин байсан хүмүүс цөөн тооны тойрон хүрээлэгчид болон мөнгийг аваад зугтааж болно, гэтэл цаана нь тэдний удирдаж байсан мөнгөгүй боловч зэвсэгтэй олон дайчид үлдэх аюултай.

#### 4. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нь

Нэгэнт төлөвшен ойлголт, зан үйл болон хэм хэмжээг өөрчлөхөд хэцүү хэдий ч авлига болон аюулгүй байдлын хооронд бий болсон харилцааг эвдэхэд ийм өөрчлөлт хийх зайлшгүй

шаардлагатай болоод байна. Аюулгүй байдлыг хангах бодлогыг шинэчлэх ажлыг төр засгийн олон байгууллага болон нийгмийн салбарт байгаа өргөн хүрээний сонирхогч этгээдээр гүйцэлдүүлэх шаардлагатай.

Түүнчлэн үүнийг хийхийн тулд авлига болон аюулгүй байдалд учрах эрсдлийг нэгэн зэрэг багасгах тактик баримтлах бөгөөд аль аль хүрээний асуудлын цар хүрээг үзэхэд энэ нь тийм ч амар даалгавар биш юм. Энэ ажлыг хийхийн тулд тухайн улс болон бус нутгийн төвшинд улс төрийн хүсэл зориг бий болгохын тулд тодорхой хүчин чармайлт гаргах ёстой. Үүний зорилго нь нийгмийн янз бүрийн салбарын санаачлагуудыг хооронд нь нэгтгэн уялдуулсан нэг төлөвлөгөө гаргаж, чухам ямар учраас аюулгүй байдлыг бэхжүүлж, авлигаас үүдэлтэй эрсдлүүдийг арилгах асуудлыг шийдвэрлэдэг вэ гэсэн нэгдмэл ойлголтыг бий болгоход оршино (хүснэгт үзнэ үү).

**“Аюулгүй байдал” болон авлига үүсэхэд түүний ролийг орчин нөхцөлтэй холбож үзэх нь**

Авлигаас аюулгүй байдалд учрах эрсдлийн асуудлууд тухайн улсын онцлог болон соёл, уламжлалын орчин нөхцлөөс шалтгаална.

Арабын олон улсад төр засгийн байгууллагыг “нийтийг ивээгч төр” гэж дээдэлдэг бөгөөд түүний үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй болгох, ажлаа ил тод явуулах буюу иргэдийн өмнө хариуцан тайлагнахшаардлагагүйгэжүздэгбайна. Жишээлвэл, Саудын Араб Улс болон Персийн булангийн бусад улсад төр засгийн ажлыг нийтэд тайлагнадаггүй нь эдгээр улсын аюулгүй байдлыг хангах тогтолцоонд авлига дэлгэрэх таатай нөхцөл бүрдүүлсэн байна.

Бусад улсад “аюулгүй байдлыг хангах” үйл ажиллагаа гэдэгт зөвхөн

батлан хамгаалах асуудлыг ойлгодог бөгөөд энэ нь бусдаас онцгой, шүтлэгийн шинжтэй зүйл учир иргэдийн мэдлээс дээгүүр, хуулийн зохицуулалтаас гадуурх асуудал болж хувирна. Судан, Сири, Ливи зэрэг улсад аюулгүй байдалтай холбоотой захираганы, санхүүгийн болон удирдлагын асуудлыг төрөөс шийдвэрлэх үйл явц ил тод бус, хаалттай явагдана.

Авлигаас үүдэлтэй аюулгүй байдалд учрах эрсдлийг арилгахад чиглэгдсэн ажлыг дараах арга замаар хийж болно:

*Зэвсэгт хүчиний хүрээнд:*

- Цэргийн салбарын хүмүүстэй ажиллахдаа тэдгээрийн үйл ажиллагаа авлигыг арилгаснаар хэрхэн илүү үр нөлөөтэй ба оновчтой болж болохыг онцлон тайлбарлах, үүний дотор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг илүү ил тод болгох, зан үйл, ёс зүйн (хахууль өгөх-авахын эсрэг) дүрмийг албадан хэрэгжүүлэх, тууштай шудрага байх тухай (төр засгийн байгууллага болон нийлүүлэгчийн хооронд хийх Шударга ёсны гэрээ) гэрээний ач холбогдлыг сурталчлан таниулах.
- Аюулгүй байдлыг хангах албан тушаалтнууд болон иргэдэд зориулж авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг хэрхэн дээшлүүлэх талаар сургалт семинар зохион байгуулах. Их Британи дахь Транспэрэнси Интэрнэшилийн зохиосон сургалтын хөтөлбөр нь олон улсын хэмжээнд зохион байгуулж болох хэмжээний сургалт болсон байна ([www.defenceagainstcorruption.org](http://www.defenceagainstcorruption.org)).

*Улс төрийн хүрээнд:*

- Авлигын эсрэг арга хэмжээг голчилсон ба янз бүрийн салбарын

бодлогыг бүрэн гүйцэд болгосон аюулгүй байдлыг хангах стратегийг боловсруулахад хууль тогтоох байгууллагатай түншилж ажиллах.

- Авлига, аюулгүй байдлыг хангах ажлын утга учир, үр нөлөөг алга болгодог нүх сүв, сувгуудын талаар яамдын түшмэлүүдтэй харилцан ярилцаж нэгдмэл ойлголтод хүрэх. Польш улсад ТИ-ийн хийсэн ажлын туршлагаас үзвэл ийм ажиллагааны үр дүнд байгууллагын бүтцэд өөрчлөлт хийж болдогийг нотлов. Тухайлбал тус улсын Батлан Хамгаалах Яаманд мөрдөх авлигын эсрэг бодлогыг боловсруулж гаргасан байна.
- Тулгамдсан асуудлын үндсийг тодорхойлж чадах илүү үр нөлөөтэй бодлого боловсруулахад нь тэр засгийн байгууллагыг дэмжих үүднээс олон улсын болон бус нутгийн хэмжээнд мөрдөх дүрмүүд бий болгон ашиглах. Үүнд Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХХАБ)-аас гаргасан Хүчирхийлэл бүхий зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Хөгжлийг Дэмжих Хорооны Удирдамж багтана.
- Улс төрийн болон бизнесийн элитийн зүгээс, мөн контрабанд болон терроризмтай холбоотой бүлэглэлүүдийн зүгээс үйл явцад зүй бусаар нөлөөлж боломжийг хязгаарлахад чиглэсэн шүүхийн болон цагдаагийн байгууллагын бодлогын шинэчлэлийн асуудлаар ажиллах.

*Нийгмиийн хүрээнд:*

- Авлига аюулгүй байдлыг сургуулж доройтуулах нөхцлийг хэрхэн бүрдүүлж өгч нөлөөлдөг, үүний дотор үүнд оролцогч болон үүнээс үүдэх үр дагварыг тодорхойлох. Энэ үнэлгээ нь авлигын эсрэг хүчин чармайлт хэрхэн үр нөлөөтэй байх эсхүл буруугаар

эргэсэн тохиолдолд ямар эрсдэлд хүргэж болох талаар тодорхой санаа бодол болон зөвлөмж агуулаж ёстай. Дайн болж өнгөрсөн улс орнуудад дайнаас гэртээ буцаж ирсэн дайчдад зориулсан нөхөн олговор болон урамшуулал бий болгож олгоогүй тохиолдолд зэвсэг хураах ажиллагаа нь өөрөө авлига ба хүчирхийллийт илүү ихээр дэгдээж болох юм. Түүнчлэн авлигаар бий болсон хууль бус зах зээлийг хориглож устгах нь тоглоомын дүрэм ийнхүү өөрчлөгдөж байгаагаас үүдэх илүү их аюул бий болох, хүчирхийлэл нэмэгдэхэд хүргэж болно.

- Жижиг хээл хахууль өгөх-авах, контрабандын бараа худалдах, хуурамч, дууриамал бараа худалдан авах түүнчлэн цэргийн холбогдолтой учир битүүлэг гэрээ хэлцэл байгуулах, зэвсэг ил тод бус аргаар экспортлох нь аюулгүй байдлыг хэрхэн сулруулдагийг ойлгуулах зорилгоор сонгогчдын дунд таниулан тайлбарлах ба сурталчлах ажил явуулах.

#### Эдийн засгийн хүрээнд:

- ЭЗХХАБ-ын Хээл хахуулийн эсрэг конвенци болон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн заалтад тулгуурлан авлигаас урьдчилан сэргийлэх ба авлигын хэрэгт шийтгэл ногдуулах зохих бүтцүүд бий болгоход нь улс орнуудад дэмжлэг үзүүлэх (парламентын гишүүд болон иргэний нийгэмтэй хамтраад). Авлигатай тэмцэх хараат бус байгууллага байгуулсанаар энэ ажлыг урагшлуулна.
- Авлига үүсгэх болон аюулгүй байдлыг сулруулах хүчин зүйлсийг арилгах аргыг боловсруулахын тулд тодорхой салбарууд (жишээ нь батлан хамгаалах, ойн аж үйлдвэр,

хөдөө аж ахуй) болон этгээдүүдтэй (төрийн, хувийн болон иргэний нийгмийн) тулж ажиллах. Энэ ажлын нэг хэсэг нь төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг шудрага, цэвэр явуулахыг дэмжих зорилгоор тухайн аж үйлдвэрийн салбарын хэмжээнд байгуулах тунхаг гэрээ (Шударга ёсны гэрээ) байж болох юм.

#### Байгаль орчны хүрээнд:

- Цаг уур, эрчим хүч, хүнс болон эрүүл мэндийн тухай олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг сайжруулах нь байгаль орчин, аюулгүй байдал болон авлигын хооронд үүссэн харилцаа холбоог таслах анхны алхам юм. Нэгэнт байгаль орчны сүйрэл хил хязгаарт баригддагүй учир асуудлыг шийдвэрлэх арга нь олон улсын хэмжээнд нэг мөр байх ёстай.
- Байгаль орчныг хамгаалах бодлого хэрэгжүүлэхэд засгийн газраас гаргах зардлын асуудлыг шийдвэрлэхэд ил тод байдал болон олон нийтийн оролцоотойгоор бодлого тодорхойлох зарчмыг нэвтрүүлж хэвшүүлэх. Ингэснээр шийдвэр гаргагчид нь салбаруудын санхүүжилтэд гарсан хоорондын тэнцвэргүй байдал, аюулгүй байдалд учрах уламжлалт эрдлийн төлөө хариуцлага хүлээх болно.

Үндэсний болон олон улсын аюулгүй байдалд учрах эрдлийг өргөн хүрээнд авч үзэх нь авлигын эсрэг арга хэмжээнүүдийг дээрх сорилуудын хариуд хэрэгжүүлэх бодлогод уялдуулан тусгах боломжийг төр застийн байгууллагад олгоно. Энэ өөрчлөлтийг шийдвэртэй хийхгүй бол өнгөрсөн үед аюулгүй байдлыг хангахад гарч байсан зөрчил дутагдал нь ирээдүйд эмгэнэлт явдал болж хувирах аюултай юм.

## **TRANSPARENCY INTERNATIONAL**

Telephone +49-30-343820 -0

Fax +49-30-347039 -12

International Secretariat, Alt-Moabit 96, 10559  
Berlin, Germany

Үг асуудлын талаар нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл ТИ-ийн ажилтан Крейг Фаган (Craig Fa-  
gan) руу хандана уу: plres [at] transparency.org.

### **Ашигласан ном, хэвлэл, мэдээллийн эх сурвалж:**

- 1) See: Natalia Mirimanova and Diana Klein (ed.), *Corruption and Conflict in the South Caucasus* (London, UK: International Alert, January 2006). [www.international-alert.org/caucasus/index.php](http://www.international-alert.org/caucasus/index.php).
- 2) See: Paul Collier, 'Africa Left Behind', *Economic Affairs*, Vol. 26 No. 4 (2007); Susan E. Rice, 'The National Security Implications of Global Poverty', Speech at the University of Michigan Law School (Ann Arbor, Michigan, 2006). [www.brookings.edu/views/speeches/srice/20060130.pdf](http://www.brookings.edu/views/speeches/srice/20060130.pdf).
- 3) Please see: NATO, *NATO-Russia Glossary of Contemporary Political and Military Terms* (Brussels, Belgium: NATO, 2001). [www.nato.int/docu/glossary/eng/index.htm](http://www.nato.int/docu/glossary/eng/index.htm); 'The Global Legal Information Network (GLIN)': [www.glin.gov](http://www.glin.gov); 'The Scottish Information Commissioner': [www.itspublicknowlegde.info/Law/FOI-SAEIRsGuidance/section31/Definition-OfKeyTerms31.asp](http://www.itspublicknowlegde.info/Law/FOI-SAEIRsGuidance/section31/Definition-OfKeyTerms31.asp).
- 4) See: Alyson J.K. Bailes, 'Introduction: The world of security and peace research in a 40-year perspective', SIPRI Yearbook 2006 (Stockholm, Sweden: SIPRI, 2007). <http://yearbook2006.sipri.org/intro>. 'United Nations University Institute for Environment and Human Security (UNU-EHS)': [www.ehs.unu.edu/file.php?id=40](http://www.ehs.unu.edu/file.php?id=40); 'The Commission on Human Security': [www.humansecurity-chs.org](http://www.humansecurity-chs.org).

5) For varying definitions of human security, see the Human Security Report Project of Simon Fraser University: [www.hsrcgroup.org/index.php?option=content&task=view&id=344&Itemid=69](http://www.hsrcgroup.org/index.php?option=content&task=view&id=344&Itemid=69). For UN definitions also see: [www.un.org/esa/ffd/doha/index.htm](http://www.un.org/esa/ffd/doha/index.htm) and [www.gdrc.org/sustdev/husec/Definitions.pdf](http://www.gdrc.org/sustdev/husec/Definitions.pdf).

6) See: Nikos Passas, *Corruption in the Procurement Process / Outsourcing Government Functions: Issues, Case Studies and Implications* (Austin, Texas: Institute for Fraud Prevention, February 2007).

7) This refers to the question whether respondents thought their government's efforts to fight corruption were: very effective, somewhat effective, neither effective nor ineffective, somewhat ineffective, or ineffective. See: Transparency International, *Global Corruption Barometer* (Berlin, Germany: Transparency International, 2007). [www.transparency.org/content/download/27256/410704/file/GCB\\_2007\\_report\\_en\\_02-12-2007.pdf](http://www.transparency.org/content/download/27256/410704/file/GCB_2007_report_en_02-12-2007.pdf).

8) See: Petter Stelenheim, Catalina Perdomo and Elisabeth Skjøns, 'Chapter 8: Military Expenditure,' SIPRI Yearbook 2007: Armaments, Disarmament and International Security (Stockholm, Sweden: Oxford University Press and SIPRI, 2007). <http://yearbook2007.sipri.org>.

9) See: Peter Grier, Faye Bowers and Owais Tohid, 'Pakistan's Nuclear Hero, World's No.1 Nuclear Suspect', *Christian Science Monitor*. 2 February 2004. [www.csmonitor.com/2004/0202/p25s01-wosc.html](http://www.csmonitor.com/2004/0202/p25s01-wosc.html).

10) For 2005 data, see: Eurobarometer, Opinions on organised, cross-border crime and corruption. Special Eurobarometer Survey No. 245 / Wave 64.3 (Brussels, Belgium: European Union March 2006).

[http://ec.europa.eu/public\\_opinion/archives/ebs/ebs\\_245\\_sum\\_en.pdf](http://ec.europa.eu/public_opinion/archives/ebs/ebs_245_sum_en.pdf). For 2007 data, see: Eurobarometer, The EU's relations with its neighbours: A survey of attitudes in the European Union. Special Eurobarometer 285/Wave 67.3 (Brussels, Belgium: European Union, September 2007). [http://ec.europa.eu/public\\_opinion/archives/ebs/ebs\\_285\\_en.pdf](http://ec.europa.eu/public_opinion/archives/ebs/ebs_285_en.pdf). It is important to note that the figures for 2007 are for 27 countries while the data from 2005 covered samples in 25 countries.

11) See: Ronald K. Noble, 'The role of the police in fostering political commitment', 10th International Anti-Corruption Conference (Prague, Czech Republic, 8 October 2001). [www.interpol.int/public/ICPO/speeches/20011008.asp](http://www.interpol.int/public/ICPO/speeches/20011008.asp).

12) See: Claire Delavallade, 'Corruption and distribution of public spending in developing countries', Journal of Economics and Finance, Vol. 30(2): 222-239 (June 2006); S. Gupta, L. de Mello, and R. Sharan, 'Corruption and Military Spending', European Journal of Political Economy, Vol. 17: 749-777 (2001).

13) Current recommendations to the World Bank's public expenditure and financial accountability framework (PEFA) suggest bringing defence expenditures into the assessment or adapting the current tool for interested countries to use in this sector.

14) The figures are estimates from the United States Department of Commerce. See: Mark Pyman, 'Corruption and the Lack of Transparency in Defence Procurement,' TI-UK Paper presented to the conference 'Arms trade and development. An ecumenical seminar'. (Brussels, Belgium, 2-3 November 2005). The industry's over-representation in the numbers is confirmed by other findings. The Bribe Payers Index produced by Transparency

International showed that it ranked as the second most likely sector to receive bribes (2002).

15) The quote is taken from a speech made by President Arias to the Inter-American Development Bank in November 2000. See: Paul Constance, 'Secrecy is a form of Corruption', IDB America (February 2001). [www.iadb.org/idbameric/index.cfm?thisid=1193](http://www.iadb.org/idbameric/index.cfm?thisid=1193).

16) The International Action Network on Small Arms (IANSA) estimates that trade on the black market in small arms may range from US\$ 2 billion to US\$ 10 billion every year. See: [www.iansa.org/media/wmd.htm](http://www.iansa.org/media/wmd.htm).

17) See: Transparencia Colombia, Conflicto armado y delincuencia organizada: Escenarios de corrupciyn. A propósito del caso de Colombia. Cuadernos de Transparencia No. 13 (Bogota, Colombia: Transparencia Colombia, 2007). [www.transparenciacolombia.org.co/Portals/0/descargas/publicaciones/TRANSPARENCIA%2013.zip](http://www.transparenciacolombia.org.co/Portals/0/descargas/publicaciones/TRANSPARENCIA%2013.zip).

18) See: World Bank, Engaging with Fragile States (Washington, DC: World Bank, 2006). [www.worldbank.org/ieg/licus/download.html](http://www.worldbank.org/ieg/licus/download.html).

19) See: Karen Hussman, 'Thought Piece: What is corruption in conflict zones'. Paper presented at conference 'The Nexus: Corruption, Conflict & Peacebuilding Colloquium'. (Boston, Massachusetts, 13 April 2007). <http://fletcher.tufts.edu/corruptionconf/pdf/Hussmann.pdf>.

20) See: Natalia Mirimanova and Diana Klein (ed.), Corruption and Conflict in the South Caucasus (London, UK: International Alert, January 2006). [www.international-alert.org/caucasus/index.php](http://www.international-alert.org/caucasus/index.php).

# СУДАЛГАА

## АВЛИГЫН СУДАЛГАА БОДЛОГОД ЧИГЛЭСЭН ТАНДАЛТ /RESEARCH ON CORRUPTION A POLICY ORIENTED SURVEY<sup>32</sup>/

Үргэлжлэл

Jens Chr. Andvig and Odd-Helge Fjeldstad  
Inge Amundsen  
Tone Sissener  
Tina Soreide

Норвегийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Нийтэмлэг (NORAD)

Христиан Михельсений Хүрээлэн (CMI);  
Норвегийн Олон Улсын Харилцааны Хүрээлэн (NUPRI)

Дэлхийн Банк, АТГ-ын Засаглалыг дэмжих төслийн орчуулагч Н. Гантуяа

2000 оны 12 сар

### 5. Авлига хүн судалын үүднээс (Anthropological perspectives on corruption)

Өнөөдөр авлига нь хөгжиж буй орнуудын нийгэм эдийн засгийн өсөлтийн гол саад тогтор болж байна. Хөгжиж байгаа орнуудад авлигатай тэмцэх хөтөлбөр боловсруулахын тулд уг үзэгдлийн мөн чанар, шинж байдал, хэв маяг, бүтцийг мэдэх хэрэгтэй.

Уг үзэгдлийг хэрхэн авч үзэх талаар дэлхий нийтийн маргаан хэлэлцүүлэг өрнөсөөр байгаа ба авлигын өргөнөөр хүлээн зөвшөөрөгддөг тодорхойлолт нь “төрийн албыг хувийн ашиг хонжоонд ашиглах” гэж томъёологддог (Amundsen 1999, Gray and Kaufmann 1998, Rose-Ackerman 1996, Zakiuddin 1998). Энэхүү тодорхойлолт нь хувийн хэвшлээс илэрхий тусгаарлагдсан төрийн хэвшил

32 [http://www.icgg.org/downloads/contribution07\\_andvig.pdf](http://www.icgg.org/downloads/contribution07_andvig.pdf)

оршихоос шалтгаалж байна. Веберийн эрх зүйт рационал захиргааны загварт (Weber's rational-legal bureaucracy model) тусгагдсан энэ тодорхойлолтыг өрнийн биш орчинд хэрхэн хэрэглэх вэ гэдэгт асуудал оршиж байна.

Ихэнх нийгмийн антропологчид авлигын уламжлалт тодорхойлолтыг дэндүү явцуу хүрээтэй, тухайн үйлийн хууль бус талд дэндүү анхаарсан байдаг гэж үзэж байна. Хүмүүс үйлийн шинж байдлыг хэрхэн үнэлж байгаа нь тухайн үйл авлига мөн үү гэдгийг зааглах түгээмэл, хувиршгүй хэм хэмжээнд тулгуурладаггүй. Харин ч юуг авлига гэж үзэж байна вэ гэдэг нь улс орон бүрт өөр байна. Ийм эрээн бараан нөхцөлд нийгмийн үйл ажиллагааг нийгмийн амьдралд оролцгосод өөрсдөө хэрхэн үнэлж байгааг судлах шаардлагатай.

Зарим улс оронд авлига уул соёл

уламжлалд нь гүн шингээстэй байдаг гэсэн узэл бодол олонтаа гардаг. Африкийн олон оронд албан тушаалаа ашиглах, хууль бусаар баяжих зэргээр авлига илэрхий, нийтлэг байдаг агаад ихэнх иргэд нь үүнийгээ авлига гэж үздэггүй буюу уг үйлдэл нь чухам хууль ёсных байж чадах уу гэдэг талаар ярихыг ч хүсдэггүй. Нийгмийн зарим хэм хэмжээ, зан үйлийн логик нь авлига үүсэх таатай нөхцөл болдог. Хууль дүрэм нь яаж ч мушгиж болдог, “уюн хатан”, давхар давхар хэм хэмжээ үйлчилдэг, хахууль зуучлагч олон, ам таглах, гар цайлгах заншилтай, бурууд найр тавьдаг, тал засдаг, гэр бүлсдэг, хуйвалддаг сүлжээнд торлогдсон, эрх мэдэл, засаглалд түрэмгий махчин (удам залгах) хэлбэр нöёрхсон нийгэмд авлига амь бөхтэй цэцэглэж байх юм.

Дээр дурдсан эрх зүйт рационал захиргааны загварт антропологийн аргачлал хэрэглэж нийгмийн ба түүхэн нөхцөл байдалд тавьж үзэхэд уг загварын зарим сул тал нь цухуйна. Өдөр тутмын практикт үйлчилж байгаа нийгэм, соёл уламжлалын сэтгэлгээг судалж үзсэнээр юу нь авлига мөн, юу нь авлига биш вэ гэдэг нь нийгмийн амьдралын туршлагаар тодорхойлогддогийг мэдэж болно.

## 5.1 Веберийн эрх зүйт рационал захиргааны загвар (Weber's rational-legal bureaucracy<sup>33</sup> model)

Европын орнууд эрх зүйт рационал

33 The noun BUREAUCRACY has 3 senses: 1. non-elective government officials; 2. a government that is administered primarily by bureaus that are staffed with nonelective officials; 3. any organization in which action is obstructed by insistence on unnecessary procedures and red tape (<http://www.audioenglish.net/dictionary/bureaucracy.htm>). Эдгэрээс зөвхөн гурав дахь утга нь бидний “хүнд суртал” гэж нэрлэдэг үзэгдэлд дүйж байна. Харин энэхүү орчуулж буй баримт бичигт 1 болон 2 дахь утгад илүү ойр байгаа тул “хүнд суртал” гэж орчуулж болохгүй нь. Тиймээс цаашид “захиргаа” эсвэл “бюрократ” гэж явъя. Мөн холбогдох албан тушаалтанг “хүнд сурталтан” гэх биш “түшмэл” гэе. (Орчуулагч)

захиргаа өнө эртний уламжлалтай. Ханделманы (Handelman) тэмдэглэснээр “төрийн захиргааны бүтэц (bureaucratic organisation) Өрнийн нийгмийн ухааны зохиосон зүйл биш” гэнэ. Тэрээр Өрнийн эрт цийн зохион байгуулалтын зарчим, бюрократ байгууллагын хувьсалд залгамж холбоо байгааг тогтоосон байна.

Түүний үзэж байгаагаар бюрократ зохион байгуулалт нь нийгмийн тусгал л байдаг аж. Өнөөгийн Өрнөдийн улс орнууд дахь бюрократ байгууллыг эрх зүйт рационал бүтцийн талаарх үзэл санааны түүхэн хувьслын үр дүн гэж үзэх ёстой аж.

Өрнөд Европт бараг 19-р зууны дунд хүртэл төрийн албан тушаалыг хувийн өмч мэтээр үздэг байсан үеэс эрх зүйт рационал зарчмын талаарх ойлголт хэрхэн хувьсаж ирсэн нь харагддаг. Скоттын (Scott) бичсэнээр “засаглалыг хянах өнөөгийн ойлголт 19-р зууны эцсээр застийн газар өргөн түмний төлөөлөл бүхий хууль тогтоох байгууллагын өмнө хариуцлага хүлээх зарчим хөгжиж байж л боломжтой болсон” байна (Scott 1969:316).

Түүний үзэж байгаагаар хөгжиж буй орнууд “Өрнөдөд улс төрийн урт удаан тэмцлийн явцад аажмаар буй болсон эрх зүйн тогтолцоог ерөнхийд нь хуулсан” байдаг аж (Scott 1969:319). Энэ нь Африкийн талаар Оливье де Сарданы (Olivier de Sardan) хэлсэнтэй дүйж байна. Тэрээр “захиргааны аппарат нь тэр чигээрээ Европоос хуулбарласан... Хууль, захиргааны ажиллагаа, төсөвлөлт нь бүхэлдээ Өрнийнх” гэжээ (Olivier de Sardan 1999:47). Гэтэл захиргааны бүтцийг нь зүгээр л хуулаад авчихсанаар Европынх шиг ажиллаад эхэлдэггүй байна.

Англид улс төр, захиргааны дүрэм журам, хэм хэмжээ урт удаан рувьслын

үр дүн байсан. Харин Африк, Өмнөд Азийн эрх зүйн тогтолцоо нь тэр чигтээ колоничлолын өв юм.

Тиймээс Европоос сохиор хуулсан захиргааны аппаратын үйл ажиллагаа нь солиорлын хэлбэртэй (“schizophrenic type”) болдог байна (Olivier de Sardan 1999:47). Кохэн (Cohen) Нигерээс бичсэн нь: ”Хууль бус явдал хэвийн үзэгдэл байдаг бюрократ тогтолцоонд хэрхэн ажиллаж, амьдрах вэ гэдгийг Африкчууд гарамгай сурсан байна” гэжээ (Cohen 1980:81). Колоничлогчдын суулгасан шинэ дүрэм журам, улс төрийн хэм хэмжээ бодит аж амьдралд нь огт уялдаагүй байна. Гэхдээ Британы колоний захиргааны суулгасан төрийн алба нь колонид уул үүрэг функцээсээ алсарч холдсон нь хэд хэдэн шалтгаантай. Бүр африкчууд төрөө барьж эхлэхээс өмнө л төвлөрсөн засаглалын ажлын догондлын улмаас түүнд итгэл буурч урам хугарсан байдал нь Нигерийн төрийн албанад хэвийн үзэгдэл, уламжлал болчихсон байсан. Тийнхүү африкчууд төрөө барих болсон үестээ өмнөх захирагч амбадын удирдлагын арга барилыг өвлөн авсан байна.

## 5.2 Авлигыг тодорхойлох нь: төрийн хувийн хоёрын зааг нийгэм судлалд

(Defining corruption: the conventional distinction in social sciences)

Улс төр судлал дахь төрийн албаны тухай баримтлалд Макс Веберийн (Max Weber) эрх зүйт рационал захиргааны төгөлдөр хэлбэрийн загвар гүн нөлөөлсөн байна. Энэхүү загвар авлигыг төрийн хувийн хоёрын ялгааг үл хайхрах явдал гэж ойлгоход чухал үүрэгтэй. Гэхдээ авлигыг зөвхөн төрийн албаны талаас

үзсэн энэхүү баримтлалд шүүмжлэлтэй хандсан нь бас бий. Үүнд:

*Нэгдүгээрт*, төрийн алба гэдэг нь угаасаа Өрнөдийн ойлголт юм. Үүнийг тодорхой тайлбарласан хэд хэдэн судлаач байна. Вууд хэлэхдээ: “Энэ ойлголт Веберийн тодорхойлсон лугаа адил рационал чанар нь нийгмийн хэм хэмжээ байдаг буюу байж болно гэсэн урьчилсан таамагт суурилаагүй” гэжээ (Wood 1994:520). Прайсын (Price) үзэж байгаагаар “Төрийн албан хаагч албан ёсны дүрэм журамд тусгагдаагүй маш олон шаардлагыг биелүүлэх дарамт шахалт дор ажилладаг... Энэтхэгийн нийгэмд хоорондоо өрсөлдөх давхар давхар хэм хэмжээнүүд үйлчилж байдаг” (Price 1999:318) гэнэ.

*Хоёрдугаарт*, хууль журам өөрөө хамгийн рационал байдаггүй. Хууль журам мөн чанартай консерватив шинжтэй, нийгмийн харилцаа, зан үйлийн статус квог л баталгаажуулж байдаг билээ. Тиймээс Мирдал (Myrdal 1968a) түшмэлийн зан үйлийн “бодит” дүрэм ба “албан ёсны” дүрмийт ялган зааглаж, “бодит” дүрэм нь тухайн улс, орон нутгийн нөхцөл байдалд илүү зохицсон, “шинэлэг” байж болох юм гэсэн санаа дэвшүүлсэн байна. Авлига сөрөг үр дагавартай гэсэн үзэл түгээмэл байдаг ч бас хүү авлига бюрократ нарын ажиллагааг “хүмүүн шинжтэй” болгож өгдөг зерэг талтай гэсэн санаа ч бас хэлэгддэг (Ward 1989).

Харьцуулсан дүн шинжилгээнд хэрэглэхэд тохиромжтой авлигын тодорхойлолт гаргах хэцүү нь ойлгогдсон. Эрх зүйн талаасаа авлигыг хууль буюу дүрмийн зөрчилтэй холбож ойлгодог. Гэтэл энэ аргачлалаас хэд хэдэн асуудал үүддэг. Нэгдүгээрт, энэ хандлагын дагуу авлигач үйлийг хориглосон хууль, дүрэм байх ба тухайн хуульд заагаагүй үйлдэл буюу эс үйлдэл гадна нь орхигдоно.

**Хоёрдугаарт**, улс улсын хууль өөр тул өөр өөр зан үйлийн хууль ёсны эсэхийг хэрхэн шийдэх нь ч ялгаатай байна.

**Гурдавдугаарт**, эрх зүйн аргачлал нь эрх зүйн орчин төвч, объектив, улс төрөөс ангид байна гэсэн санаанд үндэслэх атал авлигач үйл нь вакуум орон зайд оршсон объектив ажиллагаа биш юм. Авлига нь нийгмийн (social) зан үйл бөгөөд утгыг нь ойлгохын тулд хүмүүсийн харьцааг түүхэн онцлог орчин нөхцөлд нь шинжин үзэх шаардлагатай. Тухайн хоёр этгээдийн харилцан үйлдэл зүй ёсны эсэх нь нийгмийн орчин нөхцлөөс шалтгаална.

Авлигын талаарх ойлголтыг мэдэх үүднээс бид дараах асуултуудыг тавих хэрэгтэй: ямар зан үйлийг харьцуулж байгаа вэ? Үйлдлүүдийг хэрхэн үнэлж байна вэ? Хэн үнэлж байна вэ? Бид Веберийн онолд шүтэж гаргасан авлигын тодорхойлолт нь “дэндүү явцуу бөгөөд тухайн үйл хуульд харшилдагт хэт анхаарсан нь дан Өрнөдийн байр сууринаас харсан хэрэг” гэсэн санааг дэмжиж илүү өргөн ойлголт хэрэгтэй гэж үзэж байна (Olivier de Sardan 1999:27). Оливье Де Сардан зээсэх, эрх мэдлээ ашиглах, хөрөнгө шамшигдуулах, завших, нөлөөгөө ашиглах, байгууллагын дотоод мэдээлэл ашиглах зэрэг авлигын гадна орхигддог үзэгдлийг хамруулах зорилгоор “авлигын цогц” гэдэг нэр томъёо хэрэглэсэн байна. Ингэснээр нарийн түвэгтэй нийгмийн зан үйлийг илүү гүнзгий авч үзэх үүд нээгдэж байна. Мөнхүү хүмүүс өөрсдийнхөө үйлдлийг хэрхэн үнэлж байгааг судлах боломжийг нээж байгаа юм.

### 5.3 Антропологийн арга, аргачлал (Anthropological methods and approaches)

Блундо, Оливье де Сардан нар (Blundo and Olivier de Sardan 2000) авлига бол

их бага хэмжээний гэмт хэрэг, хар захын арилжаа, мансууруулахын бодисын наймаа дугаа адил нууц далд ажиллагаа байдаг гэж үздэг. Нийгэм судлалын нэгэн салбар болох антрополог буюу хүн судлалд ханцуй дотор хийгддэг, ил зарладаггүй, ихэвчлэн хуулийн эсрэг, заримдаа зүй ёсны бус (illegitimate) авлигын зан үйлд дүн шинжилгээ хийхэд тохирох арга зүйн багц бий.

Асуумж судалгаа зэрэг тоон өгөгдхүүн бүхий нийгмийн ухааны судалгааны аргууд нь цагдаагийн байцаалт шиг санагдах, айлгаж ичээх, өөрийгөө золиослох, бусдыг буруутгах үр дагавартай байж болох ба субъектив үр дүн гарах эрсдэлтэй. Харин хүн судлалын шууд бус судалгааны арга нь нийгмийн салбараас мэдээлэл авахад ихээхэн зохимжтой байна (Blundo and Olivier de Sardan 2000).

Блундо, Оливье де Сардан нар хүн судлалын аргачлалыг авч үзэхдээ ажиглалтын арга албан ёсны ба албан бус тогтолцооны зөрчлийг тодорхойлох, мэдээлэл өгөгчид ямар практик ажиллагаанд хамгийн их анхаарал хандуулж байгааг тогтооход тустай болохыг онцолжон байдаг. Авлига заавал судлаачдын ажиглаж байгаа хэсэгт илрэх албагүй, өдөр тутам илрдэг байршил нь өөр байж болно. Энэхүү өдөр тутмын хэмжигдэхүүнийг нийгмийн ухааны бусад судлаачид анзаардаггүй тул авлигын тухай хэвлэл нийтлэлд дурдагддаггүй байна.

Авлигыг ажиглалтаар илрүүлэх хэдий амаргүй байлаа гэхэд энгийн яриа хөөрөө, хүмүүсийн хардлага, шивнээ, явган ярианаас дуулж болох юм.

Авлигач үйлийн талаар үнэтэй мэдээллийг ярилцлагаар авч болно. Албан бус ярилцлага хийснээр тухайн улс, нутаг орны хүн амын авлигын талаарх хандлага, ёс зүйн сэтгэлгээг

мэдэж болно. Зарим тохиолдолд фокус бүлгийн хэлэлцүүлэг үр дүнтэй байдаг. Мөн тодорхой байгууллагын буюу тодорхой харилцан үйлдлийн кейс судалгаа бас ашигтай байдаг. Блундо, Оливье де Сардан нар аргазүйн гурвалсан баталгааны (triangulation) чухлыг заасан байдаг: үүнд арга аргачлалуудыг хавсарч хэрэглэх, жишээлбэл ярилцлагыг ажиглалт, сонины нийтлэл, шүүхийн мэдээллэлтэй зэрэгцүүлж хэрэглэх замаар нягталж, баталгаажуулах хэрэгтэй.

#### **5.4 Авлигын талаарх антропологийн судалгааны гурван жишээ (Three examples of anthropological field work studies on corruption)**

Энэ гарчигт антропологийн гурван судалгааг танилцуулна. Ингэснээр антропологийн салбарт ажилладаг нийгмийн ухааны судлаачид авлигыг өргөн утгаар ойлгох шаардлагатай болохыг хэрхэн дэмжиж ажилласныг үзүүлэх юм. Акхил Гупта 1995 оны нийтлэлээрээ авлигын талаарх дэлхийн эрдэмтдийн хэлэлцүүлэгт антропологийн байр сууринаас хувь нэмэр оруулсан юм. Тэрээр доод албан тушаалын албан хаагчид хэрхэн үүргээ гүйцэтгэж байгаа байдлыг судалж, Энэтхэгийн нехцөлд улсын хувийн хоёрын ялгааг өрнөдийн сэтгэлгээгээр ойлгож болохгүйг илрүүлжээ. Гуптагийн гаргасан Шармажи гэдэг бага тушаалын албан хаагчийн жишээ төр ба нийгмийн зааг хязгаарын талаарх Өрнийн ойлголт Энэтхэгт оновчгүй байдгийг харуулж байна. Дараах кейс судалгаа Энэтхэгийн эгэл албан хаагч хэрхэн ажлаа явуулдгийг харуулна.

“Шармажи тав зургаан тосгоны газрын бүртгэл хөтөлдөг патвари хэмээх албан тушаал хашдаг байна.

Тэрээр бяцхан хотынхоо хуучин хэсгийн гүнд даруухан байшинд амьдардаг. Байшингийн доод давхар хоёр өрөөтэй ба гаднаа бяцхан хороотой. Хоёр өрөөний нэг нь гудамж руу харсан том хаалгатай. Энэ өрөө Шармажийн албан тасалгаа болно. Тэр ихэвчлэн эндээ байж байдаг, үйлчлүүлэгч, тойрон хүрээлэгч нар нь энд цуглаж түүнтэй уулзана. Өрөөний хоёр талын хана дагуулж вандан тавьсан байна. Өрөөний хоймроо гурван хүн багтахтай угүйтэй өндөрлөг байна. Тэнд Шармажи сууж, иргэдийг хүлээж авах, газрын бүртгэлээ хөтлөх үйл ажиллагаагаа явуулна. Энэ талаар хөөцөлдөх ажилтай хэн бүхэн түүний энэ тасалгаанд л ирнэ. Хэзээ ямагт өөр өөр ажил хөөцөлдөж явваа хоёр гурван бүлэг хүмүүс тэр давчуу өрөөнд байж л байх юм.

Шармажи тэр бүх хүмүүстэй зэрэг зэрэг ярих ба, заримдаа нэг хүнтэй ярьж байснаа өгүүлбэрийн дундаас өөр хүнд хандаж эхэлнэ. Өрөөнд байгаа хүмүүс ч өөртөө хамаагүй нөгөө үйлчлүүлэгчийн асуудалд хошуугаа дүрэн ярианд оролцно. Шармажи ч нэг хүнтэй ярьж байснаа бусад үйлчлүүлэгчдэд хандан: “Тийм биз дээ?”, “Миний хэлдэг зөв биз дээ?” гэхчилэн чухал царайлан асууна. Энэ албан байранд явагдах үйлчилгээ ихэнхдээ энгийн хялбар ч гэлээ мөнгөөр л бүтнэ.” (Gupta 1995:379).

Шармажи хэрхэн ажлаа гүйцэтгэж байгаа хэлбэр нь Өрнөдийнхөөс наанадаж гурван зүйлээр эрс ялгаатай байна. Нэгдүгээрт, албан тасалгаа нь түүний амьдардаг байшинд байна. Хоёрдугаарт, хүний асуудлыг шийдэхдээ байнга л өөр бусад хүмүүстэй түүнийг нь ярилцана. Гуравдугаарт, ажлаа хийсний төлөө иргэдээс мөнгө авна.

Гэтэл тосгоны иргэд төрийн албан хаагчдын авлигын талаар гомдоллохдоо ажил гэр нь холилдсон тухай ч юм уу, эсвэл мөнгө авдаг талаар нь

ярихгүй юм. Харин төрийн ажилтантай амжилттай харилцаж ажлаа бүтээх чадамж хомс байгаагаа ярьж байх юм. Үүнээс Гупта “авлигын талаарх ойлголт улс улсад ихээхэн ялгаатай байдаг ба түүхэн нөхцөл байдал хийгээд нийгмийн ухамсын онцлогоос ихээхэн шалтгаалдаг” гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл аливаа зан үйлийг зүй ёсны гэж үзэх зааг хязгаар үндэсний ба нийгмийн онцлогоос шалтгаалан орчин нөхцөл бүрт өөр байдаг аж.

Арильд Энгельсен Рууд (Arild Engelsen Ruud 1998) оролцогчийн байр сууринаас үзвэл хахууль болон авлигын бусад хэлбэрийн хооронд ялгаа байна. Жишээлбэл Энэтхэгийн бенгал хэлээр ярьдагтосгоныхонхахуулийгилэрхийлэх нэр томъёотой атлаа авлигын бусад хэлбэрийт заах үг тэр бүр хэрэглэдэггүй байна. Руудийн бичсэнчлэн “хахууль нь онцгой сөрөг утгатай бололтой” гэжээ. Гэхдээ серөг утгаараа ойлгогдоо ортуулж хахууль өгч болох ба харин арга тасрах үед л шууд хахууль өгөх аж. Түүнээс биш эхлээд танил, хэлхээ холбоогоо ашиглан асуудлыг шийдэхийг оролдоно.

“Кало тогтвортой орлоготой болох хүслээр ойролцоо эмнэлэгт ажилд орохоор өргөдөл өгчээ. Гучин орон тоонд хэдэн зуун хүн өрсөлдөх болжээ. Кало мэдлэг туршлага сайтай ч, бусад өрсөлдөгч нар ч дутах юу байх вэ, бас л мэдлэг туршлага сайтай. Бусдаасаа сод илүү биш гэдгээ Кало мэдэж байгаа тул албан бус шугамаар тусламж авах хэрэгтэй гэдгээ ойлгоно. Үүнд хахууль, эсвэл танилын хэлхээ холбоо тус болох ёстой. Кало ярилцлагад орсноосоо хойш тосгоноосоо байн байн хот руу явж, мөнөөх ажлын талаар мэдээлэл болон хэлхээ холбоо хайсаар сар гаруй боллоо. Тэрээр эхлээд хотын захиргаанд ажилладаг бөгөөд тэрхүү эмнэлгийн ажилтан шалгаруулах ажиллагаанд оролцож буй хүнийг таньдаг гэх нэг найзыгаа

олсон. Бас Калогийн үеэлийн хөрш нь уг эмнэлэгт өндөр албан тушаал хашдаг болохыг мэдсэн байна. Тэрээр найзынхаа хамт эмнэлгийн ажилтан шалгаруулах хорооны хүнтэй очиж уулзахын сацуу, мөн үеэлийн хамт хөршийнд нь орж уулзсан байх юм. Тэр хөрш нь их л илэн далангүй, энгийн хүн байв.

Сайн хөршийн үүргээ биелүүлэхэд бэлэн тэр бээр зохих албан тушаалтнуудад өгөх мөнгө хэрэгтэй байгааг ч дуулгах нь тэр. Кало тэр хүн өөртөө бас хувь хүртэх байлгүй гэж бодож байв. Энэ бүхэнд багагүй мөнгө шаардагдах агаад тэр эмнэлэгт ажилд орох гэж байгаа бусад хүмүүс ч мөнгө төлөхөд бэлэн байгаа шүү дээ гэдгээр энэ нь зөвтгөгдөж байв. Калогийн үеэлийн хадмууд нь хотын иргэдийн хурлын гишүүний сайн найз болж таарав. Хурлын гишүүн “би энэ асуудалд төдийлөн нөлөөлж чадахгүй шүү дээ (энэ асуудлыг би сонирхогчийг байна гэсэнтэй агаар нэг)” гээд харин эрх бүхий хүнд тодорхойлолт бичиж өгье гэжээ. Ингэснээрээ тэр асуудалд оролцогчийг, гэхдээ бас найз нартаа нүүрээ алдахгүй аргалж байгаа нь тэр. Ингээд эцсийн найдвар хүргэн ах Никхилээс тусламж авахаар шийдэв. Гэтэл Никхил автайнхаа дүүд, автайнхааар гэрт туслахаас татгалзаж, эхнэртээ нүүр алдаж, түнжин хагарчээ.

Кало өөр бусад арга чарга хайсан ч бүгд бүтэлгүйтсэнээр, тэр ажилд орж чадаагүй юм”(Ruud 1998:14). Калогийн тохиолдолд түүний хандсан хэн бүхэн туслахыг хичээсэн. Кало ч мөнгө нэхлээ гэж гомдоогүй. Рууд бичсэн нь “хахууль өгөх, дам танилд тус болсны төлөө урамшуулж гар цайлгахын хооронд зааг татах хэцүү” гэжээ. Тэрээр юуг авлига гэх, юуг авлига биш гэх нь аль талаас нь гэрэл туслахаас хамаарна. Хахууль өгөх, хэлхээ холбоогоо ашиглах хоёрын үр дүн нь адил ч энэ хоёр үйлдлийг үнэлэх төсөөлөл нь өөр юм.

Алекс Кондос (Alex Kondos 1987) Балба улсад ажиглагддаг натабад (садандаа туслах), крипабад (бусдад туслах) гэдэг зан үйлийг судалсан угсаатны зүйн материалд түшиглэн балбачуудын хувьд төв захиргаатайгаа харьцахад нь фаворитизм гэгч ямар утгатай байхыг тодорхойлохыг оролджээ. Чингэхдээ, фаворитизмыг авлигын хэлбэр болгон томъёолсон өрнөдийнхний загвартай харьцуулж үзсэн байна. Тэрээр хоёр эсрэг үзэл суртлын зөрчлийг илрүүлсэн байна. Судлаачид авлигын хэлбэр гээд байгаа үзэгдэлд уг үзэгдлийн оролцогчид нь өөрсдөө ах дүү, найз нөхдөдөө туслахгүй ядаг юм гэсэн ойлголтоор хандана.

Энэ санааг нийслэл Катманду дахь хүн тэрэг хөтлөгчид дэмжиж байгааг дараах жишээнээс харж болно. Хүн тэрэг хөтлөгч яагаад мотортой тэрэг авахгүй байгаагаа ердөө л “*rahaisch chaina*” (зүтгүүрийн хүч байхгүй ээ) гэдэг цэээр тайлбарлаж байна. 1970-аад оны цеэр засгийн газар нь хүн тэрэг хөтлөгч нарт моторт тэрэг авахад зориулж урт хугацааны хүцгүй зээл олгох хөтөлбөр санаачлан эхлүүлсэн байна. Энэ нь боловсролтой атлаа өөр ажил олдохгүй хүн тэрэг хөтөлж яваа залуучуудын хөдөлмөрийг дээгүүр түвшинд гаргах ач холбогдолтой гэж цээж байлаа. Энэ хөтөлбөр амжилт олоогчийн шалтгааныг хэвлэл, радио “авлигас” болсон гэж мэдээлж байсан ч ард түмэн тэгж цээгүй. Харин Балба улсын өнцөг булан бүрээс оюутнууд нийслэл рүц цувж, зээл авч, моторт тэрэг аваад, түүнийгээ жинхэнэ хүн тэрэг хөтлөгчдөд түрээслүүлэх болжээ. Гэхдээ тэгж зээл авч чадсан нь сайдын ах дүц, хамаатан садан, тэдний дотно найзууд, сайдын улс төрийн хамсаатнууд байжээ” (Kondos 1987:17).

Зээл авч чадаагүй хүн тэрэг хөтлөгчид зээл хэрхэн олгогдож байсан талаар ер

гомдоллоогүй. Өөрсдөө “зүтгүүрийн хүч” (зүтгүүр гэдэг нь танил, хүч гэдэг нь тэрхүү танилын эрх мэдэл) дутсанаа л хохь гэж бодоод өнгөрсөн. Кондосын дүгнэснээр Балбын уламжлалт нийгэмд фаворитизм нь аливаа үйлсийг бүтээх зүй ёсны арга зам гэж үзэгдэх агаад оролцогчид үүнийг авлига гэж үздэгтүй байна.

## 5.5 Өдөр тутмын зан үйлийг нөхцөлдүүлэгч үндэсний сэтгэлгээ (Sociocultural logics informing everyday practices)

Хөгжиж байгаа олон оронд төрийн албан тушаал хашигчид орчин цагийн европ захиргааны чиглэлээр боловсрол эзэмшсэнээрээ албан тушаалын болон мэргэжлийн легитим чанараа бий болгодог ч нийгмийн легитим чанар нь нийгэм, соёл уламжлалын өөр логикоор ажиллахыг шаарддаг байж болзошгүй юм. Гар цайлгах ёс ба андын сүлжээний нийгэм, соёл уламжлалын (үндэсний) логикийг угсаатны зүйд суурилсан жишээгээр доор үзүүлэв. Эдгээр жишээгээр хүнд нэгэнт төлөвшсөн зуршил болон нийтлэг зан үйл өдөр тутмын үйлдлийг хэрхэн нөхцөлдүүлдгийг харуулах юм. Тухайн үйлд оролцогчид үйлдлээ өөрсдөө хэрхэн үнэлж байгаагаар тэдгээр үйлдэл нь хэдий хир легитим болохыг ойлгож болох болов уу.

### 5.5.1 Гар цайлгах сэтгэлгээ (The logics of gift-giving)

Гар цайлгах, бэлэг зөрүүлэх ёсны талаарх Малиновски (Malinowski 1922), Маусс (Mauss 1990 [1925]), Сахлинс (Sahlins 1972) нарын дүн шинжилгээ орчин цагийн угсаатны зүйчдийн судлагааны нэгэн тулгуур болж байна. (жишээлбэл

Bourdieu 1977; Ledeneva 1998; Parry 1986; Weiner, 1976, 1978, 1980; Yan 1996).

Хятадад гуаньси (*guanxi*) хэмээх ухагдахуунбайдаг нь цгилбэл “нийгмийн хэлхээ холбоо” (social relationships or social connection) гэж бууна (Yang 1989, 1994). Мэйфайр М. Ян угсаатны зүйн баялаг материалдаа гуаньси гэгчид хамаарах олон зан үйлийг дурсэлж, дүн шинжилгээ хийсэн байдаг. Гуаньси практикт гар цайлгаснаар угаасаа танилын харилцааны суурь тавигдсан хоёр этгээд өргөн хүрээнд харилцан тусалж байх үүрэг бий болдог байна. Гэхдээ гар цайлгах, хариу барих сэдэл нь талуудын харилцаанаас шалтгаалж өөр өөр байна. Нэгдүгээрт, бэлэг өгөх, бэлэг хүлээн авах, хариу барих замаар үүргээ биелүүлж байгаа нь “нэр төрөө бодсоны” зэрэгцээ ер нь “зөв” үйл гэсэн мэдрэмж байдаг. Хоёрдугаарт, “өөрийн сонирхлыг ч бодсон, унацыг нь ч бодсон бусад тусалж байхыг өөрийн үүрэг гэж сэтгэдэг” байна (Yang 1994:140). Гуаньси гэдэг нь бэлэг өгөлцөх, хариу барилцан өдөр тутам бие биедээ тусалж байх арга хэлбэр юм. Доор жишээ татъя.

“Хань Сулань гэгч ажилчин тариачин гаралтай тавь гарсан авгай нөхөр, охин, хадам эхтэйгээ амьдардаг. Тэднийх нөхрийн нь ажилладаг үйлдвэрийн гурван өрөө бүхий бяцхан байшинд суудаг. Айл хөршүүдтэйгээ олон жил ойр саахалт амьдарч ирсэн тул тэндхийн айлууд бие бие сайн мэддэг, бага сага зүйлд туслалцдаг ажгуу. Манайх юу олсныг хөршүүд тэртэй тэргүй мэдэх учраас байгаагаа айлуудтай хуваалцаж байхгүй бол болохгүй, нэр нүүрээ барна гэж Хань хэлдэг.

Нэг удаа хадам эх нь юм оёхдоо тааруу нэгэн хөршдөө өвлүүлж хөвөнтэй хүрэм хийж өгчээ. Хагас жилийн дараа хадам эх нь хөдөө байдаг хүүгээ эргэхээр явах болоход мөнөөх хөрш нь хүүгийндээ өгөөрэй гэж бялуу авч өгсөн байна.

Ийнхүү харилцан өглөг, тусламжаар айл хөршүүдтэйгээ эв найртай байж, орон гэртээ амар амгаланг цоглоодог гэж Хань хэлдэг” (op. cit.: 81).

Ян өдөр тутам бэлэг өгөлцөж авалцаж байдаг олон жишигээ татсан ба тийнхүү бэлэг хүлээж авах, хариу барихаас татгалзвал гарцаагүй нэр төрөө алддаг байна. Бэлэг авах, хариу барих үүрэг үүссэнээр ацан шалаанд орох тохиолдолд ч олонтаа гардаг байна. Үүнд ажилчин хүн албан бусаар хэд хоногийн чөлөө хүссэн тохиолдлыг дурдаж болно.

Тэрээр эхлээд үйлдвэрийн менежертээ далдхануур бэлэг өгөхөд цаадах нь татгалзсан байна. Тэгэхээр өөр аргаар бэлгээ өгөхөөр шийдэж. Тэрээр бусад ажилчид байж байхад менежер авахгүй байх аргагүй байдлаар бэлгээ өгсөн байна. Нэгэнт тэр олон хүн харж байхад бэлгийг нь авчихсан болохоор тэрхүү ажичны хүсэлтийг биелүүлэхгүй байж болдоггүй. Тэгэхгүй бол хүмүүс түүнийг хүний бэлэг авчихаад хариу тусалдаггүй юм билээ гэлцэх болно.

Хятадад зарим нөхцөлд заавал гар цайлгах ёстой байх төдийгүй энэ нь легитим (зүй ёсны) арга зам байдаг. Жишээлбэл албан тушаал дэвших, зарим хүнс, бараа олж авах, сайн сургуульд орох тухайтад заавал гар цайлгах ёстой. Янгийн өгүүлэлд “Дундадын үндэсний уламжлалд хахууль ба гуаньсидах урлагийн хооронд нарийн ялгаа бий шүү” гэжээ (Yang 1989:48). Тэрээр нэгэн нийтлэлдээ: “гуаньсидах урлагийг орчин цагийн өрнөдийн авлига гэгчийн хэмжээнд доогуур үнэлэн ухаарч болохгүй. Гуаньсийн харилцан үүрэг хүлээх, өргүй байх, хариу барилцах хувийн харилцаа нь материаллаг солилцоонос дутахгүй чухал хүчин зүйл юм” гэжээ (Yang 1994:108). Тэрээр зан үйлүүдийг соёл уламжлал талаас нь авч үзэхэд хувийн харилцааны урт удаан үргэлжлэх хугацаа ба харилцааны

чанар чухал гэж үзэж байна. Судлаачийн үзэж байгаагаар хятадууд өгөлцөж авалцах дээрээ ойр харилцаагүй хүнийг ойр харилцаатай хүнээс ялгамжаатай үздэг.

“АНУ-д сурч буй хятад бүсгүй үндэсний сэтгэлгээнд нь авлига, хахууль ба гуансийн урлагийн хооронд оршиж буй ялгааг маш тодорхой илэрхийлсэн байна. Түүний хувьд авлига ба хахууль нь сөрөт утгатай доромж үг юм. Харин гуаньсисүэ болбоос “хүн чанарыг” илэрхийлэх агаад андын ёс, урт хугацааны нөхөрлөл, харилцан туслалцах үйлсийг төлөөлдөг. Тиймээс хахуульд байдаггүй сайн тал гуаньсид байdag аж. Жишээлбэл, аль нэг албан тушаалтан Тантай урьдын хувийн харилцаатай биш, тухайлбал нэг нутаг эсвэл садан төрөл биш атлаа Танд туслаадахвал лавтай хахууль өгч, авалцсан байна гэж хүмүүс хардана.”

Тийхүү гуаньсийн талаар дотор хүмүүс өөр өөрийн, хоёрдмол, эрс тэс ойлголттой байх ч дийлэнхдээ үүнийг өдөр тутмын амьдрах ухааны урлаг гэж үздэг байна. Гэхдээ албан бус сувгаар хэрэгтэй зүйлээ бүрэн эрхтэй олж авахын тулд оролцогч талууд угаас харилцаатай хүмүүс байх учиртай.

### 5.5.2 Андын сүлжээний сэтгэлгээ (The logics of solidarity network)

Барнс (Barnes) сүлжээ гэх ойлголтыг 1954 онд антропологийн шинжлэх ухаанд оруулснаас хойш хүн судлалынхан олон янзын орчин нөхцөлд хүмүүс бие биедээ хамаарах харилцааны хэлбэрүүдийг энэ нэр томъёогоор илэрхийлэх болсон юм.

Сүлжээний ойлголт Бангладешийн нөхцөлд онц тохиромжтой. Энэ улсад хүмүүс бусадтай өргөн хүрээний хэлхээ холбоотой болохын төлөө чармайж амьдардаг (Sissener 1999). Бангладеш эрчүүд шөнө дөл болтол гадаа сууцгааж,

тамхилалцаж, цай ууж, анхилуун навч зажлан хөөрөлдөж, нөхөрлөлөө бэхжүүлэх, өргөжүүлэхийг хичээдэг. Ярьж байгаа зүйл нь ач холбогдолгүй чалчицааж байгаа мэт боловч бас ч хүү харилцан биеийнхээ тухай улам ихийг мэдэж авдаг байна.

Зах дээр ч юм уу, багахан суурин газрын иймэрхүү цугларалтын үеэр бизнес наймаа хэлэлцэж, зээл өгөлцөж, шинэ танилтай болж, харицлан хүндлэл үзүүлж, мэдээлэл солилцно.

Лукас гэдэг залуу нутгийнхаа бяцхан хотод очсон байхдаа нэгэн үдэш албан тушаалаа алдаж болзошгүй байгаа тухайгаа хүнээс дуулжээ. Хэдэн сарын өмнөөс тэрээр олон улсын төрийн бус байгууллагын орон нутгийн салбарт дээгүүр албан тушаал хаших болсон юм. Нийслэл Дакка дахь төв байгууллага нь орон нутгийн салбарын нь захирлын саналаар түүнийг Дакка хотод доогуур албан тушаалд тавих шийдвэр гаргаж байгаа шүү гэж нэг найз нь хэлжээ.

Өглөө нь Лукасыг орон нутгийн салбарын захирал нь дуудаж, ажлын гүйцэтгэлд нь сэтгэл дундуур байгаа тул Дакка руу шилжүүлэх санал тавьсан тухайгаа хэлсэн байна. Лукас яагаад дарга нь гэнэт ажилд нь сэтгэл дундуур байх болов гэдэг талаар илүү мэдээлэл олж авахаар шийдлээ. Лукас хорь шахам жил тэр салбарт ажилласны эцэст орон нутгийн салбарын хоёр дахь том албан тушаалд томилогдсон юм. Тиймээс дарга нь түүний ажлыг үнэлэхгүй байх ямар ч учир байх ёсгүй гэж тэр үзэж байв.

Лукасын найз нь Дакка дахь төв байгууллагад туслах захирал байгаад Их Британд дэд докторын сургалтад явсан юм. Тэр найз нь судалгааны ажлынхаа талбарыг сонгохоор Бангладешт ирсэн байв. Лукас нэгэн үдэш түүнтэй уулзаад өглөө нь түүнтэй хамт тосгодоор явалцаж туслахаар

болов. Ингэснээр найзтайтаа ажлынхаа талаар ярилцах боломж нээгдлээ. Нөхцөл байдлыг найздаа ярьсны дараа найзыгаа салбарын захиралтай уулзаж, яагаад түүнийг өөр ажилд шилжүүлэх гээд байгааг нь асуугаад өгөхийг гуялаа.

Дараагийн удаа уулзахдаа найз нь салбарын захирлын хэлснийг Лукаст ярив. Лукас найзыгаа Дакка дахь захиралтай уулзаж, түүнийг шилжүүлэх шаардлага байхгүй гээд хэлээд өгөөч гэж гуйв. Харин найз нь одоо нэгэнт тэнд ажиллахгүй байгаа учраас асуудалд нөлөөлж чадахгүй гэдгээ хэллээ. Мөнхүү найздаа туслах хүсэлтай байсан ч төгсөж ирээд дахин туслах захирлаар ажиллах боломжко алдах вий гэж айсан байна. Тиймээс Лукасыг өөрөө Дакkad очоод холбогдох хүмүүстэй яриад үз гэж зөвлөв. Тухайллан хэнтэй уулзахыг нь нэр зааж хэлж өгөв.

Дакка руу явахын өмнө Лукас салбарынхаа хуучин захирал байсан найзаасаа зөвлөгөө авахаар очив. Тэр найз нь Лукастай нэг ястан тул туслах байх гэж бодов. Гэтэл тэр найз нь Дакка дахь удирдлагуудтайгаа хувийн асуудлаар зөрчилтэй байснаас ажлаасаа гарсан болж таарлаа. Тиймээс тусалж чадах ямар ч найдваргүй аж. Дакkad ирээд Лукас мөн тэр байгууллагад ажилладаг хамаатныдаа буув. Харамсалтай тэр хамаатан нь доогуур албан тушаал хашдаг тул холбогдох хүмүүсийн шийвэрт нөлөөлж үл чадах нэгэн байлаа. Дакkad хүн хартай уулзан хэд хоноходоо Лукас яаж ч чадахгүй гэдгээ ойлголоо.

Лукас салбartaа эргэж ирээд дахин захиралтайгаа уулзаж, бодлыг нь өөрчлөх арга сүвэгчлэхээр болов. Эцэст нь Лукас бүр ажлаасаа гарахад хурсэн бөгөөд чингэхдээ хэрэгтэй хүмүүстэй нөхөрлөөгүй, нөхөрлөх боломж олдоогүйн гайгаар асуудлыг эргүүлэх ямар ч боломжгүй байснаа ухаарсан юм.

Лукас орон нутгийн салбар дахь ажлын байраа алдах нь гэдгээ мэдээд тухайн орон нутаг дахь өөр байгууллагын найз нартайгаа уулзав. Ингээд өөрт нь тохирох сул орон тоо байгааг мэджээ. Нэг найз нь боловсон хүчин хариуцсан нэг хүнийг таньдаг тул түүнд Лукасыг санал болгожээ. Хэдэн жилийн өмнө энэ найз нь одоогийн хийж байгаа ажилдаа орохоор өргөдөл өгөхөд Лукас тэндхийн зөвлөлд тэр найзыгаа хэлж өгч ажилд оруулж байсан аж.

Бангладешт ураг төрөл, найз нөхөд, хөрш саахалт сэлтүүд харилцан биендээ тусалж байх нийтлэг үүрэгтэй байдаг аж. Энэ хүрээнийхээ хүмүүст туслах, харж үзэхээс татгалзвал үр дагавар хөнгөнгүй л аж. Лукас Дакка шилжих болсноо мэдмэгц би тэнд таних хүн цөөтэй тул тийшээ явах боломжгүй гэж байсан байна.

Найз нарын тодорхой зорилго бүхий сүлжээ, жишээлбэл бие биедээ хүүгүй мөнгө зээлдүүлдэг, хамтарч бизнес хийдэг сүлжээ ямар чухал байдаг нь угсаатны зүйн судалгаагаар батлагддаг (cf. Sissener 1999). Хүмүүс он жилээр танилын сүлжээгээ бүрдүүлдэг агаад ураг төрөл, найз нөхөд, айл хөршүүдээсээ гүн хамааралтай амьдардаг байна. Ийм нөхцөлд андын сүлжээгээ ашиглах нь өдөр тутмын үйл амьдралын амин чухал бөгөөд зүй ёсны арга юм. Хэрэв тодорхой тохиолдолд Танаас өөр хүн андын сүлжээгээрээ давуу байдал олсон бол тэр хүний буруу биш, Таны л хохь гэж узнэ.

Оросод дээрхтэй төсөөтэй блат гэгч ойлголт байдаг нь “ховор бараа үйлчилгээ олж авах, албан ёсны дүрэм журмыг тойрч ажлаа бүтээхдээ хувийн танилын сүлжээгээ ашиглахыг” хэлнэ (Ledeneva 1998:1). Блат гэгчийн Алёна В. Леденёва оролцогчдын харилцан ашиг тустай байдал, андын буюу садан төрлийн холбоо нь харицлан

туслах үүргийг бий болгодог, дарга нь ажилтнуудаа харж үзэх байдлаар нэр хүндээ өсгөх төрөл хэлбэрүүдэд ялгаж өгсөн байна. Леденёвагийн судалгаа тавин нарийвчилсан ярилцлагад тулгуурласан байна.

Ярилцлага өгсөн нэгэн оролцогч блатыг дараах байдлаар тайлбарласан байна. “Ээж маань сангийн аж ахуйн агуулахад ажилладаг байлаа. Маш сайн махыг хямд үнээр зардаг, бас ховор хүнсний бүтээгдэхүүн зардаг байсан. Цөцгийн тос тасарсан үед цөцгийн тос олж чаддаг байсан. Ер нь танил сайтай, хувцасны дэлгүүрийн худалдагч нартай их ходий байсан.

Аав маань насаараа барилга дээр ажилласан, барилгын материал ч эрэлт ихтэй байсан. Аав тэтгэвэрт гараад хий борлуулах ажил хийдэг болсон. Ээж сайн мах зардаг болохоор хотын хий хангамжийн хүмүүс авд том хийн сав өгдөг байсан. Аав бас машиндаа ч арын хаалгаар (по блату) шатахуун авдаг байсан. Шатахуун тээврийн жолооч нарыг таньдаг байсан болохоор хэзээ л бол хэзээ шатахуунаа авдаг, ихэвчлэн шил архи, эсвэл гэрийн нэрмэлээр авна. Тэгээд бодохоор үнэгүй ч авч байгаагүй л юм байна л даа, гэхдээ цаадуул нь хэн дуртай хүн бүрт шатахуун өгөөд байхгүй шүү дээ. Зөвхөн итгэдэг хүндээ л өгнө. Ингэж авах нь хямдаас гадна, бас оочерлохгүй.

Ээж тосгоны махны зоорины няравыг сайн таньдаг байсан. Жил бүр амралтад явахдаа түүнд агуулахaa харуулдаг байсан. Тэр итгэл алдахгүй гэдгийг ээж мэдэж байсан учраас тэгдэг байсан. Харин цаадах нь ээжээс зөндөө мах худалдаж авч байхын тулд зөвшөөрдөг байсан.

Аав ч гэсэн ахын зуслангийн байшинг барихад тусалсан. Байшин барихад ямар их мөнгө ордог гэж санана? Гэхдээ

ахаас бараг мөнгө гараагүй. Танилууд, хуучин танилууд аа гэж. Танилууд нь үнэгүй ч юм уу эсвэл хэдхэн копейкоор мод буулгаж өгсөн. Шанд нь харин шинэ ондөг, бууц өгсөн.”

Леденёвагийн (Ledeneva 1998) ажигласнаар блатаар ховор бараа үйлчилгээ олж авах нь зүй ёсны үйлдэл болдог байна. Тэрээр ярилцлагад оролцогдын ярианд үндэслэн хахууль ба блатын ялгааг тодорхойлсон байна. Үүнд: “Блат тодорхой хүрээнд үйлчилдгээрээ хахуулиас ялгаатай. Блатын үйлчилгээг зөвхөн өөрийн гэсэн (своим) хүнд л үзүүлнэ. Ийм урт хугацааны хэлхээ харилцаатай хүнээ бол ямар ч байдлаар харж үзэж болох юм” гэжээ. Ийнхүү блатын хувьд гуаньситай адил хувийн харилцаа холбоо онц ач холбогдолтой байна. Нэгэн оролцогч энэ асуудлыг дараах байдлаар илэрхийлсэн байна:

“Блатад хувийн нэр нүүр чухал, мөнгө оролцдоггүй. Хүмүүс хэн нэгнийг харж үзэхдээ эргээд өөрийг нь харж үзнэ гэж найддаг. Мөн “мөнгө хэрэггүй ээ, би чамд нөхөр ёсоор л тусалж байна, найзын хооронд тооцоо байхгүй ээ, би ч чам шиг гачигдалд орох юм билүү, хожим ачийг минь хариулна биз” гэсэн санаа агуулагддаг”.

Ямар ч асуудлыг блатаар шийдэж болдог ба хахуулийг бүүр арга тасрахад хэрэглэнэ. Леденёва Эрүүгийн хуульд хахуулийг хууль бус гэж заасан атлаа блатыг огт дурдаагүй гэдгийг тэмдэглэсэн байна. Гэлээ гээд хахууль блат хоёрын зааг маш бүдэг, зарим хэсгээрээ давхцаж байдаг.

Ийнхүү танилын сүлжээн дэх зарим хэлхээ нь блатын хэлхээ, гарим зарим нь мөнгө төлөхөөс нааш хөдлөхгүй хэлхээ байна. Блат хахууль болж хувирах буюу хахуульд зуучлах цэг дээр эрх зүйн асуудал үүсэж болох ч бас эргэлзээ төрнө. Авлига, хахуулийн эсрэг тэмцэл

тэр бүр үр дүнгүй байгаа нэг шалтгаан нь энэ юм. Хууль зөвхөн хахууль өгөгч-авагчийн хэлхээг л онылсноос блатын сүлжээг үл хамарч байна.

Эдгээр нь өдөр тутмын зан үйлийг нөхцөлүүлэгч олдмол зуршил, нийтлэг үйлдлийн цөөн жишээ юм. Танилууд бэлэг өгөлцөх, хэрэгтэй зүйлээ андын сүлжээгээр дамжуулан олж авах нь танихгүй хүмүүс шууд хахууль өгөлцөхөөс ялгаатай харагддаг байна. Мөнгө өгсөн байлаа ч энэ нь танилын хэлхээ холбооны дэргэд хоёрдогч асуудал юм. Мөн нэг талаас блат болон гуаньси, нөгөө талаас хахуулийн зааг ялгаа будэг нимгэн байна.

Авлигыг хүн судлалын аргачлал, байр сууринаас авч үзсэн судалгааны энэхүү тоймоор авлигыг “соёл уламжлал, үндэсний сэтгэлгээ” нэрийн дор хаацайлах гэсэн юм биш, харин зүй ёсны гэж төсөөлөгдөх үзэгдэл, зан үйлийн зааг хязгаар газар газарт адил байдаггүй, хүн бурийн оюун санаанд нэг мөр ижил тусдаггүй юм байна гэдгийг харуулах гэсэн билээ. Тухайн үйлдлийг оролцогч талууд нь буруу гэж ухаараагүй цагт ямар ч шинэчлэл хэрэгжүүлэх хэцүү байх болов уу. Авлигын эсрэг бодлогод үүнийг тооцох зүйтэй болов уу.

## 5.6 Дүгнэлт (Concluding remarks)

Авлига бол судлаачид, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд ялгаатай, зөрчилтэй, салаа утгатай ойлгогддог үзэгдэл аж. Ийм хоёрдмол байдлаас улбаалан юу нь авлига юм бэ, юу нь авлига биш юм бэ гэдгийг нийтгийн ба соёл уламжлалын өргөн хүрээнд ойлгох боломжтой.

Антрапологчид ч бас авлигыг илүү өргөн хүрээгээр ойлгох хэрэгтэй гэж үзэж байна. Авлигын уламжлалт тодорхойлолт хэт явцуу бөгөөд эрх зүйн талд нь дэндүү анхаарсныг тэд дурдаад, илүү нээлттэй аргачлалаар судлах ёстой гэж үзжээ. Антрапологид хүмүүсийн үйл, үйлдлийн талаарх үнэлэлт, ойлголтод дүн шинжилгээ хийхэд тохирох арга хэрэгслийн багц бий. Бид эдгээр арга, аргачлалыг хэрэглэснээр юу нь авлига юм бэ, юу нь авлига биш вэ гэдгийг тухайн үйлд оролцогчдын байр сууринаас харах боломжтой.

Дэлхийн өнцөг булан бүрт авлига ихээхэн сэтгэл түгшээсэн асуудал, өдөр тутмын ярианы сэдэв болж байдаг билээ.

# **ЗАСАГЛАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ<sup>34</sup>**

## **Үргэлжлэл**

Засаглал (Governance)-тай холбоотой асуудлаар судалгаа шинжилгээний болон орчуултын ажил хийж буй хүмүүст тус болох үүднээс НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газрын ажилтан Ц.Даваадуламын гаргасан “Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны Англи-Монгол тайлбарыг цуврааар хүргэж байна.

<b>BUILD-OPERATE-TRANSFER (BOT)</b>  An arrangement, whereby the private operator finances the construction, recoups the investment through an exclusive concession, and transfers the assets to the government at the end of the period. (Schiavo & Sundaram, 2000)	<b>БАРЬЖ БАЙГУУЛАХ-АЖИЛЛУУЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ</b>  Хувийн хэвшлийн байгууллага аливаа нэг объектийн барилгын ажлыг санхүүжүүлж, тусгай хөнгөлөлттэй нөхцөлөөр ажиллуулж хөрөнгө оруулалтаа нөхсөний дараагаар түүний өмчлөлийг застийн газарт шилжүүлэн өгөх ажиллагаа. (Шиаво & Сундарам, 2000)
<b>BUREAUCRACY</b>  The word ‘bureaucracy’ itself stems from the word ‘bureau’, used from the early 18th century in Western Europe to refer to an office, a workplace where officials worked, a writing desk. The Greek suffix - <i>kratia</i> or <i>kratos</i> - means ‘power’ or ‘rule’.  The modern meaning of bureaucracy implies the structure and set of regulations in place to control activity, usually in large organizations and government. It is characterised by standardized procedure (rule-following) that dictates the execution of most or all processes within the organization, formal division of power, exercise of authority through a vertical hierarchy (chain of command), job specification with no functional overlap and record keeping. Bureaucracy is also a general term used to refer to the public service - the administrative branch of government.	<b>БЮРОКРАТ ТОГТОЛЦОО</b>  'Bureaucracy' гэдэг үг анх 18-р зууны эхнээс Баруун европын орнуудад албан газар, офис, албан тасалгаа, бичтийн ширээг нэрлэдэг 'бюро' гэдэг үгнээс үүсч дараа нь – <i>kratia</i> , <i>kratos</i> – гэсэн 'эрх мэдэл', 'захирах' гэсэн утгатай грек дагавар залган хэрэглэгдэх болжээ. Тус нэр томьёоны орчин үеийн утга нь гол төлөв том хэмжээний болон застийн газрын байгууллагуудад үйл ажиллагааг хянах зорилгоор бий болгосон бүтэц, дүрэм журмын нэгдлийг илэрхийлдэг байна. Түүний онцлог шинж нь байгууллагын үйл ажиллагааг тогтсон дүрэм журмын дагуу явуулах, эрх мэдлийг албан ёсоор хуваарилж босоо шатлалын дагуу хэрэгжүүлэх (шатлан захирах ёс), чиг үүргийн давхардалгүйгээр ажил үүргийг тодорхойлох, албан хэргийг бичгээр хөтөлж хадгалах зэрэг болно. “Бюрократ тогтолцоо” нь мөн төрийн алба, түүний дотор төрийн захиргааны

<sup>34</sup> “Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг” 2010 он

<p>However, the term ‘bureaucrat’ today has largely accepted negative connotations, so those who are the members of a governmental bureaucracy usually prefer terms such as civil servant or public servant to describe their jobs.</p>	<p>албыг нийтээр нэрлэдэг нэр томьёо юм. Гэхдээ өнөө уед “бюрократ” гэсэн үгийг сөрөг утгаар нь хүлээн авах түгээмэл болсон учраас засгийн газрын бюрократ тогтолцоонд ажиллагчид ‘төрийн албан хаагч’ хэмээх нэр томьёог илүүд үзэх болсон байна.</p>
<p><b>BUREAUCRAT</b></p> <p>An official or manager in a bureaucracy. The pure type of bureaucrat is appointed by a superior authority. They follow a career within the hierarchical order of the public service. They move from the lower, less important and lower paid positions to the higher positions. ‘Tenure for life’ is characteristic for bureaucrats.</p>	<p><b>БЮРОКРАТ (ТӨРИЙН АЛБАН ХААГЧ)</b></p> <p>Бюрократ тогтолцоон дахь гүйцэтгэх болон удирдах албан тушаалтан. Төрийн жинхэнэ албан хаагчид дээд шатны албан тушаалтны шийдвэрээр томилогдоно. Тэд төрийн албаны албан тушаалын зэрэглэлийн дагуу доод түвшний болон чухал бус албан тушаалаас эхлэн дээд түвшний албан тушаал хүртэл дэвшиш ажиллаш болно. Төрийн албанад урт хугацаагаар тогтвортой ажиллах нь бюрократын нэг шинж чанар юм.</p>
<p><b>CABINET</b></p> <p>Collective of ministers chaired by the Prime Minister that makes government policy decisions. It is the top-decision making body in the executive arm of government. The agenda for the Cabinet meetings is prepared by the Office of the Prime Minister and approved by the Prime Minister. Members of Cabinet take collective and individual responsibility for their joint decisions, as well as for the decisions that are taken in their name and the measures that they propose. Cabinet decisions are implemented by ministers through departments or other agencies for which they are responsible. (UNDP LAO, 2001)</p>	<p><b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТАНХИМ</b></p> <p>Ерөнхий сайдын тэргүүлсэн, засгийн газрын бодлогын шийдвэрийг гаргадаг сайд нарын хамтын байгууллага. Энэ нь төр засгийн гүйцэтгэх салааны шийдвэр гаргах хамгийн дээд байгууллага юм. Засгийн газрын хуралдааны хөтөлбөрийг ерөнхий сайдын алба (манайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар) гаргаж ерөнхий сайд баталдаг. Танхимын хамтын шийдвэр болон тэдний нэрийн өмнөөс гаргасан аливаа шийдвэр, санал болгосон арга хэмжээний төлөө танхимын гишүүд хамтын болон хувийн хариуцлага хүлээдэг. Танхимын шийдвэрийг сайд нар хариуцсан яам, агентлагаар дамжуулан хэрэгжүүлдэг. (НУБХХ/Лаос, 2001)</p>
<p><b>CABINET SECRETARIAT</b></p> <p>The office that supports the cabinet has a particular role in ensuring that the rules of debate are credible and efficient, and that there is a realistic prospect of agreement. (Schiavo &amp; Sundaram, 2000)</p>	<p><b>ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР</b></p> <p>Засгийн газрын танхимд дэмжлэг үзүүлэх, түүний хэлэлцүүлгийг хууль ёсны дагуу, түргэн шуурхай явуулах, зөвшшилцэлд хүрэх бодит боломжийг хангах тусгай үүрэгтэй байгууллага. (Шиаво &amp; Сундарам, 2000)</p>

<p><b>CAPACITY</b></p> <p>Describes the ability to solve problems, perform functions, and set and achieve objectives. Capacities exist at individual, social and institutional levels. (UNDP, 2005)</p>	<p><b>ЧАДАВХИ</b></p> <p>Асуудлыг шийдвэрлэх, ажил үүрэг гүйцэтгэх, зорилгоо тодорхойлох, түүнд хүрэх чадвар. Чадавхи хувь хүн, нийгэм, байгууллагын түвшинд оршдог. (НУБХХ, 2005)</p>
<p><b>CAPACITY BUILDING</b></p> <p>Capacity building is understood in its narrow sense as training and the term has been applied to <i>any</i> change that affects administrative organization or had an institutional dimension. Capacity building has four components:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Institutional development, i.e., a move from a less efficient to a more efficient set of rules and incentives, as reflected and measured by a</li> <li>• Reduction in transaction costs within the sector;</li> <li>• Organizational development, i.e., adaptation of the organizational structure to the more efficient rules, and/or rationalization of functions and responsibilities;</li> <li>• Human resource development by formation of sector-relevant skills, i.e., training ; and</li> <li>• Informatics development, i.e., the judicious introduction of information and communication technology. (Schiaovo &amp; Sundaram, 2000)</li> </ul>	<p><b>ЧАДАВХИ БИЙ БОЛГОХ</b></p> <p>Явцуу утгаар сургалт, өргөн утгаар захиргааны зохион байгуулалтад нөлөөтэй, институцийн шинжтэй аливаа өөрчлөлтийг ойлгодог. Чадавхи бий болгох дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Институцийн хөгжил – үр ашиг багатай дүрэм журмаас үр ашигтай дүрэм журам руу шилжих, энэ нь тухайн салбар дахь зардал буурсан эсэхээр хэмжигдэнэ;</li> <li>• Байгууллагын хөгжил – үр ашигтай дүрэм журамд зохицуулан байгууллагын бүтцийг өөрчлөх, чиг үүрэг, хариуцлагыг оновчтой болгох;</li> <li>• Хүний нөөцийн хөгжил – сургалт явуулах зэргээр тухайн салбарт шаардлагатай ур чадвар бий болгох;</li> <li>• Мэдээллийн технологийн хөгжил – мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх болно. (Шиаво &amp; Сундарам, 2000)</li> </ul>
<p><b>CENTRALIZATION</b></p> <p>Centralization is the concentration of authority or responsibility for a function in a single office within an organization or a single organization within a sector or institution. Process by which government services, power (budgeting, taxation, policy, etc.) are carried out at the central or national level of government. The retention of decision-making authority and responsibility in the upper echelons of an organization.</p>	<p><b>ТӨВЛӨРӨЛ</b></p> <p>Аливаа чиг үүргийн талаархи хариуцлага, эрх мэдэл тухайн байгууллагын нэг нэгж юмуу, эсвэл тухайн салбарын нэг байгууллагад төвлөрөх. Төрийн бүх үйлчилгээ, эрх мэдлийг (төсөв, татвар, бодлого г.м.) застгийн газрын төв, эсвэл үндэсний түвшин хэрэгжүүлэх үйл явц. Шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлагыг байгууллагын дээд шатанд барих.</p>

<p><b>CHECKS AND BALANCES</b></p> <p>Power is divided among three branches of the government (legislature, executive, judiciary), each of which checks – that is, restrains – and balances the others. The branches share certain powers but also exercise some exclusive powers. Such checks and balances are essential to complement the political accountability of the government to the population, which is exercised through periodic elections. (Schiavo &amp; Sundaram, 2000)</p>	<p><b>ХЯНАЛТ ТЭНЦВЭР</b></p> <p>Эрх мэдэл тэр засгийн гурван салаанд (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) хуваагддаг бөгөөд салаа бүр тус тусын эрх, үүргийн дагуу бусад салбарт хяналт тавьж тэнцвэржүүлж байдаг. Ийм хяналт тэнцвэр засгийн газраас иргэдийн өмнө хүлээх, ээлжит сонгуулиар дамжин хэрэгждэг улс төрийн хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. (Шиаво &amp; Сундарам, 2000)</p>
<p><b>CITIZENSHIP</b></p> <p>Citizenship is the condition or status of a citizen, with its rights and duties. Citizenship is the legal relationship between citizens and their government and country. Citizens owe their government loyalty, support, and service. The government owes the citizens the protection of constitutionally guaranteed rights to life, liberty, property, and equal justice under law. Citizenship in a democracy entails serious responsibilities. For example, good citizens in a democracy exhibit civic engagement, which means they are ready, willing, and able to use their constitutionally protected political rights to advance the common good. Citizens are expected to be loyal and patriotic, to assume responsibility for the defence of their country against internal and external threats or attacks. Citizenship also entails certain duties, such as paying taxes, serving on juries when summoned, joining the country's armed forces if drafted, and obeying the laws.</p>	<p><b>ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ</b></p> <p>Иргэний эрх зүйн статусыг түүний эрх, үүрэгтэй хамт тодорхойлсон нэр томъёо. Иргэний харьяалал бол иргэд, тухайн улсын тэр засаг хоорондын эрх зүйн харилцаа юм. Иргэд тэр засагтаа үнэнч байх, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, тэр засаг нь иргэдэд үндсэн хуулиар олгосон амьд явах эрх, эрх чөлөө, өмчлөх эрх, хуулийн өмнө тэгш байх эрхийг хамгаалах үүрэгтэй байдаг. Ардчилсан тогтолцоонд иргэн чухал үүрэг, хариуцлагатай байдаг. Жишээ нь, ардчилсан нийгэмд сайн иргэн байхын тулд үндсэн хуулиар олгосон улс төрийн эрхийг нийтийн сайн сайхны тусын тулд ашиглах, ө.х. нийгмийн амьдралд оролцох бэлтгэл, дур хүсэл, чадвартай байх хэрэгтэй. Иргэд эх орондоо үнэнч байх, дотоод, гадаадын аюул занал тулгарсан нехцэлд эх орноо хамгаалах үүрэгтэй байдаг. Харьят байснаар татвар төлөх, шүүхийн зарлан дуудах авсан тохиолдолд хурэлцэн ирэх, цэргийн алба хаах, хууль сахин биелүүлэх зэрэг тодорхой үүрэг хүлээдэг.</p>
<p><b>CITIZENS' CHARTER</b></p> <p>Citizens' charter is an explicit and public statement of service standards and obligations to serve as a guide for the government agency's behaviour and can vary from a general statement of performance standards to a detailed list of</p>	<p><b>ИРГЭНИЙ ЭРХИЙН ТУНХАГ</b></p> <p>Иргэний эрхийн тунхаг нь засгийн газрын байгууллага үйл ажиллагаандаа удирдамж болгох үйлчилгээний стандарт, хүлээх үүргийг нийтэд тусгайлан зарласан мэдэгдэл бөгөөд энэ нь гүйцэтгэлийн стандартын ерөнхий</p>

<p>rights of citizens. The charter is based on the premise that since citizens contribute to all public services as taxpayers and have basic rights as members of society, they are <i>entitled</i> to public services of a certain degree of quality, responsiveness, and efficiency. (Schiavo &amp; Sundaram, 2000)</p>	<p>тодорхойлолтоос эхлээд иргэний эрхийн дэлгэрэнгүй жагсаалт хуртэл төрөл бурийн хэлбэртэй байдаг. Тунхаг нь иргэд татвар төлөгчийнхөө хувьд төрийн бүх үйлчилгээнд хувь нэмэр оруулж, нийгмийн гишүүний хувьд эдлэх үндсэн эрхийнхээ хүрээнд төрөөс тодорхой чанарын, хөнгөн шуурхай, үр ашигтай үйлчилгээ авах эрхтэй гэсэн санаанд үндэслэсэн байдаг. (Шиаво &amp; Сундарам, 2000)</p>
<p><b>CITIZENS' REPORT CARDS</b></p> <p>A citizen report card is a new way to rate different service providers from a user perspective and to utilize the rating to make the providers more accountable to the people. User feedback is a cost-effective way for a government to find out whether its services are reaching the people, especially the poor. (UN, 2007)</p>	<p><b>ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ</b></p> <p>Төрөл бурийн үйлчилгээнд хэрэглэгчдээр үнэлгээ өгүүлж, түүнийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг иргэдийн өмнө илүү хариуцлага хүлээдэг болгоход ашиглаж байгаа шинэ арга хэрэгсэл. Хэрэглэгчдийн санаа бодлыг судлах нь застийн газрын үйлчилгээ иргэд, түүний дотор ядуу иргэдэд хүрч байгаа эсэх талаар мэдээлэл олж авах өртөг багатай арга зам юм. (НҮБ, 2007)</p>
<p><b>CIVIL SERVICE/ PUBLIC SERVICE</b></p> <p>A body composed of those public servants that are subject to the rules and regulations defined in the Civil Service Statute.</p>	<p><b>ТӨРИЙН АЛБА</b></p> <p>Төрийн албаны тухай хуулиар тогтоосон дүрэм журмаар эрх, үүрэг нь зохицуулагддаг албан хаагчдаас бүрдсэн алба.</p>
<p><b>CIVIL SERVICE COMMISSION</b></p> <p>The mandate of a civil service commission includes administering competitive examinations and selecting the successful candidates according to transparent and objective criteria. The central PSC also enforces the merit principle in promotions and senior appointments; assists the government in recruiting and managing a senior executive service; regulates disciplinary procedure; hears appeals from employees; and is consulted before major penalties for misconduct are assessed. (Schiavo &amp; Sundaram, 2000)</p>	<p><b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</b></p> <p>Төрийн албаны зөвлөлийн эрхлэх ажил нь өрсөлдөөнт шалгалт зохион байгуулах, ил тод, бодитой зарчмын дагуу хүмүүсийг сонгон шалгаруулах болно. Төрийн албаны төв комисс нь мен албан тушаал дэвшиүүлэх, удирдах албан тушаалд томилох явцад мерит зарчмыг мөрдүүлэх; удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах, томилоход застийн газарт туслах; сахилгын дүрэм журмын хэрэгжилтийг зохицуулах; ажиллагчдаас ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх; төрийн албан хаагчдын буруутай үйлдэлд томоохон шийтгэл ногдуулах шийдвэр гаргахын өмнө зөвлөх үүрэгтэй байдаг. (Шиаво &amp; Сундарам, 2000)</p>

<b>CIVIL SERVICE REFORM</b>	<b>ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ</b>
Civil Service reforms establish or adjust the duties, responsibilities and obligations of public employees, pay levels, recruitment procedures, incentives, training and career development rules, and ethical standards. (UN, 2007)	Төрийн албан хаагчдын хийж гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлага, цалингийн хэмжээ, ажилд авах, томилох, урамшуулах, сургах, албан тушаал дэвшиүүлэх журам, ёс зүйн стандарт тогтоох, шинэчлэх асуудлуудыг хамардаг. (НҮБ, 2007)
<b>CIVIL SOCIETY ORGANISATIONS</b>	<b>ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА</b>
<p>“Civil society” fills the space between the individual and the state, and comprises voluntary groups and associations of all kinds—professional, religious, cultural, etc. A strong and active civil society is the foundation for good governance, providing contestability for the government, productive relationships among people, opportunities to influence policy, advocacy for the poor, and mechanisms for participation. Civil society organizations, however, are not necessarily intended to act in the public interest, and also include associations and lobbies formed for sectarian or vested business interests. Civil society organizations can be formal (e.g., trade unions) and governed by codified rules, or informal (e.g., squatters’ associations). (Schiavo &amp; Sundaram, 2000)</p>	<p>“Иргэний нийгэм” нь хувь хүн ба тэр засгийн хоорондхи орон зайд нөхөж байдаг бөгөөд мэргэжлийн, шашны, соёлын гэх мэт төрөл бүрийн сайн дурын бүлэг, холбоодоос бүрддэг. Хүчтэй иргэний нийгэм нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, хүмүүсийн дунд бүтээлч харилцаа бий болгох, бодлогод нөлөөлөх боломж бүрдүүлэх, ядуусын төлөө ухуулга нөлөөллийн ажил хийх, оролцооны механизм бий болгох замаар сайн засаглалын үндсийг тавьж өгдөг. Харин иргэний нийгмийн байгууллага бүр нийтийн ашиг сонирхолд үйлчилдэггүй бөгөөд тэдний дотор шашны, эсвэл бизнесийн явцуу эрх ашгийн төлөө байгуулагдсан эвсэл холбоод, ухуулга нөлөөллийн (лобби) бүлгүүд ч байдаг. Иргэний нийгмийн байгууллагууд нь албан ёсны (үйлдвэрчний эвлэл гэх мэт), тогтсон дүрэм журамтай эсвэл албан бус (шилжин суурьшигчдын холбоо гэх мэт) байж болно. (Шиаво &amp; Сундарам, 2000)</p>

# **JUSTICE**

(Quarterly Publication)

2010 №4(5)

## **ABSTRACTS**

### **1. Self regulation of media: Journalist's code of ethics and media consul.**

Ts.Onon (4-10)

Although journalists have a code of ethics it's unclear who will be responsible for implementing, monitoring. Author offered Media consul – association of mass media.

### **2. Mongolian Investment Policy and it's effectiveness.**

Ch. Ulaan (11-15)

From state budget was spent 2020.9 billion tugrug to the investment last five years. In contrast with previous five years it is more than ten times. Rapidly increasing an amount of state investment requires careful attention for question of effectiveness of Mongolian investment policy.

### **3. Does the Globalization of Anti-corruption Law Help Developing Countries?**

Kevin E. Davis (16-56)

What role do foreign institutions play in combating political corruption in developing countries? This chapter begins by describing the recently developed transnational anti-corruption regime, which encompasses legal instruments ranging from the dedicated multilateral agreements sponsored by the OECD and the United Nations, to the anti-corruption policies of international financial institutions, to components of the international anti-money laundering regime, international norms governing government procurement, and private law norms concerning enforcement of corruptly procured contracts.

### **4. Symposium on Strengthening Global Leadership and Cooperation against Corruption**

Giovanni Gallo (57-64)

Author highlighted importance of United Nations Convention against Corruption. Also he gave attention that the success of the UN anti-corruption Convention will be measured by the ability of States and their leaders to implement the measures to combat corruption. There are some instruments such a preventive work, criminalization and law enforcement, international co-operation, asset recovery and etc.

### **5. Requirement to renew penalty policy and Criminal law reform**

D. Bayarsaikhan (65-72)

Although it passed 8 years, since the adoption of the Criminal Code of Mongolia, there have appeared omissions in the Criminal Code in a number of parts and provi-

sions, thus the need to adjust and remove them has arisen simultaneously. According to the judicial practice, in the last 15 years, 70% of the penalties imposed by the courts are sentences of imprisonment, 45% have been canceled or changed. This has demonstrated the negative tendency regarding this matter. Although the system of Criminal law of Mongolia and Continental law system (civil law) have analogous aspects; the sources, principles, judicial practice are very different. Meanwhile, it is similar to Russian criminal law system in many ways. It is substantial to replace the penalty policy of the criminal law to humanitarian one, extend the types of penalty other than imprisonment, correct and eliminate the omissions in the Criminal Code, improve the effectiveness of the penalty and do reforms in the Criminal Code.

## **6. Research on Corruption A policy oriented survey**

Jens Chr. Andvig and Odd-Helge Fjeldstad, Inge Amundsen, Tone Sissener,  
Tina Soreide (73-84)

This survey, “*Research on Corruption. A Policy Oriented Survey*”, is an overview of contemporary corruption research. The main objective is to present research that is relevant for foreign aid policies to developing countries. Authors have focused on recent academic research. Thus, while a survey of the output of public commissions dealing with corruption would be useful, this is not covered by this study. Moreover, to make the survey accessible for a multidisciplinary audience, the most abstract and technical parts of the literature are presented in a non-technical way, emphasising the intuition behind the models. In spite of its limitations we hope this survey will be considered useful – and used – by researchers, students, development practitioners and aid officials.

## **7. Corruption and (In)security**

Transparency International working paper 04/2008 (85-96)

The threat of foreign invasion is no longer the only concern dominating the security agenda of states. The list of dangers includes the menace posed by non-state actors and terrorist groups as well as broader social, economic and environmental risks. Whether internal or external, these pressures are breeding violence and corruption, undermining state security and destabilising the global system. For security policies to be effective states must recognise and respond to how corruption ignites and magnifies these dangers. In some countries and regions corruption is the *facilitator* of insecurity.

## **8. Glossary of concepts and terms in governance**

Ts. Davaadulam (97-102)

This glossary is first source of concepts and terms in governance translated into Mongolian language. This will be useful for researchers, practitioners, students.